


**БАТЛАВ
САНГИЙН САЙД**



Б.ЖАВХЛАН

**БАТЛАВ.
ХУУЛЬ ЗҮЙ, ДОТООД
ХЭРГИЙН САЙД**



Л.МӨНХБААТАР

2025 оны 08 дугаар сарын 18-ны өдөр

АЖ АХУЙН НЭГЖИЙН ОРЛОГЫН АЛБАН ТАТВАРЫН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ ХУУЛИЙН ТӨСЛИЙН ҮЗЭЛ БАРИМТЛАЛ

Нэг.Хуулийн төсөл боловсруулах болсон үндэслэл, шаардлага

1.1.Хууль зүйн үндэслэл

Монгол Улсын Их Хурлын 2020 оны 52 дугаар тогтоолоор батлагдсан “Алсын хараа-2050” урт хугацааны хөгжлийн бодлогод жижиг, дунд бизнес эрхлэлтийн өрсөлдөх чадварыг дээшлүүлнэ, олон улсад өрсөлдөхүйц бичил, жижиг, дунд бизнес эрхлэх таатай орчин, нөхцөлийг бүрдүүлнэ зэрэг зорилтуудыг дэвшүүлсэн. Уг зорилтуудыг хэрэгжүүлэх хүрээнд “Хөрөнгө оруулалтыг бүрэн дэмжсэн, бизнес эрхлэх таатай орчныг бүрдүүлнэ”, “Олон улсад өрсөлдөх чадвартай бичил, жижиг, дунд бизнес эрхлэгчдийг хөгжүүлж, ажлын байрыг нэмэгдүүлнэ”, “Цахим засаглалын технологийг бүх түвшинд бүрэн хэрэгжүүлж, авлига хүнд сурталгүй төрийн үйлчилгээг төлөвшүүлнэ” гэж тус тус заасан.

Монгол Улсын Их Хурлын 2020 оны 23 дугаар тогтоолоор батлагдсан Монгол Улсыг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэлийн 3.3.2-т “бичил, жижиг, дунд бизнесийг дэмжих орчин бэхжиж, төлөвшинэ”, 4.1.5-д “бизнесийн таатай орчныг бүрдүүлж, иргэдийн худалдан авах чадварыг дээшлүүлнэ” гэж заасан.

Монгол Улсын Их Хурлын 2024 оны 21 дүгээр тогтоолоор батлагдсан Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 3.2.1-д “Татвар, нийгмийн даатгалын шинэчлэл хийх”-ээр заасан бөгөөд энэ хүрээнд татварын орчныг олон улсын стандартад үе шаттайгаар нийцүүлж, цахим татварын тогтолцоог сайжруулах, бизнес эрхлэх эрх зүйн орчныг сайжруулах, бизнес эрхлэгчдийн татварын ачааллыг бууруулах, татварын дэмжлэгүүдийг оновчтой болгож, татварын орчныг сайжруулах, хариуцлагатай татвар төлөгчийг дэмжих зэрэг зорилтуудыг тус тус тусгасан нь хуулийн төслийг боловсруулах хууль зүйн үндэслэл болж байна.

1.2.Практик шаардлага

Татварын багц хуулийн шинэчлэлийн хүрээнд Татварын ерөнхий хууль, Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хууль, Хувь хүний орлогын албан татварын тухай хуулийн төслүүдийг 2019 онд Улсын Их Хурлаас баталж, 2020 оноос

эхлэн хүчин төгөлдөр мөрдөгдөж эхэлсэн. Энэхүү шинэчлэл нь жижиг, дунд бизнесийг дэмжих, татварын үйл ажиллагааг цахимжуулах, олон улсын татварын шинэлэг зарчмуудыг дотоодын хууль тогтоомжид нэвтрүүлэх үндсэн зорилготой байсан.

Гэвч хуулийн шинэчлэлээс хойших зургаан жилийн хугацаанд геополитикийн тогтворгүй нөхцөл байдал үргэлжилж, худалдааны бодлогоос үүдэлтэй тодорхой бус байдал нэмэгдэх, голлох эдийн засгуудын өсөлт удаашрах, инфляцын түвшин өсөх, зээлийн хүү нэмэгдэх, гадаадын хөрөнгө оруулалт буурах зэрэг нийтлэг санхүүгийн хүндрэл, эрсдэлүүд дэлхийн нийгэм, эдийн засгийн төлөвт бий болсон.

Энэ хүрээнд сүүлийн жилүүдэд дэлхийн улс орнууд татварын бодлогоор жижиг, дунд бизнесийн өсөлт, хөгжлийг дэмжихэд чиглэсэн арга хэмжээнүүдийг хэрэгжүүлж байна. Тухайлбал Бүгд Найрамдах Энэтхэг Улс, Канад Улс, Япон Улс зэрэг улс орнууд бизнес эрхлэгчдийн санхүүгийн дарамтыг бууруулах, ажлын байрыг нэмэгдүүлэх, эдийн засгийн өсөлтийг дэмжих зорилгоор жижиг, дунд аж ахуйн нэгжүүдэд татварын таатай нөхцөлийг бүрдүүлж, тэдний татварын ачааллыг бууруулах бодлого хэрэгжүүлсэн байна. Мөн Бүгд Найрамдах Сингапур Улс, Их Британи Умард Ирландын Нэгдсэн Хант Улс, Бүгд Найрамдах Казакстан Улс зэрэг улсууд хөрөнгө оруулалт татах, бизнесийн орчныг сайжруулах, татварын орчныг энгийн, ойлгомжтой болгоход чиглэсэн өөрчлөлтүүдийг хийсэн байна. Эдгээр татварын бодлогын арга хэмжээнүүд нь жижиг, дунд аж ахуйн нэгжүүдийн санхүүгийн тогтвортой байдлыг хангах, өрсөлдөх чадварыг нэмэгдүүлэх, эдийн засгийн өсөлтийг дэмжихэд чухал үүрэг гүйцэтгэж байна.

Татварын хууль тогтоомжуудад шаардлагатай нэмэлт, өөрчлөлтүүдийг оруулах зорилгоор Сангийн яам, татвар, гаалийн байгууллага, Монголын үндэсний худалдаа, аж үйлдвэрийн танхим болон Улсын Их Хурлын Тамгын газар хамтран улс орон даяар давхардсан тоогоор 11,000 гаруй татвар төлөгчийг хамруулсан 150 удаагийн уулзалт, хэлэлцүүлэг зохион байгуулж, 176 мянга орчим саналыг хүлээн авсан. Хэлэлцүүлгийн явцад аж ахуйн нэгжүүдээс нийтлэг байдлаар ирүүлсэн татвар ногдуулах орлогын босго, шатлалыг нэмэгдүүлэх, бизнес эрхлэх татварын орчныг хялбаршуулах, илүү энгийн, ойлгомжтой болгох, бичил, жижиг, дунд аж ахуйн нэгжүүдийг татварын бодлогоор дэмжих зэрэг саналуудыг хуулийн төсөлд тусгах нь зүйтэй байна.

Дээрх бодлого, зорилтуудыг хэрэгжүүлэх, эдийн засгийн өсөлтийг дэмжих, бизнес эрхлэх илүү таатай татварын орчныг бүрдүүлэх, бизнесүүд үйл ажиллагаагаа идэвхжүүлэх, тогтвортой явуулах нөхцөлийг бүрдүүлэх, түүнд дэмжлэг үзүүлэх шаардлага тулгарч буйг харгалзан Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг боловсруулах практик шаардлага үүсэж байна.

Хоёр.Хуулийн төслийн зорилго, ерөнхий бүтэц, зохицуулах харилцаа, хамрах хүрээ

Хуулийн төслийн зорилго нь аж ахуйн нэгжүүд үйл ажиллагаагаа тогтвортой явуулах, идэвхжүүлэх, бичил, жижиг, дунд аж ахуйн нэгжүүдэд чиглэсэн татварын хялбар, таатай орчныг бүрдүүлэх болон татвар төлөгчдөөс ирүүлсэн нийтлэг саналуудыг тусгахад чиглэнэ. Үүнд:

➤ Аж ахуйн нэгжийн орлогын албан татвар ногдуулах босго, шатлалыг өөрчилнө;

➤ Жижиг, дунд аж ахуйн нэгжүүдэд хялбаршуулсан бага татвар бүхий горимд хамрагдах боломжийг нэмэгдүүлнэ;

➤ Аж ахуйн нэгжүүдэд татварын орчныг илүү хялбар, энгийн, уян хатан болгоно;

➤ Татварын хууль тогтоомжийн хэрэгжилттэй холбоотойгоор татвар төлөгчдөд үүсдэг тодорхойгүй, маргаантай асуудлуудыг зохицуулна;

➤ Аж ахуйн нэгжүүд үйл ажиллагаагаа тогтвортой явуулах, хүний нөөцөө дэмжих, хуримтлал үүсгэх нөхцөлийг бүрдүүлэн, бизнесийн өргөжих, тэлэх боломжийг нэмэгдүүлнэ.

Гурав.Хуулийн төсөл батлагдсаны дараа үүсэж болох эдийн засаг, нийгэм, хууль зүйн үр дагавар, тэдгээрийг шийдвэрлэх талаар авч хэрэгжүүлэх арга хэмжээний талаар

Хуулийн төсөл батлагдсанаар Монгол Улсын бизнесийн орчны олон улсын тавцанд өрсөлдөх чадвар сайжирч, бизнес эрхлэгчдийн татварын ачааллыг бууруулах бөгөөд энэ нь эдийн засгийн өсөлтийг дэмжих, нийгмийн тогтвортой байдлыг бэхжүүлэх суурь нөхцөлийг бүрдүүлнэ.

Түүнчлэн аж ахуйн нэгжүүд үйл ажиллагаагаа тогтвортой явуулах, өргөжүүлэн хөгжүүлэх, санхүүгийн чадавхаа бэхжүүлэх, бизнесийн идэвхээ нэмэгдүүлж дотоод, гадаад зах зээлд өрсөлдөх боломжийг нэмэгдүүлнэ.

Цаашид хиймэл оюун ухаан, их өгөгдөлд суурилсан шийдлүүдийг татварын удирдлагад нэвтрүүлэх замаар татвар төлөгчид шаардлагатай мэдээллийг шуурхай, хүртээмжтэй авах боломжтой болох бөгөөд татварын хууль тогтоомжийн хэрэгжилтийг сайжруулж, зөрчлийг урьдчилан сэргийлэх нөхцөл бүрдэнэ. Энэ нь Монгол Улсад үйл ажиллагаа явуулж буй аж ахуйн нэгж, хөрөнгө оруулагчдын тогтвортой хөгжилд эерэг нөлөө үзүүлнэ.

Дөрөв.Хуулийн төсөл нь Монгол Улсын Үндсэн хууль, Монгол Улсын олон улсын гэрээ болон бусад хуультай хэрхэн уялдах, хуулийг хэрэгжүүлэхэд шинээр боловсруулах, хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах, хүчингүй болсонд тооцох тухай хууль тогтоомжийн төслийн талаар

Хуулийн төслийг Монгол Улсын Үндсэн хууль, Монгол Улсын олон улсын гэрээ болон бусад хуультай нийцүүлэн боловсруулах бөгөөд Мэргэжлийн болон техникийн боловсрол, сургалтын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг боловсруулна.

---o0o---

ТАНИЛЦУУЛГА

*Аж ахуйн нэгжийн орлогын албан
татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт
оруулах тухай*

Монгол Улсын Их Хурлын 2020 оны 52 дугаар тогтоолоор батлагдсан “Алсын хараа-2050” урт хугацааны хөгжлийн бодлогод жижиг, дунд бизнес эрхлэлтийн өрсөлдөх чадварыг дээшлүүлнэ, олон улсад өрсөлдөхүйц бичил, жижиг, дунд бизнес эрхлэх таатай орчин, нөхцөлийг бүрдүүлнэ зэрэг зорилтуудыг дэвшүүлсэн. Уг зорилтуудыг хэрэгжүүлэх хүрээнд “Хөрөнгө оруулалтыг бүрэн дэмжсэн, бизнес эрхлэх таатай орчныг бүрдүүлнэ”, “Олон улсад өрсөлдөх чадвартай бичил, жижиг, дунд бизнес эрхлэгчдийг хөгжүүлж, ажлын байрыг нэмэгдүүлнэ”, “Цахим засаглалын технологийг бүх түвшинд бүрэн хэрэгжүүлж, авлига хүнд сурталгүй төрийн үйлчилгээг төлөвшүүлнэ” гэж тус тус заасан.

Монгол Улсын Их Хурлын 2020 оны 23 дугаар тогтоолоор батлагдсан Монгол Улсыг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэлийн 3.3.2-т “бичил, жижиг, дунд бизнесийг дэмжих орчин бэхжиж, төлөвшинө”, 4.1.5-д “бизнесийн таатай орчныг бүрдүүлж, иргэдийн худалдан авах чадварыг дээшлүүлнэ” гэж тус тус заасан.

Монгол Улсын Их Хурлын 2024 оны 21 дүгээр тогтоолоор батлагдсан Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 3.2.1-д “Татвар, нийгмийн даатгалын шинэчлэл хийх”-ээр заасан бөгөөд энэ хүрээнд татварын орчныг олон улсын стандартад үе шаттайгаар нийцүүлж, цахим татварын тогтолцоог сайжруулах, бизнес эрхлэх эрх зүйн орчныг сайжруулах, бизнес эрхлэгчдийн татварын ачааллыг бууруулах, татварын дэмжлэгүүдийг оновчтой болгож, татварын орчныг сайжруулах, хариуцлагатай татвар төлөгчийг дэмжих зэрэг зорилтуудыг тус тус тусгасан нь хуулийн төслийг боловсруулах хууль зүйн үндэслэл болж байна.

Татварын багц хуулийн шинэчлэлийн хүрээнд Татварын ерөнхий хууль, Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хууль, Хувь хүний орлогын албан татварын тухай хуулийн төслүүдийг 2019 онд Улсын Их Хурлаас баталж, 2020 оноос эхлэн хүчин төгөлдөр мөрдөгдөж эхэлсэн. Энэхүү шинэчлэл нь жижиг, дунд бизнесийг дэмжих, татварын үйл ажиллагааг цахимжуулах, олон улсын татварын шинэлэг зарчмуудыг дотоодын хууль тогтоомжид нэвтрүүлэх үндсэн зорилготой байсан. Гэсэн хэдий ч хуулийн шинэчлэлээс хойших зургаан жилийн хугацаанд геополитикийн тогтворгүй нөхцөл байдал үргэлжилж, худалдааны бодлогоос үүдэлтэй тодорхой бус байдал нэмэгдэх, голлох эдийн засгуудын өсөлт удаашрах, инфляцын түвшин өсөх, зээлийн хүү нэмэгдэх, гадаадын хөрөнгө оруулалт буурах зэрэг нийтлэг санхүүгийн хүндрэл, эрсдэлүүд дэлхийн нийгэм, эдийн засгийн төлөвт бий болсон.

Энэ хүрээнд дэлхийн улс орнууд татварын бодлогоор жижиг, дунд бизнесийн өсөлт, хөгжлийг дэмжихэд чиглэсэн арга хэмжээнүүдийг хэрэгжүүлж байна. Тухайлбал, Бүгд Найрамдах Энэтхэг Улс, Канад Улс, Япон Улс зэрэг улс орнууд бизнес эрхлэгчдийн санхүүгийн дарамтыг бууруулах, ажлын байрыг нэмэгдүүлэх, эдийн засгийн өсөлтийг дэмжих зорилгоор жижиг, дунд аж ахуйн нэгжүүдэд татварын таатай нөхцөлийг бүрдүүлж, тэдний татварын ачааллыг бууруулах бодлого хэрэгжүүлсэн байна. Мөн Бүгд Найрамдах Сингапур Улс, Их Британи

Умард Ирландын Нэгдсэн Хант Улс, Бүгд Найрамдах Казакстан Улс зэрэг улсууд хөрөнгө оруулалт татах, бизнесийн орчныг сайжруулах, татварын орчныг энгийн, ойлгомжтой болгоход чиглэсэн өөрчлөлтүүдийг хийсэн байна. Эдгээр татварын бодлогын арга хэмжээнүүд нь жижиг, дунд аж ахуйн нэгжүүдийн санхүүгийн тогтвортой байдлыг хангах, өрсөлдөх чадварыг нэмэгдүүлэх, цаашлаад эдийн засгийн өсөлтийг дэмжихэд чухал үүрэг гүйцэтгэж байна.

Дээрх бодлого, зорилтуудыг хэрэгжүүлэх, эдийн засгийн өсөлтийг дэмжих, бизнес эрхлэх илүү таатай татварын орчныг бүрдүүлэх, бизнесүүд үйл ажиллагаагаа идэвхжүүлэх, тогтвортой явуулах нөхцөлийг бүрдүүлэх, түүнд дэмжлэг үзүүлэх шаардлага тулгарч буйг харгалзан Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг боловсруулах шаардлага үүсээд байна.

Хуулийн төсөлд дараах үндсэн чиглэлийг баримталж, холбогдох зохицуулалтуудыг тусгасан. Үүнд:

- Жижиг, дунд аж ахуйн нэгжүүдэд хялбаршуулсан бага татвар бүхий горимд хамрагдах боломжийг нэмэгдүүлнэ;
- Аж ахуйн нэгжүүдэд татварын орчныг илүү хялбар, энгийн, уян хатан болгоно;
- Татварын хууль тогтоомжийн хэрэгжилттэй холбоотойгоор татвар төлөгчдөд үүсдэг тодорхойгүй, маргаантай асуудлуудыг зохицуулна;
- Аж ахуйн нэгжүүд үйл ажиллагаагаа тогтвортой явуулах, хүний нөөцөө дэмжих, хуримтлал үүсгэх нөхцөлийг бүрдүүлэн, бизнесийн өргөжих, тэлэх боломжийг нэмэгдүүлнэ.

Хуулийн төсөл батлагдсанаар Монгол Улсын бизнесийн орчны олон улсын тавцанд өрсөлдөх чадвар сайжрах, жижиг, дунд бизнес эрхлэгчдийн татварын ачаалал буурах, улмаар эдийн засгийн өсөлт нэмэгдэж, нийгмийн тогтвортой байдал бэхжих зэрэг эерэг үр дагавартай юм.

ДЭЛГЭРЭНГҮЙ ТАНИЛЦУУЛГА

Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай

Монгол Улсын Их Хурлын 2020 оны 52 дугаар тогтоолоор батлагдсан “Алсын хараа-2050” урт хугацааны хөгжлийн бодлогод жижиг, дунд бизнес эрхлэлтийн өрсөлдөх чадварыг дээшлүүлнэ, олон улсад өрсөлдөхүйц бичил, жижиг, дунд бизнес эрхлэх таатай орчин, нөхцөлийг бүрдүүлнэ зэрэг зорилтуудыг дэвшүүлсэн. Уг зорилтуудыг хэрэгжүүлэх хүрээнд “Хөрөнгө оруулалтыг бүрэн дэмжсэн, бизнес эрхлэх таатай орчныг бүрдүүлнэ”, “Олон улсад өрсөлдөх чадвартай бичил, жижиг, дунд бизнес эрхлэгчдийг хөгжүүлж, ажлын байрыг нэмэгдүүлнэ” гэж тус тус заасан.

Монгол Улсын Их Хурлын 2020 оны 23 дугаар тогтоолоор батлагдсан Монгол Улсыг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэлийн 3.3.2-т “бичил, жижиг, дунд бизнесийг дэмжих орчин бэхжиж, төлөвшинэ”, 4.1.5-д “бизнесийн таатай орчныг бүрдүүлж, иргэдийн худалдан авах чадварыг дээшлүүлнэ” гэж заасан.

Монгол Улсын Их Хурлын 2024 оны 21 дүгээр тогтоолоор батлагдсан Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 3.2.1-д “Татвар, нийгмийн даатгалын шинэчлэл хийх”-ээр заасан бөгөөд энэ хүрээнд татварын орчныг олон улсын стандартад үе шаттайгаар нийцүүлж, цахим татварын тогтолцоог сайжруулах, бизнес эрхлэх эрх зүйн орчныг сайжруулах, бизнес эрхлэгчдийн татварын ачааллыг бууруулах, татварын дэмжлэгүүдийг оновчтой болгож, татварын орчныг сайжруулах, хариуцлагатай татвар төлөгчийг дэмжих зэрэг зорилтуудыг тус тус тусгасан.

Татварын хуулийн шинэчлэлийн хүрээнд Татварын ерөнхий хууль, Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хууль, Хувь хүний орлогын албан татварын тухай хуулийн төслүүдийг 2019 онд Улсын Их Хурлаас баталж, 2020 оноос эхлэн хүчин төгөлдөр мөрдөгдөж эхэлсэн. Энэхүү шинэчлэл нь жижиг, дунд бизнесийг дэмжих, татварын үйл ажиллагааг цахимжуулах, олон улсын татварын шинэлэг зарчмуудыг дотоодын хууль тогтоомжид нэвтрүүлэх үндсэн зорилготой байсан.

Гэвч хуулийн шинэчлэлээс хойших хугацаанд геополитикийн тогтворгүй нөхцөл байдал үргэлжилж, худалдааны бодлогоос үүдэлтэй тодорхой бус байдал нэмэгдэх, голлох эдийн засгуудын өсөлт удаашрах, инфляцын түвшин өсөх, зээлийн хүү нэмэгдэх зэрэг нийтлэг санхүүгийн хүндрэл, эрсдэлүүд дэлхийн нийгэм, эдийн засгийн төлөвт бий болсон.

Энэ хүрээнд сүүлийн жилүүдэд дэлхийн улс орнууд татварын бодлогоор жижиг, дунд бизнесийн өсөлт, хөгжлийг дэмжихэд чиглэсэн арга хэмжээнүүдийг хэрэгжүүлж байна. Тухайлбал Бүгд Найрамдах Энэтхэг Улс, Канад Улс, Япон Улс зэрэг улс орнууд бизнес эрхлэгчдийн санхүүгийн дарамтыг бууруулах, ажлын байрыг нэмэгдүүлэх, эдийн засгийн өсөлтийг дэмжих зорилгоор жижиг, дунд аж ахуйн нэгжүүдэд татварын таатай нөхцөлийг бүрдүүлж, тэдний татварын ачааллыг бууруулах бодлого хэрэгжүүлсэн байна. Мөн Бүгд Найрамдах Сингапур Улс, Их Британи Умард Ирландын Нэгдсэн Хант Улс, Бүгд Найрамдах Казакстан Улс зэрэг улсууд хөрөнгө оруулалт татах, бизнесийн орчныг сайжруулах, татварын орчныг энгийн, ойлгомжтой болгоход чиглэсэн өөрчлөлтүүдийг хийсэн байна. Эдгээр татварын бодлогын арга хэмжээнүүд нь жижиг, дунд аж ахуйн нэгжүүдийн

санхүүгийн тогтвортой байдлыг хангах, өрсөлдөх чадварыг нэмэгдүүлэх, эдийн засгийн өсөлтийг дэмжихэд чухал үүрэг гүйцэтгэж байна.

Татварын хууль тогтоомжуудад шаардлагатай нэмэлт, өөрчлөлтийг оруулах зорилгоор 2025 оны 01 дүгээр сарын 27-ны өдрөөс эхлэн Сангийн яам, татвар, гаалийн байгууллага, Монголын үндэсний худалдаа, аж үйлдвэрийн танхим болон Улсын Их Хурлын Тамгын газар хамтран улс орон даяар давхардсан тоогоор 11,000 гаруй татвар төлөгчийг хамруулсан 150 удаагийн уулзалт, хэлэлцүүлэг зохион байгуулж, 176 мянга орчим санал хүлээн авсан. Хэлэлцүүлгийн явцад аж ахуйн нэгжүүдээс жижиг, дунд аж ахуйн нэгжүүдийн үйл ажиллагаа тогтворжих эхний жилүүдэд татварын бодлогоор дэмжлэг үзүүлэх, үйл ажиллагаагаа өргөжүүлэх, идэвхжүүлэх хүрээнд хүний нөөцөө хөгжүүлэх болон зарим зардлуудыг хасагдах зардалд тооцох, татвар төлөгчдөд хууль тогтоомжийн хэрэглээтэй холбоотой үүсдэг ойлгомжгүй, маргаантай асуудлуудыг шийдвэрлэх, татвар төлөх хугацааг сунгах зэрэг саналуудыг нийтлэг байдлаар ирүүлсэн.

Аж ахуйн нэгжүүдээс ирүүлсэн саналуудыг судлан үзэж, дээрх бодлого, зорилтуудыг хэрэгжүүлэх хүрээнд аж ахуйн нэгжүүдийг үйл ажиллагаагаа идэвхжүүлэх, тогтвортой явуулахад дэмжлэг үзүүлэх, жижиг, дунд аж ахуйн нэгжүүдийн татварын ачааллыг бууруулах, бизнес эрхлэх илүү таатай татварын орчныг бүрдүүлэх зорилгоор Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг боловсрууллаа.

Үзэл баримтлалд тусгасан үндсэн чиглэлийг баримталж, дараах холбогдох зохицуулалтуудыг хуулийн төсөлд тусгалаа. Үүнд:

1. Жижиг, дунд аж ахуйн нэгжүүдийн татварын ачааллыг бууруулж, татварын орчныг илүү энгийн, хялбар, уян хатан болгоно.

- Жилийн 1.5-2.5 тэрбум төгрөг хүртэлх борлуулалтын орлоготой аж ахуйн нэгжүүд 10 хувиар татвар төлж, дараагийн жил нь төлсөн татварын 50 хувийг буцаан авах;
- Жижиг, дунд аж ахуйн нэгжүүд хялбаршуулсан бага татвар бүхий горимд хамрагдах боломжийг нэмэгдүүлж, босгыг 400 сая болгон нэмэгдүүлэх;
- Шинээр эзэмшсэн хөрөнгийн элэгдэл, хорогдлын шимтгэлийг тухайн хөрөнгийг ашиглаж эхэлсэн өдрөөс эхлэн тооцох;
- Татварын тайлан тушаах хугацааг сунгах зэрэг зохицуулалтуудыг тус тус тусгалаа.

Дээр дурдсан өөрчлөлттэй холбоотой зохицуулалтуудыг хуулийн төслийн 3 дугаар зүйл, 4 дүгээр зүйл болон 5 дугаар зүйлд тус тус тусгалаа.

2. Бизнесүүд үйл ажиллагаагаа тогтвортой явуулах, хуримтлал үүсгэх, хүний нөөцийн хөгжилд дэмжлэг үзүүлэх, бизнесийн өргөжих боломжийг дэмжинэ.

- Аж ахуйн нэгжийн ажилтнаа сургах, мэргэжил дээшлүүлэх, мэргэшүүлэх болон ажилтны хангамжид зориулан авсан бараа, ажил, үйлчилгээний зардлыг хасагдах зардалд тооцох;

- Гадаадад гарсан татвар төлөгчийн үйл ажиллагаатай холбоотой бэлэн бус төлбөр төлөгдсөн зардлыг И-баримт шаардахгүйгээр хасагдах зардалд тооцох;
- Аюулт үзэгдлийн улмаас үүссэн хохирлын даатгалын нөхөн төлбөрийг чөлөөлөх;
- Засгийн газрын тусгай санд хуулийн дагуу төвлөрүүлсэн хөрөнгийг хасагдах зардалд тооцох;
- Татварын хууль тогтоомжийн хэрэгжилттэй холбоотойгоор татвар төлөгчдөд үүсдэг тодорхойгүй асуудлуудыг татвар төлөгчдөд илүү ойлгомжтой болгох зэрэг зохицуулалтуудыг тус тус тусгалаа.

Дээр дурдсан өөрчлөлттэй холбоотой зохицуулалтыг хуулийн төслийн 1 дүгээр зүйл, 2 дугаар зүйл, 3 дугаар зүйл, 4 дүгээр зүйл, 5 дугаар зүйл болон 6 дугаар зүйлд тус тус тусгалаа.

Хуулийн төсөл батлагдсанаар Монгол Улсын бизнесийн орчны олон улсын тавцанд өрсөлдөх чадвар сайжирч, бизнес эрхлэгчдийн татварын ачаалал буурна. Үүний үр дүнд эдийн засгийн өсөлтийг дэмжих, нийгмийн тогтвортой байдал бэхжүүлэх суурь нөхцөл бүрдэх чухал ач холбогдолтой юм.

Хуулийн төсөлтэй холбогдуулан Мэргэжлийн болон техникийн боловсрол, сургалтын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг боловсрууллаа.

---oOo---

DETAILED INTRODUCTION

On the Draft Law to Amend the Law on Entity Income Tax

The long-term development policy of Mongolia “Vision 2050”, approved by Resolution No.52 of the State Great Khural of Mongolia in 2020, sets forth objectives to enhance the competitiveness of small and medium-sized enterprises (SMEs), and to establish favorable and internationally competitive conditions for micro, small, and medium enterprises. Within the framework of implementing these objectives, it is stipulated to “fully support investment and create a favorable business environment” and to “develop internationally competitive micro, small, and medium-sized enterprises and increase employment.”

Pursuant to Resolution No. 23 of 2020, the State Great Khural of Mongolia approved the Five-Year Development Guidelines of Mongolia for 2021–2025, wherein Clause 3.3.2 provides for the strengthening and consolidation of the environment supporting micro, small, and medium-sized enterprises, and Clause 4.1.5 mandates the creation of a favorable business environment and the enhancement of citizens’ purchasing power.

The Government Action Plan of Mongolia for 2024–2028, approved by Resolution No. 21 of the State Great Khural in 2024, provides in Section 3.2.1 for “tax and social insurance reforms.” Within this framework, the objectives include gradually aligning the tax environment with international standards, improving the e-tax system, strengthening the legal framework for entrepreneurship, reducing the tax burden on businesses, optimizing tax incentives, improving the overall tax environment, and supporting responsible taxpayers.

The 2019 tax reform package, encompassing the General Tax Law, the Corporate Income Tax Law, and the Individual Income Tax Law, was approved by the State Great Khural and took effect in 2020. This reform aimed to support small and medium-sized enterprises, modernize tax processes through digitalization, and incorporate contemporary international taxation principles into domestic law.

However, in the six years following the legal reforms, persistent geopolitical instability, coupled with trade policy uncertainty, contributed to a slowdown in major economies, rising inflation, increased interest rates, and declining foreign investment, creating widespread financial challenges and risks in the global economic landscape.

Within this context, countries around the world have used tax policies to promote the growth and development of SMEs in the recent years. For example, Japan, India, and Canada have implemented tax incentives for SMEs to reduce financial burdens, increase employment, and stimulate economic growth. Additionally, countries such as Singapore, the UK, and Kazakhstan have made changes aimed to attract investment, enhance the business environment, and simplify and clarify their tax systems. These changes play a crucial role in ensuring the financial stability of SMEs, enhancing their competitiveness, and supporting economic growth.

To introduce the necessary amendments to tax legislation, starting from January 27, 2025, the Ministry of Finance, the tax and customs authorities, the Mongolian National Chamber of Commerce and Industry, and the Secretariat of the State Great Khural jointly organized 150 meetings and discussions across the country, involving more than 11,000 taxpayers, and received approximately 176,000 proposals. During these discussions,

enterprises frequently expressed the need for tax policy measures to support SMEs in their early years of operation, to allow certain expenses to be treated as deductible, to resolve ambiguities and disputes arising from the application of tax legislation, and to extend the deadlines for tax payments.

Considering the proposals received from enterprises and in line with the policy objectives outlined above, this draft law amending the Law on Entity Income Tax has been developed with the aim of supporting business sustainability and expansion, reducing the tax burden on SMEs, and creating a more favorable tax environment for entrepreneurs.

The following key measures are reflected in the draft law:

1. Reduce the tax burden on SMEs and make the tax environment simpler, easier, and more flexible.

- Businesses with annual sales revenue of between MNT 1.5–2.5 billion will be taxed at 10%, with 50% of the tax paid refunded in the following year;
- Increase the threshold for simplified low-tax regimes for SMEs to MNT 400 million;
- Depreciation of newly acquired assets will be calculated from the date the asset is first put into use;
- Extend the deadlines for filing tax returns.

These provisions are reflected in Articles 3, 4, and 5 of the draft law.

2. To support enterprises in sustaining operations, building reserves, developing human resources, and expanding business opportunities.

Treat expenses for employee training, professional development, certification, and staff welfare as deductible.

- Allow non-cash expenses related to foreign operations of taxpayers to be deductible without requiring e-invoices;
- Exempt insurance compensation for damages caused by disasters;
- Treat funds transferred to special government funds in accordance with the law as deductible expenses;
- Clarify provisions of tax legislation that are currently ambiguous for taxpayers.

These provisions are reflected in Articles 1, 2, 3, 4, 5, and 6 of the draft law.

Upon adoption, the draft law will improve Mongolia's international business competitiveness and reduce the tax burden on entrepreneurs. As a result, it will play an important role in creating the fundamental conditions necessary to support economic growth and strengthen social stability.

In relation to the draft law, the necessary amendments to the Law on Vocational and Technical Education and Training have been duly prepared.

**АЖ АХУЙН НЭГЖИЙН ОРЛОГЫН АЛБАН ТАТВАРЫН ТУХАЙ ХУУЛЬД
НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ**

- | | |
|---------------|--|
| 1 дүгээр зүйл | Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуульд хэсэг, заалт нэмэх |
| 2 дугаар зүйл | Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуулийн зарим хэсэг, заалтад үг, өгүүлбэрийг нэмэлтээр оруулах |
| 3 дугаар зүйл | Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуулийн зарим хэсэг, заалтад өөрчлөн найруулах |
| 4 дүгээр зүйл | Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуулийн зарим хэсэг, заалтад өөрчлөлт оруулах |
| 5 дугаар зүйл | Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуулийн зарим хэсэг, заалтын үг, өгүүлбэрийг хасах |
| 6 дугаар зүйл | Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуулийн зарим хэсэг, заалтыг хүчингүй болсонд тооцох |
| 7 дугаар зүйл | Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийг дагаж мөрдөх хугацаа |

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2025 оныдугаар
сарын-ны өдөр

Улаанбаатар
хот

АЖ АХУЙН НЭГЖИЙН ОРЛОГЫН АЛБАН ТАТВАРЫН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл.Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуульд доор дурдсан агуулгатай дараах хэсэг, заалт нэмсүгэй:

1/13 дугаар зүйлийн 13.2.13, 13.2.14 дэх заалт:

“13.2.13.Хөдөлмөрийн тухай хуулийн 73 дугаар зүйлд заасны дагуу ажилтныг сургах, мэргэжил дээшлүүлэх, мэргэшүүлэхтэй холбоотой гарсан зардал нь тухайн татварын жилд хөдөлмөрийн гэрээ байгуулан ажиллаж байгаа нийт ажилтанд олгосон цалингийн зардлын нийт дүнгийн 10 хувиас хэтрэхгүй байна. Албан татвар төлөгчийн эрх бүхий албан тушаалтантай Татварын ерөнхий хуулийн 27.1.1-д заасан харилцан хамаарал бүхий ажилтан хамаарахгүй;

13.2.14.албан татвар төлөгчийн эрхэлж байгаа аж ахуйн үйл ажиллагаатай шууд холбоогүй, ажилтны хангамжид зориулан худалдаж авсан бараа, ажил, үйлчилгээний зардал нь тухайн татварын жилд хөдөлмөрийн гэрээ байгуулан ажиллаж байгаа нийт ажилтанд олгосон цалингийн зардлын нийт дүнгийн 5 хувиас хэтрэхгүй байна. Албан татвар төлөгчийн эрх бүхий албан тушаалтантай Татварын ерөнхий хуулийн 27.1.1-д заасан харилцан хамаарал бүхий ажилтан хамаарахгүй.”

2/13 дугаар зүйлийн 13.6 дахь хэсэг:

“13.6.Албан татвар төлөгчийн Монгол Улсад байрладаггүй болон Монгол Улсад байнга оршин суугч бус албан татвар төлөгчөөс гадаад улсын нутаг дэвсгэрт худалдан авсан үйлчилгээний зардлыг бэлэн бусаар төлсөн баримт, холбогдох гэрээг үндэслэн энэ хуулийн 13.1.4-т заасан төлбөрийн баримт шаардахгүйгээр албан татвар ногдох орлогоос хасаж тооцно.”

3/15 дугаар зүйлийн 15.1.20 дахь заалт:

“15.1.20.Засгийн газрын тусгай сангийн тухай хуулийн 9.2, 9.3-т заасны дагуу тусгай санд төвлөрүүлсэн хөрөнгө.”

4/21 дүгээр зүйлийн 21.1.17, 21.1.18 дахь заалт:

“21.1.17.Гамшгаас хамгаалах тухай хуульд заасан аюулт үзэгдлийн улмаас үүссэн хохирлын даатгалын нөхөн төлбөр.”

21.1.18.Монгол Улсад байрладаг албан татвар төлөгчийн өөрийн 100 хувь эзэмшдэг аж ахуйн нэгжээс авсан ногдол ашгийн орлого.”

5/30 дугаар зүйлийн 30.15, 30.16, 30.17 дахь хэсэг:

“30.15.Тусгай зөвшөөрөл эзэмшигч нь нэмж хувьцаа гаргаж хувь нийлүүлсэн хөрөнгөө нэмэгдүүлснийг энэ зүйлд заасны дагуу эрх борлуулсан, шилжүүлсэн гэж үзэхгүй.

30.16.Энэ зүйлийн 30.2-т заасан этгээдүүд дараах баримт бичигт холбогдох мэдээллийг татварын албанд мэдүүлнэ:

30.16.1.хувьцаа, хувь оролцоо борлуулсан, шилжүүлсэн гэрээ, тухайн гэрээнд оруулсан нэмэлт, өөрчлөлт, түүнтэй холбоотой байгуулсан ирээдүйд бүтээгдэхүүн хуваах, ашиг хуваах, өр авлага шилжүүлэх гэрээ болон бусад гэрээ, хэлцэл;

30.16.2.Эрдэс баялгийн мэргэжлийн зөвлөлөөр хэлэлцүүлж батлуулсан техник, эдийн засгийн үндэслэл, техник, эдийн засгийн урьдчилсан тооцоолол, ордын геологийн болон ашиглалтын нөөц, нөөцийн хөдөлгөөний мэдээлэл, хайгуулын болон ашиглалтын үйл ажиллагааны тайлан, төлөвлөгөө, бусад мэдээлэл;

30.16.3.тусгай зөвшөөрлийг борлуулах, шилжүүлэхтэй холбоотой эрхийн үнэлгээг тогтоосон үндэслэл, холбогдох нотлох баримт, мэдээлэл.

30.17.Энэ зүйлийн 30.16-д заасан баримт бичгийг бүрэн ирүүлсний дараа татвар төлөгчийн тодорхойлсон албан татвар ногдуулах орлогыг татварын алба ажлын 30 хоногийн дотор хянан баталгаажуулна.”

2 дугаар зүйл.Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.9.4 дэх заалтын “цэцэрлэгжүүлэх,” гэсний дараа “олон нийтэд үйлчлэх зориулалт бүхий ариун цэврийн байгууламж шинээр байгуулах болон засварлах, хяналтын камер суурилуулах,” гэж тус тус нэмсүгэй.

3 дугаар зүйл.Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуулийн дараах хэсэг, заалтыг доор дурдсанаар өөрчлөн найруулсугай:

1/22 дугаар зүйлийн 22.1 дэх хэсэг:

“22.1.Холбогдох хуулийн дагуу үүсгэн байгуулагдсан, мөн доор дурдсанаас бусад салбарт үйл ажиллагаа явуулдаг албан татвар төлөгчийн жилийн эцсийн татварын тайланд тусгасан энэ хуулийн 18.2, 18.3, 18.4, 18.5-д заасан албан татвар ногдох орлого нь 1.5 тэрбум төгрөгөөс ихгүй бол энэ хуулийн 20.1-д заасны дагуу ногдуулсан албан татварыг 90 хувиар, 1.5–2.5 тэрбум төгрөг хүртэл бол 50 хувиар хөнгөлнө.”

2/29 дүгээр зүйлийн 29.3.1 дэх заалт:

“29.3.1.албан татвар төлөгч болон тухайн татварын жилд түүнтэй ажил гүйлгээ хийсэн харилцан хамаарал бүхий этгээдийн борлуулалтын орлогын нийлбэр дүн 400 сая төгрөгөөс их;”

4 дүгээр зүйл.Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.2.6, 13.6.7 дахь заалтын “15 хувиас” гэснийг “2026 онд 20 хувиас, 2027 онд 25 хувиас, 2028 оноос эхлэн 30 хувиас” гэж, 14 дүгээр зүйлийн 14.4 дэх хэсгийн “хөрөнгө оруулагч этгээдээс энгийн хувьцаа, давуу эрхийн хувьцаа худалдан авах, хувь нийлүүлэх замаар оруулсан хөрөнгө оруулалтыг” гэснийг “хөрөнгө оруулагчийн хувь оролцоонд хамаарах өмнөх тайлант хугацааны эздийн өмчийг” гэж, 15 дугаар зүйлийн 15.1.5 дахь заалтын “Мэргэжлийн боловсрол, сургалтын тухай хуулийн 11.5, 18 дугаар” гэснийг “Мэргэжлийн болон техникийн боловсрол, сургалтын тухай хуулийн 14 дүгээр” гэж, 17 дугаар зүйлийн 17.11 дэх хэсгийн “дараагийн сарын эхний” гэснийг “тухайн хөрөнгийг ашиглаж эхэлсэн” гэж, 20 дугаар зүйлийн 20.3 дахь хэсгийн “хувь, хэмжээгээр” гэснийг “хувиар” гэж, 21 дүгээр зүйлийн 21.1.9 дэх заалтын “Боловсролын тухай хуулийн 12.1,” гэснийг “Боловсролын ерөнхий хуулийн 18.1,” гэж, 25 дугаар зүйлийн 25.2 дахь хэсгийн “25-ны” гэснийг “сүүлийн өдрийн” гэж, 25 дугаар зүйлийн 25.2 дахь хэсгийн, 26 дугаар зүйлийн 26.1, 26.2 дахь хэсгийн, 29 дүгээр зүйлийн 29.12 дахь хэсгийн, 30 дугаар зүйлийн 30.12 дахь хэсгийн “20-ны” гэснийг “сүүлийн өдрийн” гэж, 25 дугаар зүйлийн 25.2 дахь хэсгийн, 26 дугаар зүйлийн 26.1, 26.2, 26.8 дахь хэсгийн, 29 дүгээр зүйлийн 29.13 дахь хэсгийн, 30 дугаар зүйлийн 30.12 дахь хэсгийн, 31 дүгээр зүйлийн 31.8, 31.9 дэх хэсгийн “10-ны” гэснийг “сүүлийн өдрийн” гэж, 27 дугаар зүйлийн 27.11 дэх хэсгийн “тухайн татварын жилийн дунджаар тооцож, дараагийн татварын жилийн 01 дүгээр сард багтаан” гэснийг “албан ханшаар Эдийн засгийн хамтын ажиллагаа, хөгжлийн байгууллагын зөвлөмжийн дагуу тооцож” гэж, 29 дүгээр зүйлийн 29.1 дэх хэсгийн “50.0” гэснийг “400.0” гэж, мөн хэсгийн “нийт дүнгээр” гэснийг “10 хувиар” гэж, 29.6 дахь хэсгийн “албан татвар төлөгч Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуульд заасан нөхцөл, шаардлагын дагуу нэмэгдсэн өртгийн албан татварын суутган төлөгч болсон өдрөөс” гэснийг “албан татвар төлөгчийн борлуулалтын орлогын дүн 400 сая төгрөг хүрсэн өдрийн дараа сараас” гэж, 29.9 дэх хэсгийн “1” гэснийг “10” гэж, 30 дугаар зүйлийн 30.10 дахь хэсгийн “хувь хэмжээгээр” гэснийг “хувиар” гэж, 31 дүгээр зүйлийн 31.6 дахь хэсгийн “хувь хэмжээг” гэснийг “хувийг” гэж тус тус өөрчилсүгэй.

5 дугаар зүйл.Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.1.12 дахь заалтын “энэ хуулийн 22.9-д зааснаас бусад” гэснийг, 17 дугаар зүйлийн 17.11 дэх хэсгийн “тухайн улиралд” гэснийг, Тавдугаар бүлгийн гарчгийн “, ХЭМЖЭЭ” гэснийг, 20 дугаар зүйлийн гарчгийн “, хэмжээ” гэснийг, 22 дугаар зүйлийн 22.3, 22.4 дэх хэсгийн “20.2.7,” гэснийг, 25 дугаар зүйлийн 25.1 дэх хэсгийн “, 20.2.7” гэснийг, 22 дугаар зүйлийн 22.10 дахь хэсгийн “, 22.5.9” гэснийг, 30 дугаар зүйлийн 30.7 дахь хэсгийн “Энэ хуулийн 30.1-д заасан эцсийн эзэмшигч нь Монгол Улсад байрладаг албан татвар төлөгч бол тухайн” гэснийг тус тус хассугай.

6 дугаар зүйл.Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.7, 15.8 дахь хэсгийг, 20 дугаар зүйлийн 20.2.7 дахь заалтыг, 22 дугаар зүйлийн 22.5.9 дэх заалтыг тус тус хүчингүй болсонд тооцугай.

7 дугаар зүйл.Энэ хуулийг ... оны ... дүгээр сарын ...-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

Гарын үсэг

**МЭРГЭЖЛИЙН БОЛОН ТЕХНИКИЙН БОЛОВСРОЛ, СУРГАЛТЫН
ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ**

- | | |
|---------------|--|
| 1 дүгээр зүйл | Мэргэжлийн болон техникийн боловсрол, сургалтын тухай хуулийн зарим хэсгийн үгийг хасах |
| 2 дугаар зүйл | Мэргэжлийн болон техникийн боловсрол, сургалтын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийг дагаж мөрдөх хугацаа |

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2025 оныдугаар
Улаанбаатар
сарын-ны өдөр

ХОТ

МЭРГЭЖЛИЙН БОЛОН ТЕХНИКИЙН БОЛОВСРОЛ, СУРГАЛТЫН ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл.Мэргэжлийн болон техникийн боловсрол, сургалтын тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 19.4 дэх хэсгийн “, 15.1.6, 15.1.9” гэснийг хассугай.

2 дугаар зүйл.Энэ хуулийг 2026 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс дагаж мөрдөнө.

Гарын үсэг

**АЖ АХУЙН НЭГЖИЙН ОРЛОГЫН АЛБАН
ТАТВАРЫН ТУХАЙ ХУУЛИЙН ХЭРЭГЖИЛТИЙН
ҮР ДАГАВАРТ ХЭСЭГЧЛЭН ХИЙСЭН ҮНЭЛГЭЭ**

Улаанбаатар хот
2025 он

АГУУЛГА

ТОВЧИЛСОН ҮГИЙН ЖАГСААЛТ	3
УДИРТГАЛ	5
НЭГ. ТӨЛӨВЛӨХ ҮЕ ШАТ	6
1.1. Үнэлгээ хийх шалтгааныг тодорхойлох	6
1.2. Үнэлгээ хийх хүрээг тогтоох	6
1.3. Шалгуур үзүүлэлтийг сонгосон үндэслэл	7
1.4. Үнэлгээний харьцуулах хэлбэрийг сонгох	9
1.5. Шалгуур үзүүлэлтийг томъёолох	10
1.6. Мэдээлэл цуглуулах аргыг сонгох	11
ХОЁР. ХЭРЭГЖҮҮЛЭХ ҮЕ ШАТ	12
ГУРАВ. ҮНЭЛЭХ ҮЕ ШАТ	12
3.1. “ЗОРИЛГОД ХҮРСЭН ТҮВШИН” ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТИЙН ХҮРЭЭНД ҮНЭЛСЭН БАЙДАЛ	12
3.2. “ПРАКТИКТ НИЙЦЭЖ БАЙГАА БАЙДАЛ” ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТИЙН ХҮРЭЭНД ҮНЭЛСЭН БАЙДАЛ	16
ДӨРӨВ. ДҮГНЭЛТ, САНАЛ	22
ТАВ. АШИГЛАСАН ЭХ СУРВАЛЖ	26

ТОВЧИЛСОН ҮГИЙН ЖАГСААЛТ

ААН	Аж ахуйн нэгж
ААНОАТ	Аж ахуйн нэгжийн орлогын албан татвар
ААНОАТтХ	Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хууль
АМАТЗ	Ашигт малтмалын ашиглалтын тусгай зөвшөөрөл
АМХТЗ	Ашигт малтмалын хайгуулын тусгай зөвшөөрөл
БНХАУ	Бүгд найрамдах Хятад ард улс
ДНБ	Дотоодын нийт бүтээгдэхүүн
КтХ	Компанийн тухай хууль
ТБМНС	Татварын бүртгэл, мэдээллийн нэгдсэн сан
ТЕГ	Татварын ерөнхий газар
ТЕХ	Татварын ерөнхий хууль
ТТТГ	Том татвар төлөгчийн газар

ХҮСНЭГТИЙН ЖАГСААЛТ

Хүснэгт 1. “Зорилгод хүрсэн түвшин” шалгуур үзүүлэлтийн хүрээнд сонгосон зүйл, заалтууд	8
Хүснэгт 2. “Практикт нийцэж байгаа байдал” шалгуур үзүүлэлтийн хүрээнд сонгосон зүйл, заалтууд	8
Хүснэгт 3. “Үнэлгээний харьцуулах хэлбэрийн тайлбар”	10
Хүснэгт 4. ААНОАТ-ын тайлагналын мэдээ (2020-2023 он)	15
Хүснэгт 5. ААНОАТтХ-ийн 22.1-д заасан албан татварын хөнгөлөлтийн мэдээ, сая төгрөгөөр (2020-2023 он)	17
Хүснэгт 6. ААНОАТ-ын тайлангийн ирцийн мэдээ (2020-2023 он).....	20
Хүснэгт 7. Шийтгэлийн хуудасны судалгаа	21

ГРАФИКИЙН ЖАГСААЛТ

График 1. ААНОАТ-ын тайлагналын мэдээ (2020-2023 он)	15
---	----

УДИРТГАЛ

Монгол Улсын Их Хурлын 2024 оны 21 дүгээр тогтоолын 1 дүгээр хавсралтаар батлагдсан “Монгол Улсын Засгийн Газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөр”-т татвартай холбоотой 17 чиглэл тусгагдсан байна.

Тус хөтөлбөрийн 3.2.1-д заасан “Татвар, нийгмийн даатгал”-ын шинэчлэлийн хүрээнд 8 чиглэл тусгажээ. Харин үлдсэн 9 чиглэл нь Шилжилт хөдөлгөөн (1.4.1.7), Хөдөлмөр эрхлэлт (2.1.2.10), Нийгмийн баталгаа (2.1.3.11), Банк, санхүү, даатгалын салбарын шинэчлэл (3.1.3.5), Бизнес, хөрөнгө оруулалтын таатай орчин (3.2.2.8, 3.2.2.11), Шинжлэх ухаан, технологи, инновац (3.3.7.4), Ногоон эдийн засаг, ногоон хөгжлийн загвар (3.4.3.9), Сансар судлал, харилцаа холбоо, мэдээлэл технологи (4.3.2.3)-ийг салбарт татварын шинэчлэл хийхтэй холбоотой асуудлууд байна.¹

Энэ хүрээнд татварын шинэчлэлийг үр дүнтэй хэрэгжүүлэхийн тулд одоогийн хүчин төгөлдөр мөрдөгдөж буй хууль тогтоомжийн хэрэгжилтийг үнэлэх зайлшгүй шаардлагатай байна. Ингэснээр татварын хуулийн хэрэгжилтийн бодит байдалд дүн шинжилгээ хийж, гарч байгаа хүндрэл, бэрхшээл, нийгэмд үзүүлж байгаа эерэг, сөрөг нөлөөллийг илрүүлэх боломжтой.

Иймд Татварын Ерөнхий газраас “Татварын ерөнхий хууль”, “Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хууль”, “Хувь хүний орлогын албан татварын тухай хууль”, “Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хууль”, “Үл хөдлөх эд хөрөнгийн албан татварын тухай хууль”, “Монгол Улсын автотээврийн болон өөрөө явагч хэрэгслийн албан татварын тухай хууль”, “Газрын төлбөрийн тухай хууль”-ийн зарим зүйл, заалтын хэрэгжилтийн үр дагаварт тус тус үнэлгээг хийлээ.

Харин энэхүү судалгаагаар Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуулийн хэрэгжилтийн үр дагаварт Засгийн газрын 2016 оны 59 дүгээр тогтоолын 6 дугаар хавсралтаар батлагдсан “Хууль тогтоомжийн хэрэгжилтийн үр дагаварт үнэлгээ хийх аргачлал”-ыг баримтлан хэсэгчлэн үнэлгээ хийж, судалгааны тайланг боловсрууллаа.

Тус судалгааны зорилго нь хуулийн хэрэгжилтийн явц дахь хүндрэл, бэрхшээл, нийгэмд үзүүлж буй эерэг, сөрөг нөлөөллийг илрүүлэн, цаашид зохистой, үр дүнтэй хэрэгжүүлэх боломжит хувилбарыг тодорхойлж, үнэлэлт дүгнэлт өгөх, зөвлөмж боловсруулахад оршино.

¹ Монгол Улсын Их Хурлын Тогтоол, Дугаар 21, Монгол Улсын Засгийн Газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөр, <https://legalinfo.mn/mn/detail?lawId=17141368388631&showType=1>

НЭГ.ТӨЛӨВЛӨХ ҮЕ ШАТ

ААНОАТТХ-ийн хэрэгжилтийн үр дагаварт үнэлгээ хийх ажлыг Засгийн газрын 2016 оны 59 дүгээр тогтоолоор баталсан “Хууль тогтоомжийн хэрэгжилтийн үр дагаварт үнэлгээ хийх аргачлал”-ын дагуу төлөвлөх, хэрэгжүүлэх, үнэлэх гэсэн гурван үе шаттайгаар хийж гүйцэтгэсэн. Төлөвлөх үе шатанд дараах ажлыг хийж гүйцэтгэв. Үүнд:

1. Үнэлгээ хийх шалтгааныг тодорхойлох;
2. Үнэлгээ хийх хүрээг тогтоох;
3. Шалгуур үзүүлэлтийг сонгож тогтоох;
4. Харьцуулах хэлбэрийг сонгох;
5. Шалгуур үзүүлэлтийг томьёолох;
6. Мэдээлэл цуглуулах аргыг сонгох.

Үнэлгээ хийх шалтгааныг тодорхойлох

ААНОАТТХ 2019 оны 03 дугаар сарын 22-ны өдөр батлагдаж, 2020 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн мөрдөгдөж байна. Тус хуульд нийт 19 удаа нэмэлт, өөрчлөлт оруулсан бөгөөд хуулийн хэрэгжилтийн үр дагаварт үнэлгээ хийгээгүй байна.

Шинэчлэн найруулсан ААНОАТТХ хэрэгжиж эхлээд 5 жилийн хугацаа өнгөрч байгаа боловч тус хуулийн зарим зохицуулалтыг практикт нэг мөр ойлгон хэрэгжүүлэхэд хүндрэлтэй, олон нийтээс тус хуультай холбоотой санал, шүүмж ирсээр байна.

Иймд Хууль тогтоомжийн тухай хуулийн 51 дүгээр зүйлийн 51.3-т “Энэ хуульд өөрөөр заагаагүй бол хууль тогтоомжийн хэрэгжилтийн үр дагаварт хийх үнэлгээг тухайн хууль тогтоомжийг дагаж мөрдсөнөөс хойш 5 жил тутамд хийх бөгөөд шаардлагатай тохиолдолд дээрх хугацаанаас өмнө хийж болно” гэж заасан, мөн “Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого, Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрт тусгагдсан татварын эрх зүйн орчны шинэчлэлийг үр дүнтэй хэрэгжүүлэхэд одоо хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжийн хэрэгжилтийн үнэлэх, түүнчлэн татварын хууль тогтоомжийг хэрэгжүүлэхэд тулгамдаж буй хүндрэл, бэрхшээл, татвар алба болон татвар төлөгчийн хооронд маргаан үүсгэж буй асуудал болон олон нийтийн дунд зохион байгуулсан хэлэлцүүлэг, санал, асуулгын үр дүнд үндэслэн ААНОАТТХ-д үнэлгээ хийх зайлшгүй шаардлага бий болсон гэж үзэж байна.

Мөн тус хуулийн зарим зүйл, заалтын хувьд аргачлалын 3.2-т заасан ойлгомжгүй, зөрчилтэй зохицуулалттай байх, тэдгээр нь цаашид тухайн харилцаанд сөрөг үр дагавар үүсгэх шинжтэй, практикт хэрэгжүүлэхэд хүндрэлтэй, бодит байдалтай нийцээгүй, тухайн харилцааг зохицуулах боломжгүй нөхцөл байдал үүссэн талаар олон нийтээс үндэслэл бүхий саналууд ирсээр байна.

Тус хуулийн хэрэгжилтийн үр дагаварт үнэлгээ хийснээр татварын хууль тогтоомжийн хэрэгжилтийн бодит байдал, хуулийн хэрэгжилтийн явц дахь ололтыг бататгах, хүндрэл, бэрхшээлтэй асуудал, нийгэмд үзүүлж буй эерэг, сөрөг нөлөөллийг илрүүлэх, цаашид зохистой, үр дүнтэй хэрэгжих, хэрэгжүүлэх хувилбарыг тодорхойлох боломж бүрдэнэ. Өөрөөр хэлбэл, хуулиар зохицуулсан харилцаа нь зорилгодоо хүрсэн эсэх болон практикт хэрэгжилтийг судлан хуулийн хэрэгжилтэд хяналт тавих тогтолцоо оновчтой байгаа эсэх, хариуцлагын тогтолцоо үүргээ гүйцэтгэж байгаа эсэх, хуульд нэмэлт өөрчлөлт оруулах эсвэл шинэчлэн батлах шаардлага бий эсэхийг тогтоох боломжтой.

1.2. Үнэлгээ хийх хүрээг тогтоох

Үнэлгээний хүрээг тогтоох ажиллагаа нь хууль тогтоомжийн хэрэгжилтийн үр дагаврыг судлах явцад агуулгын хувьд чухал ач холбогдолтой, нөлөөлөл үзүүлэх хамгийн гол зохицуулалтыг тодорхойлоход чиглэдэг. Өөрөөр хэлбэл, үнэлгээ хийх болсон шалтгаан (өмнө тодорхойлсон)-тай харилцан уялдаа, хамааралтайгаар хийгдэх ажиллагаа бөгөөд

тодорхойлогдсон эерэг, сөрөг нөхцөл байдал, хүндрэл бэрхшээл, тулгамдсан асуудал, үр дагавар бүхий харилцаатай холбогдсон хуулийн зохицуулалтыг илрүүлнэ.

Үнэлгээний хүрээг тогтоохдоо үнэлгээ хийх ажлын төлөвлөлт, зохион байгуулалт, хүний нөөц, цаг хугацаа, гарах зардлыг заавал харгалзан үзэх нь чухал. Хуулийг бүхэлд нь үнэлэх ажиллагааны зардал ихэвчлэн хэт өндөр гардаг тул зөвхөн тухайн хуулийн зорилго, үнэлгээний шалгуурт хамгийн ихээр нөлөөлж болохуйц хуулийн зохицуулалтыг зөв сонгох шаардлагатай.

Хууль тогтоомжийн тухай хуулийн 51.4 дэх хэсэгт “Хууль тогтоомжийн зохицуулах харилцааны онцлог, асуудлаас хамааран хууль тогтоомжийн хэрэгжилтийн үр дагаврын үнэлгээ хийхдээ хууль тогтоомжид бүхэлд нь эсхүл түүний зарим зүйл, хэсэг, заалтыг сонгож болно” гэж заасны дагуу Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуулийн практикт хэрэгжүүлэхэд хүндрэлтэй, маргаан дагуулж буй эрх зүйн хийдэл, давхардал, хоёрдмол утгатай, иргэд, олон нийтийн зүгээс шүүмжлэл дагуулж буй зохицуулалтуудыг сонгон авах нь зүйтэй хэмээн үзсэн болно. Энэ хүрээнд тус хуулийн албан татвар ногдох орлогоос хасагдах зардалтай холбоотой зохицуулалт, албан татварын хувь, хэмжээтэй холбоотой зохицуулалт, албан татвар тайлагнах болон татварын хялбаршуулсан горимтой холбоотой зохицуулалтыг сонгон авч судлан үзлээ.

1.3.Шалгуур үзүүлэлтийг сонгосон үндэслэл

“Хууль тогтоомжийн хэрэгжилтийн үр дагаварт үнэлгээ хийх аргачлал”-ын дагуу дээрх хуулийн хэрэгжилтийг үнэлэхэд оновчтой, бодитой, хэмжиж болохуйц байдлыг баримталж, мөн үнэлгээний хүрээ, онцлогоос хамааран дараах шалгуур үзүүлэлтийг сонгосон болно. Үүнд:

1. “Зорилгод хүрсэн түвшин”
2. “Практикт нийцэж байгаа байдал”

1.3.1. “Зорилгод хүрсэн түвшин” шалгуур үзүүлэлтийг сонгосон үндэслэл

ААНОАТтХ-ийн 1 дүгээр зүйлд тус хуулийн зорилгыг “...аж ахуйн нэгжийн орлогын албан татвар ногдуулах, уг албан татварыг төсөвт төлөх, тайлагнахтай холбогдсон харилцааг зохицуулахад оршино...” гэж тодорхойлжээ. Иймд тус хуулийн дээр дурдсан зорилгыг хангахад чиглэсэн зүйл, заалтуудыг сонгож “Зорилгод хүрсэн түвшин” шалгуур үзүүлэлтийн хүрээнд үнэлгээг хийлээ. Сонгосон зүйл, заалтыг хүснэгтээр үзүүлбэл:

**Хүснэгт 1. “Зорилгод хүрсэн түвшин” шалгуур үзүүлэлтийн хүрээнд
сонгосон зүйл, заалтууд**

№	Сонгосон зүйл, заалт	Зүйл, заалтын агуулга
1.	15 дугаар зүйлийн 15.7, 15.8 дахь хэсэг	15 дугаар зүйл. Албан татвар ногдох орлогоос хасагдах бусад зардал 15.7. Эрх бүхий байгууллагаас тогтоосон стандартад нийцсэн олон нийтэд үйлчлэх зориулалт бүхий ариун цэврийн байгууламж шинээр байгуулсан болон засварласантай шууд холбогдон гарсан энэ хуулийн 13 дугаар зүйлд заасан шаардлага хангасан зардлыг 100 хувиар нэмэгдүүлэн албан татвар ногдох орлогоос хасаж тооцно. 15.8. Ойр орчмын гудамж талбайд эрх бүхий байгууллагаас тогтоосон стандартад нийцсэн хяналтын камер худалдан авч суурилуулахтай шууд холбогдон гарсан энэ хуулийн 13 дугаар зүйлд заасан шаардлага хангасан зардлыг 100 хувиар нэмэгдүүлэн албан татвар ногдох орлогоос хасаж тооцно. /
2.	20 дугаар зүйлийн 20.1 дэх хэсэг	20 дугаар зүйл. Албан татварын хувь, хэмжээ 20.1. Энэ хуулийн 18.2, 18.3, 18.4, 18.5-д заасны дагуу тодорхойлоход 0-6 тэрбум төгрөгийн албан татвар ногдуулах тухайн жилийн орлого олсон тохиолдолд 10 хувиар, 6 тэрбум төгрөгөөс дээш албан татвар ногдуулах тухайн жилийн орлого олсон тохиолдолд 600 сая төгрөг дээр 6 тэрбумаас дээш давсан орлогод 25 хувиар нэмж албан татвар ногдуулна.
3.	20 дугаар зүйлийн 20.2.7 дахь заалт	20 дугаар зүйл. Албан татварын хувь, хэмжээ 20.2. Албан татвар төлөгчийн дараах албан татвар ногдуулах орлогод доор дурдсан хувиар тооцож албан татвар ногдуулна: 20.2.7. энэ хуулийн 20.1-д заасныг үл харгалзан энэ хуулийн 18.2, 18.3, 18.4, 18.5-д заасан жилийн 300 сая төгрөг хүртэл албан татвар ногдох орлого олсон, энэ хуулийн 22.1.1, 22.1.2, 22.1.3-т зааснаас бусад салбарт үйл ажиллагаа явуулж байгаа албан татвар төлөгчийн тухайн албан татвар ногдуулах орлогод 1 хувиар.

1.3.2. “Практикт нийцэж байгаа байдал” шалгуур үзүүлэлтийг сонгосон үндэслэл

Энэхүү шалгуур үзүүлэлт нь тухайн хууль тогтоомжийн зохицуулалт практикт хэрхэн хэрэгжиж байгаа, түүний эерэг, сөрөг үр дагавар, хэрэгжүүлэхэд хүндрэл, бэрхшээл гарч байгаа эсэхийг тодорхойлоход чиглэгддэг. Иймд судалгааны энэ хэсэгт тус хуулийн зарим зохицуулалтыг сонгож, уг зүйл, заалт практикт хэрхэн хэрэгжиж байгаа байдал, түүний эерэг болон сөрөг үр дагавар, хэрэгжүүлэхэд гарч буй хүндрэл, бэрхшээл байгаа эсэхийг тодорхойлохыг зорьсон болно. Сонгосон зүйл, заалтыг хүснэгтээр үзүүлбэл:

**Хүснэгт 2. “Практикт нийцэж байгаа байдал” шалгуур үзүүлэлтийн хүрээнд
сонгосон зүйл, заалтууд**

№	Сонгосон зүйл, заалт	Зүйл, заалтын агуулга
1.	17 дугаар зүйлийн 17.11 дэх хэсэг	17.11. Албан татвар төлөгчийн тухайн улиралд шинээр эзэмшсэн хөрөнгийн элэгдэл, хорогдлын шимтгэлийг дараагийн сарын эхний өдрөөс эхлэн тооцно.
2.	22 дугаар зүйлийн 22.1 дэх хэсэг	22 дугаар зүйл. Албан татварын хөнгөлөлт 22.1. Энэ хуулийн 18.2, 18.3, 18.4, 18.5-д заасан албан татвар ногдох орлогыг 1.5 тэрбум төгрөгөөс ихгүй байхаар жилийн эцсийн татварын тайланд тусгасан, доор дурдсанаас бусад салбарт үйл ажиллагаа явуулдаг, энэ хуулийн 20.2.7-д зааснаас бусад Монгол Улсын хуулийн дагуу үүсгэн байгуулагдсан албан татвар төлөгчийн энэ хуулийн 20.1-д заасны дагуу ногдуулсан албан татварыг 90 хувиар хөнгөлнө:
3.	22 дугаар зүйлийн 22.5.1, 22.5.3, 22.5.7-22.5.9 дэх заалт	22.5. Дараах орлогод албан татварын хөнгөлөлт үзүүлнэ: 22.5.1. аймаг, хот, сумын төв нь нийслэл Улаанбаатар хотоос 500 км-ээс хол алслагдсан аймаг, хот, суманд байнгын үйл ажиллагаа явуулдаг, хуулийн этгээдийн ерөнхий захиргаа нь тухайн орон нутагт бүртгэлтэй, орон нутгийн татварын албатай харьцдаг, ажлын байр бий болгож /нийгмийн даатгалын шимтгэл төлөлтөөр баталгаажсан/ байгаа энэ хуулийн 5.3.1-д заасан албан татвар төлөгчийн тухайн аймаг, хот, сумын нутаг дэвсгэр дээр явуулсан үйл ажиллагаанаас олсон энэ хуулийн 7.4.1-д заасан албан татвар ногдох орлогод ногдох албан татварыг аймаг, хот, сумын төв нь нийслэл Улаанбаатар хотоос 500

		км-ээс хол алслагдсан аймаг, хот, суманд 50 хувиар, 1000 км-ээс хол алслагдсан аймаг, хот, суманд 90 хувиар; 22.5.3.байгалийн нөөцийг хэмнэлттэй ашиглах, орчны бохирдол, хаягдлыг багасгах, байгальд ээлтэй техник, тоног төхөөрөмжийг борлуулсан орлогод ногдох албан татварыг; 22.5.7.чөлөөт бүсэд зориулсан эрчим хүч, дулааны эх үүсвэр, шугам сүлжээ, цэвэр усан хангамж, ариутгах татуурга, авто зам, төмөр зам, нисэх онгоцны буудал, харилцаа холбооны үндсэн сүлжээ зэрэг дэд бүтцэд 500.0 мянган америк доллар буюу түүнээс дээш хэмжээний хөрөнгө оруулсан аж ахуйн нэгжийн чөлөөт бүсээс олсон орлогод оруулсан хөрөнгө оруулалтын 50 хувьтай тэнцэх хэмжээний орлогод ногдох албан татварыг; 22.5.8.чөлөөт бүсэд агуулах, ачиж буулгах байгууламж, зочид буудал, аялал жуулчлалын цогцолбор, импортыг орлох болон экспортын бүтээгдэхүүний үйлдвэр байгуулахад 300.0 мянган америк доллар буюу түүнээс дээш хэмжээний хөрөнгө оруулсан аж ахуйн нэгжийн чөлөөт бүсээс олсон орлогод оруулсан хөрөнгө оруулалтын 50 хувьтай тэнцэх хэмжээний орлогод ногдох албан татварыг; 22.5.9.тодорхой нутаг дэвсгэрийн усны нөөцийг нэмэгдүүлэх, усны найдвартай хангамжийг бүрдүүлэх зорилгоор байгалийн усны чанарыг сайжруулах, гол, горхийг нөхөн сэргээх арга хэмжээг санхүүжүүлсэн иргэн, аж ахуйн нэгж, байгууллагын тухайн арга хэмжээнд зарцуулсан хэмжээний орлогод ногдох албан татварыг.
4.	26 дугаар зүйлийн 26.1-26.2 дахь хэсэг	26 дугаар зүйл.Албан татварыг тайлагнах 26.1.Өмнөх татварын жилийн албан татвар ногдуулах орлого нь 6 тэрбум төгрөг ба түүнээс дээш бол уг албан татвар төлөгч тухайн татварын жилийн улирлын татварын тайланг дараагийн улирлын эхний сарын 20-ны дотор, жилийн эцсийн татварын тайланг дараа оны 02 дугаар сарын 10-ны дотор харьяалах татварын албанд хүргүүлнэ. 26.2.Татварын өмнөх жилийн албан татвар ногдуулах орлого нь 6 тэрбум төгрөг хүртэл энэ хуулийн 29.1-д заасны дагуу татварын албанд бүртгүүлээгүй албан татвар төлөгч тухайн татварын жилийн эхний хагас жилийн татварын тайланг 07 дугаар сарын 20-ны дотор, жилийн эцсийн татварын тайланг дараа оны 02 дугаар сарын 10-ны дотор гаргаж, харьяалах татварын албанд хүргүүлнэ.
5.	29 дүгээр зүйлийн 29.1 дэх хэсэг	29 дүгээр зүйл.Татварын хялбаршуулсан горим 29.1.Өмнөх татварын жилийн тайлангаар баталгаажсан борлуулалтын нийт орлогын хэмжээ 50.0 сая төгрөгөөс бага бол тухайн албан татвар төлөгч тухайн татварын жилийн 3 дугаар улиралд багтаан хүсэлт гаргасныг харьяалах татварын алба бүртгэж авсан тохиолдолд дараагийн татварын жилээс эхлэн тухайн албан татвар төлөгчийн үйл ажиллагааны орлогын нийт дүнгээр албан татвар ногдуулах орлогыг тодорхойлж болно.
6.	30 дугаар зүйлийн 30.2, 30.8 дахь хэсэг	30 дугаар зүйл.Эцсийн эзэмшигчийн хувьцаа, хувь оролцоог өөрчлөх замаар эрх борлуулсан, шилжүүлсний татварын харилцаа 30.2.Эцсийн эзэмшигчийн эзэмшиж байгаа хувьцаа, хувь оролцоо, саналын эрхийг борлуулах, шилжүүлэх замаар Монгол Улсын хууль тогтоомжийн дагуу олгосон газар эзэмших, ашиглах эрх, ашигт малтмал, цацраг идэвхт ашигт малтмал, газрын тосны хайгуулын болон ашиглалтын тусгай зөвшөөрлийг бүрэн буюу хэсэгчлэн борлуулах, шилжүүлэхтэй холбогдон олсон орлогыг тухайн эрх эзэмшигч аж ахуйн нэгжийн энэ хуулийн 10.1.2-т заасан орлогод тооцно. 30.8.Эцсийн эзэмшигч нь эрх эзэмшигчийн тухайд төлөөлүүлэн эзэмшиж буй байгаа хувьцаа, хувь оролцоо, саналын эрхийн нийт дүн, хэмжээг өөрчлөлгүйгээр эрх эзэмшигчээс эцсийн эзэмшигч хүртэлх үргэлжилсэн хэлхээ холбоонд хамаарах хуулийн этгээд хооронд хувьцаа шилжүүлэх, нэгдэх, нийлэх, тусгаарлах, шинэ хуулийн этгээд үүсгэн байгуулах хэлбэрээр хэлхээ холбоо доторх хувьцаа, хувь оролцоо, саналын эрхийн бүтцийг өөрчилсөн тохиолдолд эрх борлуулсан, шилжүүлсэн гэж үзэхгүй.

1.4. Үнэлгээний харьцуулах хэлбэрийг сонгох

Хуулийн хэрэгжилтийн үр дагаварт үнэлгээ хийхдээ үнэлэх болсон шалтгаан, үнэлгээний хүрээ, шалгуур үзүүлэлт зэргийг харгалзан дор дурдсан харьцуулах хэлбэрүүдээс сонгоно. Үүнд:

- Байх ёстой болон одоо байгаа;

- Хууль тогтоомж батлагдахаас өмнөх болон хууль тогтоомж батлагдсанаас хойших;
- Хууль хүчин төгөлдөр үйлчилж эхэлснээс хойших;
- Тохиолдол судлах.

Хүснэгт 3. “Үнэлгээний харьцуулах хэлбэрийн тайлбар”

№	Харьцуулах хэлбэр	Ойлголт, онцлог
1.	Байх ёстой болон одоо байгаа	Хуулиар тогтоосон “байх ёстой” үзүүлэлт практикт хэр байгааг илрүүлэх зорилготой. Үнэлгээ хийх хуульд байвал зохих тодорхой абсолют үзүүлэлтийг зааж өгсөн тохиолдолд одоо бодит байгаа үзүүлэлттэй харьцуулна.
2.	Хууль тогтоомж батлагдахаас өмнөх болон хууль тогтоомж батлагдсанаас хойш	Хууль хүчин төгөлдөр үйлчлэхээс өмнөх нөхцөл байдлыг хууль хүчин төгөлдөр хэрэгжсэний дараах буюу хуулийн хэрэгжилтийн явцад гарч буй үр дагавартай харьцуулна.
3.	Хууль хүчин төгөлдөр үйлчилж эхэлснээс хойш	Хууль хүчин төгөлдөр үйлчилж эхэлснээс хойш нөхцөл байдал хэрхэн өөрчлөгдсөнийг он дарааллаар тогтоон харьцуулна.
4.	Тохиолдол судлах	Хууль, эсхүл үнэлгээний хүрээгээр тогтоогдсон зүйл, заалт өөр орчин нөхцөлд (бусад улсад, өөр орон нутагт гэх зэрэг) хэрхэн хэрэгжиж буй байдлыг харьцуулна.

Судалгааны явцад ААНОАТТХ-ийн зарим зүйл, заалтын хэрэгжилтийн үр дагаврыг үнэлэхдээ байх ёстой болон одоо байгаа, хууль тогтоомж батлагдахаас өмнөх болон хууль тогтоомж батлагдсанаас хойших, хууль хүчин төгөлдөр үйлчилж эхэлснээс хойших, тохиолдол судлах харьцуулах хэлбэрийг аль тохирохыг ашиглана. Мөн гадаад орнуудын эрх зүйн зохицуулалт, сайн туршлагыг харьцуулан судална.

Судалгааны явцад хууль тогтоомжоос сонгон авсан зохицуулалтын “байх ёстой” үзүүлэлт практикт хэр байгааг илрүүлэхэд буюу хууль хүчин төгөлдөр үйлчлэхээс өмнөх нөхцөл байдлыг хууль хүчин төгөлдөр хэрэгжсэний дараах буюу хуулийн хэрэгжилтийн явцад гарч буй үр дагавартай харьцуулах харьцуулалтын хэлбэрийг ашиглав.

1.5. Шалгуур үзүүлэлтийг томьёолох

Шалгуур үзүүлэлтийг томьёолохдоо сонгосон шалгуур үзүүлэлт тус бүрээр ААНОАТТХ-ийн сонгон авсан зүйл, хэсэг, заалтад тохируулан дараах таамаглал дэвшүүлж, асуулт боловсрууллаа:

Зорилгод хүрсэн түвшин шалгуур үзүүлэлтийн хүрээнд:

Шалгуур үзүүлэлтийн томьёолол 1. ААНОАТТХ-ийн 15 дугаар зүйлийн 15.7, 15.8 дахь хэсэгт заасан албан татвар ногдох орлогоос хасагдах бусад зардалтай холбоотой зохицуулалт зорилгодоо хүрсэн эсэх.

Шалгуур үзүүлэлтийн томьёолол 2. ААНОАТТХ-ийн 20 дугаар зүйлийн 20.1 дэх хэсэгт заасан албан татварын хувь, хэмжээтэй холбоотой зохицуулалт зорилгодоо хүрсэн эсэх.

Шалгуур үзүүлэлтийн томьёолол 3. ААНОАТТХ-ийн 20 дугаар зүйлийн 20.2.7-д заасан 1 хувиар албан татвар оногдуулахтай холбоотой зохицуулалт зорилгодоо хүрсэн эсэх.

Практикт нийцэж буй байдал шалгуур үзүүлэлтийн хүрээнд:

Шалгуур үзүүлэлтийн томьёолол 1. ААНОАТТХ-ийн 17 дугаар зүйлийн 17.11 дэх хэсэгт заасан хөрөнгийн элэгдэл, хорогдлын шимтгэл тооцох хугацааны зохицуулалт практикт хэрхэн хэрэгжиж байна вэ? Тус зохицуулалтыг хэрэгжүүлэхэд хүндрэл, бэрхшээл тулгарч байгаа эсэх.

Шалгуур үзүүлэлтийн томъёолол 2. Хуулийн 22 дугаар зүйлийн 22.1 дэх хэсэгт заасан албан татварыг 90 хувиар хөнгөлөх зохицуулалт практикт хэрхэн хэрэгжиж байна вэ? (албан татвар ногдуулах босгын дагуу 10 хувь, 25 хувиар албан татварыг ногдуулалт, татварын хувь хэмжээ тохиромжтой эсэх, жижиг дунд үйлдвэрлэл, бизнес эрхлэгчдэд татварын ачаалал хэт их биш байгаа эсэх, том аж ахуйн нэгжүүдэд татварын ачаалал тохиромжтой байгаа эсэх, татварын орлогын төлөвлөгөөний гүйцэтгэл жил бүр биелж байгаа эсэхийг судална)

Шалгуур үзүүлэлтийн томъёолол 3. ААНОАТТХ-ийн 22 дугаар зүйлийн 22.5 дахь хэсэгт заасан албан татварыг хөнгөлөхтэй холбоотой зохицуулалт практикт хэрхэн хэрэгжиж байна вэ? Тус зохицуулалтыг хэрэгжүүлэхэд хүндрэл, бэрхшээл тулгарч байгаа эсэх. /22 дугаар зүйлийн 22.5.1, 22.5.3, 22.5.7-22.5.9 дэх заалтын хүрээнд/

Шалгуур үзүүлэлтийн томъёолол 4. ААНОАТТХ-ийн 26 дугаар зүйлд заасан албан татварыг тайлагнах зохицуулалтууд практикт хэрхэн хэрэгжиж байна вэ? Тус зохицуулалтыг хэрэгжүүлэхэд хүндрэл, бэрхшээл тулгарч байгаа эсэх. /26 дугаар зүйлийн 26.1., 26.2 дахь хэсгийн хүрээнд/

Шалгуур үзүүлэлтийн томъёолол 5. ААНОАТТХ-ийн 29 дүгээр зүйлийн 29.1 дэх хэсэгт заасан татварын хялбаршуулсан горимтой холбоотой зохицуулалт практикт хэрхэн хэрэгжиж байна вэ? Тус зохицуулалтыг хэрэгжүүлэхэд хүндрэл, бэрхшээл тулгарч байгаа эсэх.

Шалгуур үзүүлэлтийн томъёолол 6. Хуулийн 30 дугаар зүйлийн 30.2, 30.8 дахь хэсэгт заасан эцсийн эзэмшигчийн хувьцаа, хувь оролцоог өөрчлөх замаар эрх борлуулсан, шилжүүлсний орлогод эрх борлуулсны орлогын албан татвар ногдуулах заалт практикт хэрхэн хэрэгжиж байна вэ?

1.6. Мэдээлэл цуглуулах аргыг сонгох

Уг үнэлгээний ажилд анхдагч болон хоёрдогч эх сурвалжуудыг хамтатган ашигласан бөгөөд үнэлгээний хүрээнээс хамаарч өөр хоорондоо ялгаатай мэдээллийг ашигласан болно. Хоёрдогч эх сурвалжаар холбогдох хууль тогтоомж, онолын үндэслэл, татварын алба болон татвар төлөгчдөөс хуулийг хэрэгжүүлэхэд үүсдэг тулгамдсан асуудал, хүндрэл, бэрхшээлийг хэлэлцүүлэг, санал асуулгаар тодорхойлсон үр дүн, мэргэжлийн болон салбарын аж ахуйн нэгжүүд, эрдэмтэн, судлаачидтай хийсэн уулзалт, хэлэлцүүлэг, татварын маргаан таслах зөвлөл болон захиргааны хэргийн шүүхийн шийдвэр зэрэг мэдээллийг ашигласан болно.

Мэдээлэл цуглуулах арга:

- Байгаа мэдээллийг цуглуулж ашиглах;
- Холбогдох субъектээс судалгаа авах аргыг сонгон хэрэгжүүллээ.

Байгаа мэдээллийг цуглуулах хүрээнд: Энэ аргын хүрээнд ТЭХ (2019 он), түүний үзэл баримтлал, ААНОАТТХ (2006 он, 2019 он), түүний үзэл баримтлал, ТЭХ-ийн 32 дугаар зүйлд заасан Татварын бүртгэл, мэдээллийн нэгдсэн санд байгаа татвар төлөгчийн бүртгэл, татварын тайлагнал, албан татвар ногдуулалт, төлөлт, албан татварын хөнгөлөлт, чөлөөлөлт, татварын маргаан таслах зөвлөлийн зөрчлийн сангийн судалгаа, захиргааны хэргийн шүүхээр шийдвэрлэгдсэн хэрэг маргааны судалгаа, Зөрчлийн тухай хуулийн дагуу шийтгэл оногдуулсан зөрчлийн судалгаа, УБЕГ-ын мэдээлэл, олон улсын туршлага зэрэг;

Холбогдох субъектээс судалгаа авах хүрээнд: Энэ аргын хүрээнд эрх зүйн зохицуулалтыг хэрэгжүүлэх явцад тулгамдаж буй асуудлыг илрүүлэхийн тулд татвар төлөгч, татварын улсын байцаагчид, эрдэмтэн, судлаач, мэргэжлийн болон салбарын холбоод, том, дунд, жижиг, бичил сегментийн аж ахуйн нэгж, байгууллагууд, мэргэшсэн нягтлан бодогчид болон татварын мэргэшсэн зөвлөхүүдтэй хийсэн олон удаагийн хэлэлцүүлэг, уулзалт,

ярилцлага, нээлттэй санал асуулгаар судалгаа авч, холбогдох байгууллагаас үйл ажиллагааны тайлан, судалгаа, бусад мэдээллийг гаргуулан авч үнэлгээ хийхэд ашиглав.

ХОЁР. ХЭРЭГЖҮҮЛЭХ ҮЕ ШАТ

Хэрэгжүүлэх үе шатны гол зорилго нь хэрэгцээтэй, шаардлагатай байгаа ач холбогдол бүхий мэдээллийг цуглуулан судалснаар хууль тогтоомжийн хэрэгжилтийн явц дахь ололтыг бататгах, түүний хэрэгжилтийн бодит байдалд дүн шинжилгээ хийж, гарч байгаа хүндрэл, бэрхшээлтэй асуудал, нийгэмд үзүүлж байгаа эерэг, сөрөг нөлөөллийг илрүүлэх, цаашид тухайн хууль тогтоомжийг зохистой, үр дүнтэй хэрэгжүүлэх боломжит хувилбарыг тодорхойлох юм.

ХУУЛЬ ТОГТООМЖ, БОДЛОГЫН БАРИМТ БИЧИГ

- Татварын ерөнхий хууль
- Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хууль
- Компанийн тухай хууль
- Зөрчлийн тухай хууль
- Төсвийн тухай хууль
- Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого;
- Монгол Улсын Засгийн Газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр.

ГУРАВ. ҮНЭЛЭХ ҮЕ ШАТ

ААНОАТТХ 2019 оны 03 дугаар сарын 22-ны өдөр батлагдаж, 2020 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн даган мөрдөж эхэлсэн. Хэрэгжилтийн явцад нийтдээ 19 удаагийн хуулиар нэмэлт, өөрчлөлт оруулсан бөгөөд хуулийн хэрэгжилтийн үр дагаварт үнэлгээ хийгээгүй байна.

Иймд ААНОАТТХ-ийн хэрэгжилтийн байдалд судалгаа хийж, татварын хууль тогтоомж хэрэгжүүлэхэд үүссэн хүндрэлтэй асуудал, татвар алба болон татвар төлөгч хооронд маргаан үүсдэг асуудал, олон нийтийн дунд зохион байгуулсан хэлэлцүүлэг, санал, асуулгын үр дүнд үндэслэн ААНОАТТХ-ийн зарим зүйл, заалтыг сонгон авч хэрэгжилтийн үр дагаврыг үнэлэх аргачлалын дагуу үнэлж дүгнэхийг зорьсон болно.

3.1.“ЗОРИЛГОД ХҮРСЭН ТҮВШИН” ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТИЙН ХҮРЭЭНД ҮНЭЛСЭН БАЙДАЛ

Шалгуур үзүүлэлтийн томъёолол 1. ААНОАТТХ-ийн 15 дугаар зүйлийн 15.7, 15.8 дахь хэсэгт заасан албан татвар ногдох орлогоос хасагдах бусад зардалтай холбоотой зохицуулалт зорилгодоо хүрсэн эсэх.

Үнэлгээ: ААНОАТТХ-ийн 15 дугаар зүйлд албан татвар ногдох орлогоос хасагдах бусад зардлын харилцааг зохицуулсан бөгөөд 15.7-д “Эрх бүхий байгууллагаас тогтоосон стандартад нийцсэн олон нийтэд үйлчлэх зориулалт бүхий ариун цэврийн байгууламж шинээр байгуулсан болон засварласантай шууд холбогдон гарсан энэ хуулийн 13 дугаар зүйлд заасан шаардлага хангасан зардлыг 100 хувиар нэмэгдүүлэн албан татвар ногдох орлогоос хасаж тооцно.”, мөн 15.8-д “Ойр орчмын гудамж талбайд эрх бүхий байгууллагаас тогтоосон стандартад нийцсэн хяналтын камер худалдан авч суурилуулахтай шууд холбогдон гарсан энэ хуулийн 13 дугаар зүйлд заасан шаардлага хангасан зардлыг 100 хувиар нэмэгдүүлэн албан татвар ногдох орлогоос хасаж тооцно.” гэж тус тус заасан.

Энэхүү зохицуулалтуудыг ААНОАТТХ-д нэмэлт, өөрчлөлт оруулах тухай 2024 оны 06 дугаар сарын 05-ны өдрийн хуулиар нэмсэн бөгөөд 2025 оны 06 дугаар сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөхөөр хуульчилсан байна.

Иймд, энэхүү хуулийн зохицуулалтууд хүчин төгөлдөр хэрэгжих хугацаа болоогүй тул хэрэгжилтийг үнэлэх боломжгүй юм. Харин Хууль тогтоомжийн тухай хуулийн 24.2-т зааснаар хуулийн давхардлыг арилгах, нийцлийг хангуулах зорилгоор өөрчлөлт оруулах хуулийн төслийг боловсруулах саналтай байна. Үүнд:

ААНОАТтХ-ийн 22 дугаар зүйлийн 22.9 дэх хэсэгт “Албан татвар төлөгчийн орлого олох үйл ажиллагаатай хамааралгүй доор дурдсан үйл ажиллагааг нийгмийн хариуцлагын хүрээнд дэмжих зорилгоор элэгдэл тооцох үндсэн хөрөнгөд оруулсан хөрөнгө оруулалт, харилцан хамааралгүй бусад этгээдэд олгосон санхүүгийн дэмжлэг, хандивын зардлыг энэ хуулийн 20.1-д заасны дагуу ногдуулсан албан татвараас хасаж хөнгөлнө. Хөнгөлөх дүн нь тухайн татварын жилийн татвар ногдох орлогын 1 хувь хүртэл хэмжээнээс хэтрэхгүй байна.

22.9.4.нийтийн эзэмшлийн зам, талбай, цэцэрлэгт хүрээлэн барьж байгуулах, ашиглах, хамгаалах, тохижуулах, цэцэрлэгжүүлэх, нийтийн тээврийн хөгжлийг дэмжих” гэж заасантай хуулийн 15.7, 15.8 дахь хэсгийн зохицуулалтуудыг нэгтгэж, “нийтийн эзэмшлийн зам, талбай, цэцэрлэгт хүрээлэн барьж байгуулах, ашиглах, хамгаалах, олон нийтэд үйлчлэх зориулалт бүхий ариун цэврийн байгууламж шинээр байгуулах болон засварлах, хяналтын камер суурилуулах, тохижуулах, цэцэрлэгжүүлэх, нийтийн тээврийн хөгжлийг дэмжих” гэж өөрчлөн найруулах.

Шалгуур үзүүлэлтийн томъёолол 2. ААНОАТтХ-ийн 20 дугаар зүйлийн 20.1 дэх хэсэгт заасан албан татварын хувь хэмжээтэй холбоотой зохицуулалт зорилгодоо хүрсэн эсэх.

ААНОАТтХ-ийн 20 дугаар зүйлийн 20.1 дэх хэсэгт заасан албан татварын хувь, хэмжээтэй холбоотой зохицуулалт зорилгодоо хүрсэн эсэхийг албан татвар ногдуулах босгын дагуу 10 хувь, 25 хувиар албан татварыг ногдуулалт, татварын хувь хэмжээ тохиромжтой эсэх, жижиг дунд үйлдвэрлэл, том аж ахуйн нэгжүүдэд татварын ачаалал тохиромжтой байгаа эсэх, татварын орлогын төлөвлөгөөний гүйцэтгэл жил бүр биелж байгаа эсэхийг судалж, харин тус зүйлийн 20.2.7 дахь заалтыг ААН бүр өөрт ногдох албан татварыг төлдөг эсэх, ААНОАТ-ын ачааллыг судалж дүгнэсэн болно.

Үнэлгээ: Татварын хувь хэмжээ гэдэг нь татвар ногдуулах нэгж /суурь/-ээс татварын төлбөрийг тодорхойлох хэмжээ юм.²

ААНОАТтХ-ийн 20 дугаар зүйлд албан татварын хувь хэмжээг тодорхойлсон бөгөөд тус зүйлийн 20.1-д “Энэ хуулийн 18.2, 18.3, 18.4, 18.5-д заасны дагуу тодорхойлоход 0-6 тэрбум төгрөгийн албан татвар ногдуулах тухайн жилийн орлого олсон тохиолдолд 10 хувиар, 6 тэрбум төгрөгөөс дээш албан татвар ногдуулах тухайн жилийн орлого олсон тохиолдолд 600 сая төгрөг дээр 6 тэрбумаас дээш давсан орлогод 25 хувиар нэмж албан татвар ногдуулна” гэж заажээ.

Татварын хувь хэмжээ нь орлогын хэмжээгээр өөрчлөгддөг нь жижиг, дунд аж ахуйн нэгжүүдийн хувьд эерэг нөлөө үзүүлэх зорилгоор хуульчлагдсан. Тухайлбал, 0-6 тэрбум төгрөгийн орлоготой аж ахуйн нэгжид 10 хувийн татвар ногдуулдаг нь эдгээр компанид татварын ачааллыг бууруулах, бизнесийн орчныг дэмжих боломжийг бүрдүүлдэг. Энэ нь жижиг бизнесүүдийн өсөн нэмэгдэх боломжийг дэмжих зорилготой байна. Харин 6 тэрбум төгрөгөөс дээш орлоготой аж ахуйн нэгжүүдийн хувьд татварын хувь хэмжээ 25 хувьд хүрч байгаа нь төсвийн орлогыг нэмэгдүүлэх, мөн томоохон орлоготой компаниудаас илүү татварын ачааллыг үүрдэг байхад чиглэсэн зохицуулалт юм.

ААНОАТ нь дунджаар Татварын нийт орлогын 31 гаруй хувийг бүрдүүлдэг бөгөөд ААНОАТ-ын орлого бүрдүүлэлтийг 2020-2023 оны эдийн засгийн салбараар ангилан үзэхэд уул уурхайн салбар нийт татварын 52.4 хувийг бүрдүүлж байна.

² П.Одгэрэл, Татварын эрх зүйн ерөнхий анги /Захиргааны ерөнхий хууль ба Татварын ерөнхий хууль/, 29 дэх тал.

Хуулийн хэрэгжилтийн хугацаанд буюу 2020-2023 оны тайлагналаар, 0-6 тэрбум төгрөгийн албан татвар ногдуулах орлого олсон 151,891 татвар төлөгчөөс 10 хувиар татвар ногдуулж, нийт 896.3 тэрбум төгрөгийн татвар төлөгдсөн байна. Мөн 6 тэрбум төгрөгөөс дээш албан татвар ногдуулах орлого олсон 399 татвар төлөгчөөс шаталсан хувь хэмжээгээр татвар ногдуулж, нийт 5,233.6 тэрбум төгрөгийн татвар төлөгдсөн байна.

Шаталсан хувиар албан татвар ногдуулж, төлдөг татвар төлөгчийн тоо 2020-2023 он тус бүрийн тайлагналыг тодруулбал, 2020 онд 336, 2021 онд 349, 2022 онд 376, 2023 онд 399 татвар төлөгч шаталсан хувиар татвар төлсөн байна. Мөн шаталсан хувиар татвар төлдөг аж ахуйн нэгжийг салбарын ангиллаар үзэхэд, уул уурхайн салбар чухал байр суурийг эзэлж байна.

ААНОАТ-ын 2023 оны төлөвлөгөөний биелэлтээр үнэлэхэд, нийт ногдлын 70.4 хувь нь хугацаандаа төсөвт төлөгдсөн бөгөөд үлдэх 29.6 хувь нь хуулийн хугацаанд төлөөгүй байна.

"Татварын хуулийн шинэчлэл-2025" хэлэлцүүлэг, санал асуулгын үр дүнгээс харахад, тус хуулийн 20.1-д заасан татварын хувь хэмжээг бууруулах эсхүл шаталсан хувийг бууруулах, мөн 6 тэрбум төгрөгийн албан татвар ногдуулах орлогын босгыг нэмэгдүүлэхтэй холбоотой саналууд ирсэн байна.

Түүнчлэн, татвар төлөгчид шаталсан хувиар албан татварыг төлөхөөс зайлсхийх зорилгоор үйл ажиллагааны чиглэлийг тусгаарлах, хуваах замаар компаниа жижиглэх хэлбэрт шилжиж, татварын ачааллаа бууруулах арга замыг эрэлхийлж болзошгүй эрсдэлтэй.

Энэхүү асуудлыг шийдвэрлэхийн тулд шатлалын босгыг нэмэгдүүлэх шаардлагатай. Учир нь 2019 онд батлагдсан хуулийн шатлалын босго 2025 оны байдлаар бараа бүтээгдэхүүний үнэ болон инфляцийн түвшинтэй харьцуулахад өөрчлөгдөөгүй байна. Энэ нь 0-6 тэрбум болон 6 тэрбум төгрөгөөс дээш шатлалын босгыг нэмэгдүүлэх шаардлагатайг илэрхийлж байна.

Тус зохицуулалтыг албан татвар ногдуулах босгын дагуу 10 хувь, 25 хувиар албан татварын ногдуулалт, татварын хувь хэмжээ тохиромжтой эсэх, жижиг дунд үйлдвэрлэл, том аж ахуйн нэгжүүдэд татварын ачаалал тохиромжтой байгаа эсэх, татварын орлогын төлөвлөгөөний гүйцэтгэл жил бүр биелж байгаа эсэхийг судлан дүгнэхэд тус зохицуулалтын дагуу татвар төлөхөөс зайлсхийж байж болзошгүй нөхцөл байдал тогтоогдож байгаа нь тус зохицуулалтыг зорилгодоо хангалттай хүрч чадахгүй байгааг илэрхийлж байна.

Нөгөөтээгүүр, төрийн татвар хураах үйл ажиллагаа нь шударга ёсыг эрхэмлэсэн, ил тод, бүгдэд ойлгомжтой, татварын дарамт адил тэгшээр хуваарилагдсан байж хэмээн иргэдэд хүлээн зөвшөөрөгддөг³ гэдгийг харгалзан үзэж татвар төлөгчийн хувьд татварыг зөвтгөж, хүлээн зөвшөөрөх нөхцөлийг бүрдүүлэх нь чухал юм.⁴ Тиймээс энэхүү зохицуулалтыг эдийн засгийн нөхцөл байдалд нийцүүлэн, нэмэлт, өөрчлөлт оруулах шаардлагатай гэж үзэж байна.

Шалгуур үзүүлэлтийн томъёолол 3. ААНОАТтХ-ийн 20 дугаар зүйлийн 20.2.7 дахь заалтад заасан 1 хувиар албан татвар ногдуулахтай холбоотой зохицуулалт зорилгодоо хүрсэн эсэх.

Тус зохицуулалтыг зорилгодоо хүрсэн эсэхийг хууль хүчин төгөлдөр үйлчилж эхэлснээс хойш практикт хэрэгжсэн байдал болон ААН бүр өөрт ногдох албан татварыг төлдөг эсэх, албан татварын ачаалал, татварын орлогын төлөвлөгөөний гүйцэтгэлийн өсөлт, бууралтын хувь, ААНОАТ-ын ачааллыг судалж дүгнэлт өгсөн болно.

³ П.Одгэрэл, Татварын эрх зүйн ерөнхий анги /Захиргааны ерөнхий хууль ба Татварын ерөнхий хууль/, 14 дэх тал.

⁴Мөн тэнд, 13 дахь тал.

Үнэлгээ: ААНОАТХ-ийн 20 дугаар зүйлийн 20.2.7-д “энэ хуулийн 20.1-д заасныг үл харгалзан энэ хуулийн 18.2, 18.3, 18.4, 18.5-д заасан жилийн 300 сая төгрөг хүртэл албан татвар ногдох орлого олсон, энэ хуулийн 22.1.1, 22.1.2, 22.1.3-т зааснаас бусад салбарт үйл ажиллагаа явуулж байгаа албан татвар төлөгчийн тухайн албан татвар ногдуулах орлогод 1 хувиар” албан татварыг ногдуулна гэж заасан.

Шинэчлэн найруулсан тус хуулийн төслийн үзэл баримтлалд “...одоо байгаа татварын ачааллыг бууруулах замаар татварын суурийг өргөжүүлэх зарчмыг баримтална. Мөн 2006 оны ААНОАТХ-аар бүх аж ахуйн нэгж нэгэн ижил тайлангийн маягаар, ижил хугацаанд тайлагнаж, төлдөг тул жижиг, дунд хэмжээний аж ахуйн нэгжүүдийн татвар төлөх, тайлагнахтай холбогдсон зардлууд хүндрэл учруулдаг. Жижиг, дунд аж ахуйн нэгжийн үйл ажиллагааг дэмжих, тэдний татвар төлөхтэй холбоотой зардлыг бууруулах, тайлагналын ажиллагааг хялбарчлах зорилгоор хялбаршуулсан татварын тайлагнал, төлөлтийн заалтуудыг хуулийн төсөлд тусгалаа.” гэжээ.


Өөрөөр хэлбэл, шинэчлэн найруулсан ААНОАТХ-ийн 20 дугаар зүйлийн 20.2.7-д заасан энэхүү зохицуулалт нь ААН-ийн татвар төлөхтэй холбоотой зардлыг бууруулах, тайлагналыг илүү хялбарчлах зорилготой зохицуулалт юм.

Хүснэгт 4. ААНОАТ-ын тайлагналын мэдээ (2020-2023 он)

Утга	2020 он	2021 он	2022 он	2023 он
Татвар төлөгчийн тоо	31,445	32,197	36,019	39,738
Ногдлын дүн (тэрбум төгрөгөөр)	6.9	12	14.7	17.9

2023 онд нийт 39,738 аж ахуйн нэгж орлогын албан татварын тайлагнал ирүүлсэн бөгөөд ногдлын дүн 17.9 тэрбум төгрөг байна. Энэ нь өмнөх онтой харьцуулахад аж ахуйн нэгж 3719 буюу 10.3 хувиар, ногдлын дүн 3.2 тэрбум төгрөг буюу 21.8 хувиар тус тус өссөн үзүүлэлттэй байна.

График 1. ААНОАТ-ын тайлагналын мэдээ (2020-2023 он)



Дээрх тоон үзүүлэлтээр ААНОАТ-ын тайлагналаар 2020-2023 онд тус тус татвар төлөгчийн тоо болон ногдлын дүн тогтмол өссөн үзүүлэлттэй байна.

ААНОАТ-ын 2023 оны тайланг 154,782 татвар төлөгч тушааж, тайлангийн ирц 83.8 хувь байх бөгөөд 83.8 хувь нь ААНОАТХ-ийн 20.2.7 дахь заалтад хамаарч тайлагнасан байна.

“Татварын хуулийн шинэчлэл-2025” хэлэлцүүлэг, санал асуулгын үр дүнгийн нэгтгэлд жижиг, дунд бизнес эрхлэгч ААН-үүдийн эдийн засагт эзлэх хувь оролцоог дээшлүүлэх,

татварын бодлогоор дэмжиж татвар ногдох орлогын босгыг нэмэгдүүлэх замаар 1 хувиар албан татвар төлөгчдийн хамрагдалтыг нэмэгдүүлэх саналыг гаргасан.

Хэрэв ААНОАТТХ-ийн 22 дугаар зүйлийн 22.1 дэх хэсэгт заасан албан татвар ногдох орлогын 1.5 тэрбум төгрөгийн босгыг ЖДҮҮДТХ-ийн 4.1.1-д заасан жилийн 2.5 тэрбум төгрөг хүртэл борлуулалтын орлоготой уялдуулсан тохиолдолд энэхүү 20.2.7 дахь заалт цаашид байх эсэхийг тодорхойлох шаардлагатай.

3.2. “ПРАКТИКТ НИЙЦЭЖ БАЙГАА БАЙДАЛ” ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТИЙН ХҮРЭЭНД ҮНЭЛСЭН БАЙДАЛ

Практикт нийцэж буй байдал шалгуур үзүүлэлтийн хүрээнд ААНОАТТХ-ийн дараах зүйл, хэсэг, заалтууд практикт хэрхэн хэрэгжиж байгаа болон хэрэгжилтэд үүсдэг тулгамдсан асуудлыг судлан үзнэ.

Шалгуур үзүүлэлтийн томъёолол 1. ААНОАТТХ-ийн 17 дугаар зүйлийн 17.11 дэх хэсэгт заасан хөрөнгийн элэгдэл, хорогдлын шимтгэл тооцох хугацааны зохицуулалт практикт хэрхэн хэрэгжиж байна вэ? Тус зохицуулалтыг хэрэгжүүлэхэд хүндрэл, бэрхшээл тулгарч байгаа эсэх.

Үнэлгээ: ААНОАТТХ-ийн 17 дугаар зүйлд албан татвар төлөгчийн нэг ба түүнээс дээш жилийн хугацаанд ашиглах хөрөнгөд элэгдэл, хорогдлыг ашиглах нийт хугацаа /жилээр/-гаар тооцохоор зохицуулсан бөгөөд 17.11-т “Албан татвар төлөгчийн тухайн улиралд шинээр эзэмшсэн хөрөнгийн элэгдэл, хорогдлын шимтгэлийг дараагийн сарын эхний өдрөөс эхлэн тооцно.” гэж заасан.

Энэхүү хуулийн зохицуулалтыг хэрэгжүүлэхэд татвар төлөгч болон татварын алба хооронд зөрүүтэй ойлголт үүсгэдэг байна. Тодруулбал: ААН-ийн 2020 оны 2 дугаар сард эзэмшсэн хөрөнгийн элэгдэл, хорогдлын шимтгэлийг хэзээнээс эхлэн тооцох вэ? гэсэн асуудлыг татвар төлөгчөөс тавьсан байна. Энэ тохиолдолд тухайн улирлын дараа сар буюу 2020 оны 4 дүгээр сараас эхлэн элэгдэл тооцох уу?, эсхүл 2020 оны 3 дугаар сараас эхлэн элэгдэл тооцох уу ? гэдэгт эргэлзээ үүсгэдэг байна.

Шинэ хөрөнгийн элэгдэл, хорогдлыг тооцох хугацаа нь тухайн хөрөнгө хэр удаан ашиглагдах боломжтойг харуулдаг бөгөөд энэ зохицуулалт нь тэрхүү хөрөнгийн ашиглалтын эхнээс эхлэн хуримтлагдах шимтгэлийг тооцоолох боломжийг олгодог байна.

Иймд, хуулийг нэг мөр хэрэгжүүлэх нөхцөлийг бүрдүүлэх зорилгоор ААНОАТТХ-ийн 17.11 дэх хэсгийг “Албан татвар төлөгчийн шинээр эзэмшсэн хөрөнгийн элэгдэл, хорогдлын шимтгэлийг дараагийн сарын эхний өдрөөс эхлэн тооцно.” гэж өөрчлөн найруулах нь зүйтэй байна. Энэ нь тодорхой хугацаанд татвар төлөгчийн татварын ачаалал буурах боломжийг бий болгох бөгөөд зарим бизнесийн хувьд энэ нь санхүүгийн нөхцөл байдлыг сайжруулж, хөрөнгө оруулалт хийх боломжийг олгох юм.

Шалгуур үзүүлэлтийн томъёолол 2. ААНОАТТХ-ийн 22 дугаар зүйлийн 22.1 дэх хэсэгт заасан албан татварын хөнгөлөлттэй холбоотой зохицуулалт практикт хэрхэн хэрэгжиж байна вэ? Тус зохицуулалтыг хэрэгжүүлэхэд хүндрэл, бэрхшээл тулгарч байгаа эсэх.

Тус зохицуулалтын хэрэгжилтийг албан татвар ногдуулах босгын дагуу 10 хувь, 25 хувиар албан татварыг ногдуулалт, татварын хувь хэмжээ тохиромжтой эсэхийг судална.

Үнэлгээ: ААНОАТТХ-ийн 22 дугаар зүйлийн 22.1-д “Энэ хуулийн 18.2, 18.3, 18.4, 18.5-д заасан албан татвар ногдох орлогыг 1.5 тэрбум төгрөгөөс ихгүй байхаар жилийн эцсийн татварын тайланд тусгасан, доор дурдсанаас бусад салбарт үйл ажиллагаа явуулдаг, энэ хуулийн 20.2.7-д зааснаас бусад Монгол Улсын хуулийн дагуу үүсгэн байгуулагдсан албан татвар төлөгчийн энэ хуулийн 20.1-д заасны дагуу ногдуулсан албан татварыг 90 хувиар хөнгөлнө.” гэж заасан.

Тус зохицуулалтыг татвар төлөгчийн татварын дарамтыг бууруулж, салбарын хөгжилд эерэг нөлөө үзүүлэх, жижиг, дунд бизнесүүд хөнгөлөлтийг ашиглан санхүүгийн ачааллаа багасгах зорилгоор хуульчилсан бөгөөд практикт албан татвар төлөгч нь хуулийн хугацаанд тухайн татварын жилд ногдуулсан албан татварыг төлсөн тохиолдолд төлсөн татварын 90 хувийг буцаан авах замаар энэхүү хөнгөлөлтийг эдэлж байна. Өөрөөр хэлбэл, татвар төлөгч хуулиар хүлээсэн үүргээ биелүүлсэн тохиолдолд хуульд заасан хөнгөлөлт эдлэх эрхээ хэрэгжүүлэх нь татвар төлөгчийг хариуцлагажуулсан зохицуулалт болсон.

Харин татвар төлөгч хуульд заасан хугацаанд татвар төлөөгүй, үнэн зөв тайлагнах үүргээ хэрэгжүүлээгүй дутуу ногдуулж төлсөн зэргээс хамаарч энэхүү хөнгөлөлтөд хамрагдах боломжгүй байдаг.

Хүснэгт 5. ААНОАТмХ-ийн 22.1-д заасан албан татварын хөнгөлөлтийн мэдээ, сая төгрөгөөр (2020-2023 он)

Утга	2020 он	2021 он	2022 он	2023 он
ААН-ийн тоо	297	2491	3943	3865
Хөнгөлөлтийн дүн (сая төгрөгөөр)	2,031.90	36,591.19	59,374.50	68,567.39

2023 онд 3,865 ААН, нийт 68,567.39 сая төгрөгийн албан татварын хөнгөлөлтөд хамрагдсан байна. Үүнийг өмнөх онтой харьцуулахад ААН-ийн тоо 78 буюу 2 хувиар, хөнгөлөлтийн дүн 9,192.89 сая төгрөг буюу 15.5 хувиар өссөн байна. Түүнчлэн, 2023 онд хөнгөлөлт эдэлсэн татвар төлөгчийн тоо 2020 оноос 92 хувиар, хөнгөлөлтийн дүн мөн оноос 97 хувиар тус тус өссөн байна.

Тус зохицуулалт хууль хүчин төгөлдөр үйлчилж эхэлснээс хойш практикт тодорхой үр дүнтэй хэрэгжсэн байна. Гэвч практикт албан татварын хөнгөлөлтөд хамрагдахын тулд албан татвар ногдох орлогын босготой холбоотойгоор компанийн үйл ажиллагааг тусгаарлах, компанийг жижиглэн олон компани байгуулах, зарим тохиолдолд борлуулалт хийх тухай бүрд төлбөрийн баримт олгохгүй орлогоо нуух гэх мэт асуудлууд үүсэх эрсдэлтэй байна.

Олон нийтийн хэлэлцүүлэг, санал асуулгын үр дүнгийн нэгтгэлээс үзэхэд, албан татвар ногдох орлого 1.5 тэрбум төгрөгөөс ихгүй байх босго, хамрагдалтын түвшин, болон татварын орлогын бааз суурийг нэмэгдүүлэх саналыг гаргасан байна.

Энэхүү зохицуулалт хэрэгжиж эхэлснээс хойш зарим салбарт эерэг нөлөө үзүүлж байгаа боловч төсвийн санхүүгийн тогтвортой байдлын үүднээс эрсдэл үүсгэж болохыг анхааран үзэж, зохицуулалт хийх шаардлагатай.

Нөгөөтээгүүр, ААНОАТтХ-ийн 22 дугаар зүйлийн 22.1 дэх хэсэгт заасан албан татварын чөлөөлөлттэй холбоотой зохицуулалтын жижиг, дунд бизнес эрхлэгчдийг татварын бодлогоор дэмжих, татварын ачааллыг бууруулах зорилгоор хуульчилсан.

Харин Жижиг, дунд үйлдвэрлэл, үйлчилгээг дэмжих тухай хуулийн 4.1.1-д "жижиг, дунд үйлдвэр, үйлчилгээ эрхлэгч" гэж 200 хүртэл ажилтантай, жилийн 2.5 тэрбум төгрөг хүртэл борлуулалтын орлоготой, үйлдвэрлэл, худалдаа, үйлчилгээний салбарт үйл ажиллагаа явуулдаг аж ахуйн нэгжийг" ойлгоно гэж тодорхойлсон байна.

Иймд ААНОАТтХ-ийн 22 дугаар зүйлийн 22.1-д заасан албан татвар ногдох орлогыг Жижиг, дунд үйлдвэрлэл, үйлчилгээг дэмжих тухай хуулийн 4.1.1-д заасан зохицуулалттай уялдуулан, хууль хоорондын харилцан уялдааг хангах нь зүйтэй.

Шалгуур үзүүлэлтийн томъёолол 3. ААНОАТтХ-ийн 22 дугаар зүйлийн 22.5 дахь хэсэгт заасан албан татварыг хөнгөлөхтэй холбоотой зохицуулалт практикт хэрхэн хэрэгжиж байна вэ? Тус зохицуулалтыг хэрэгжүүлэхэд хүндрэл, бэрхшээл тулгарч байгаа эсэх. /22 дугаар зүйлийн 22.5.3, 22.5.7-22.5.9 дэх заалтын хүрээнд/

Үнэлгээ: ААНОАТХ-ийн 22 дугаар зүйлийн 5 дахь хэсэгт албан татварын хөнгөлөлт үзүүлэх 22 үндэслэлийг тусгасан. Албан татварын хөнгөлөлттэй холбоотой дээрх 22 үндэслэлээс 2023 онд 9 үндэслэлээр 4,585 татвар төлөгч 160,303.0 сая төгрөгийн хөнгөлөлтөд хамрагдаж байгаа бөгөөд 6 үндэслэлээр хөнгөлөлтөд хамрагдсан ААН бүртгэгдээгүй бөгөөд тус албан татварыг хөнгөлөх зохицуулалтад тусгагдсан үлдсэн 7 үндэслэл нь 2024, 2025 онд дагаж мөрдөгдөхөөр хуульчлагдсан учир одоогоор хөнгөлөлтөд хамрагдсан ААН-ийн тоо гараагүй байна.

Иймд 2024 онд хэрэгжиж эхэлсэн болон 2025 онд хэрэгжиж эхлэх албан татварын чөлөөлөлттэй холбоотой зохицуулалтыг энэхүү үнэлгээний хүрээнд судлан үзээгүй бөгөөд одоо практикт хэрэгжиж буй 15 үндэслэлээс практик хэрэгжилт хангалтгүй 5 /22 дугаар зүйлийн 22.5.3, 22.5.7-22.5.9 дэх заалт/ үндэслэлийг сонгон авч үнэлсэн болно.

- ААНОАТХ-ийн 22 дугаар зүйлийн 22.5.3 дахь заалт

Тус зохицуулалтад “Байгалийн нөөцийг хэмнэлттэй ашиглах, орчны бохирдол, хаягдлыг багасгах, байгальд ээлтэй техник, тоног төхөөрөмжийг борлуулсны орлого”-д ногдох албан татварыг хөнгөлнө гэж заасан. Мөн хуулийн 22 дугаар зүйлийн 22.6 дахь хэсэгт “Энэ хуулийн 22.5.3, 22.5.4, 22.5.13-т заасан техник, тоног төхөөрөмж, бүтээгдэхүүн, ажил, үйлчилгээний жагсаалтыг Засгийн газар батална.” гэж хуулиар тусгайлан эрх олгосны дагуу Засгийн газар 2019 оны 468 дугаар тогтоолын хавсралтаар “Байгалийн нөөцийг хэмнэлттэй ашиглах, орчны бохирдол, хаягдлыг багасгах, байгальд ээлтэй техник, тоног төхөөрөмжийн жагсаалт”-ыг баталсан байна. Тус жагсаалтаар нийт 59 төрлийн тоног төхөөрөмжийг нэрлэж заасан бөгөөд хэрэгжилтийн хугацаанд нэмэлт, өөрчлөлт оруулаагүй байна.

Татварын албанаас тус хуулийн заалтын хэрэгжилтийг хангуулахтай холбогдсон тулгамдсан асуудал үүсээгүй бөгөөд хууль хүчин төгөлдөр үйлчилж эхэлснээс хойш хуулийн 22.5-д заасны дагуу хөнгөлөлт эдэлсэн тоо, дүнг авч үзэхэд, нийт 22 төрлийн хөнгөлөлтөөс 2023 онд 9 төрлөөр 4,585 татвар төлөгч 160,303.0 сая төгрөгийн хөнгөлөлтөд хамрагдаж, 6 төрөлд хөнгөлөлт эдлээгүй, 2024, 2025 онд дагаж мөрдөх нийт 7 хөнгөлөлт байна.

Үүнээс хуулийн 22.5.3-д заасны дагуу албан татварын хөнгөлөлт эдэлсэн ААН 2020-2023 онд давхардсан тоогоор нийт 7 ААН 177.81 сая төгрөгийн хөнгөлөлт эдэлсэн байна. Тодруулбал, 2021 онд 3 ААН 25.53 сая төгрөгийн, 2022 онд 1 ААН 7.05 сая төгрөгийн, 2023 онд 3 ААН 145.23 сая төгрөгийн хөнгөлөлтийг эдэлсэн байна. Энэ нь 2023 онд нийт хөнгөлөлт эдэлсэн татвар төлөгчийн 0.06 хувийг эзэлж байна.

Тус хуулийн 22.5.3 дахь заалтын зорилго нь ААН-үүдийг байгаль орчинд ээлтэй үйл ажиллагаа явуулахад урамшуулах, татварын таатай орчин бүрдүүлэх замаар экологид ээлтэй бизнесийг хөхиүлэн дэмжих, уур амьсгалын өөрчлөлт, хүрээлэн буй орчны доройтлын эсрэг тэмцэх, цэвэр технологи, инновацийг нэвтрүүлэхэд төрөөс үзүүлэх дэмжлэгийн нэг хэлбэр юм. Ногоон эдийн засгийн загварт шилжих, тогтвортой хөгжлийн зорилтуудыг биелүүлэхэд бодитой хувь нэмэр оруулах зорилготой.

Дээрх үзэл баримтлалын хүрээнд байгальд ээлтэй техник, тоног төхөөрөмжийг борлуулсан орлогод ногдох албан татварыг хөнгөлөх замаар аж ахуйн нэгжүүдийг урамшуулж, ногоон хөгжлийг дэмжихэд чиглэсэн байна.

Гэвч, практикт хөнгөлөлтийн зохицуулалт нь үр ашиггүй, хуулийн зорилгодоо хүрч хэрэгждэггүй, цаашид байх зайлшгүй хэрэгцээ шаардлага тогтоогдохгүй байна.

- ААНОАТХ-ийн 22 дугаар зүйлийн 22.5.7, 22.5.8 дахь заалт

ААНОАТХ-ийн 22 дугаар зүйлийн 22.5-д “Дараах орлогод албан татварын хөнгөлөлт үзүүлнэ” гэж заасан бөгөөд 22.5.7-д “чөлөөт бүсэд зориулсан эрчим хүч, дулааны эх үүсвэр, шугам сүлжээ, цэвэр усан хангамж, ариутгах татуурга, авто зам, төмөр зам, нисэх онгоцны буудал, харилцаа холбооны үндсэн сүлжээ зэрэг дэд бүтцэд 500.0 мянган америк доллар буюу

түүнээс дээш хэмжээний хөрөнгө оруулсан аж ахуйн нэгжийн чөлөөт бүсээс олсон орлогод оруулсан хөрөнгө оруулалтын 50 хувьтай тэнцэх хэмжээний орлогод ногдох албан татварыг” гэж, 22.5.8-д “чөлөөт бүсэд агуулах, ачиж буулгах байгууламж, зочид буудал, аялал жуулчлалын цогцолбор, импортыг орлох болон экспортын бүтээгдэхүүний үйлдвэр байгуулахад 300.0 мянган америк доллар буюу түүнээс дээш хэмжээний хөрөнгө оруулсан аж ахуйн нэгжийн чөлөөт бүсээс олсон орлогод оруулсан хөрөнгө оруулалтын 50 хувьтай тэнцэх хэмжээний орлогод ногдох албан татварыг” гэж тус тус заасан.

Дээрх зохицуулалтуудыг манай улсад чөлөөт бүс байгуулах, тухайн бүсэд эрх зүй, хөрөнгө оруулалтын таатай орчныг бүрдүүлснээр иргэн, аж ахуйн нэгжийн экспорт, импортыг дэмжих, экспортын чиглэлийн үйлдвэрлэлийг хөгжүүлэх, худалдаа, үйлчилгээний шинэ салбар, аялал жуулчлал, хөрөнгө оруулалтыг татах, транзит тээвэр, логистикийг нэмэгдүүлэх, тэргүүний техник, технологийг нутагшуулах, худалдааг хөнгөвчлөх, бүс нутгийн хөгжлийг хурдасгах замаар эдийн засгийн өсөлтийг нэмэгдүүлэх зорилгоор хуульчилсан байна.

ААНОАТТХ хэрэгжиж эхэлснээс хойш дээрх зохицуулалтын дагуу 2020-2023 онд хөнгөлөлт эдэлсэн ААН байхгүй байна. Тус хөнгөлөлтийн заалтууд нь энэ хуульд шинээр тусгагдсан зохицуулалт биш бөгөөд 2006 оны ААНОАТТХ-д нэмэлт оруулах тухай 2012 оны хуулиар 18.1.13, 18.1.14 дахь заалтаар шинээр хөнгөлөлт үзүүлэхээр тусгасан байдаг.

Өөрөөр хэлбэл, 2012 оноос хойш өнөөдрийг хүртэл энэхүү зохицуулалтын дагуу татварын хөнгөлөлтөд хамрагдсан ААН байхгүй байна. Энэ нь тус хуулийн дээрх зохицуулалтууд практикт огт хэрэгждэггүй болохыг илэрхийлж байна.

- **ААНОАТТХ-ийн 22 дугаар зүйлийн 22.5.9 дэх заалт**

-

Тус хуулийн 22 дугаар зүйлийн 22.5.9-д “тодорхой нутаг дэвсгэрийн усны нөөцийг нэмэгдүүлэх, усны найдвартай хангамжийг бүрдүүлэх зорилгоор байгалийн усны чанарыг сайжруулах, гол, горхийг нөхөн сэргээх арга хэмжээг санхүүжүүлсэн иргэн, аж ахуйн нэгж, байгууллагын тухайн арга хэмжээнд зарцуулсан хэмжээний орлого”-д ногдох албан татварыг хөнгөлнө гэж заасан бөгөөд энэхүү үндэслэлээр 2020-2022 онуудад албан татварын чөлөөлөлтөд хамрагдсан ААН-ийн тоо бүртгэгдээгүй бөгөөд харин 2023 онд 1 аж ахуйн нэгж 75.0 сая төгрөгийн хөнгөлөлт эдэлсэн байна.

Өөрөөр хэлбэл, Татварын албанд бүртгэлтэй нийт хөнгөлөлт эдэлсэн 4585 ААН-ийн зөвхөн 1 ААН нь тус заалтын хүрээнд хөнгөлөлт эдэлсэн үзүүлэлттэй байна.

ААНОАТТХ-д 2024 оны 08 дугаар сарын 30-ны өдрийн хуулиар нэмэлт, өөрчлөлт оруулж, тус хуулийн 22 дугаар зүйлийн 22.9 дэх хэсэгт “Албан татвар төлөгчийн орлого олох үйл ажиллагаатай хамааралгүй доор дурдсан үйл ажиллагааг нийгмийн хариуцлагын хүрээнд дэмжих зорилгоор элэгдэл тооцох үндсэн хөрөнгөд оруулсан хөрөнгө оруулалт, харилцан хамааралгүй бусад этгээдэд олгосон санхүүгийн дэмжлэг, хандивын зардлыг энэ хуулийн 20.1-д заасны дагуу ногдуулсан албан татвараас хасаж хөнгөлнө. Хөнгөлөх дүн нь тухайн татварын жилийн татвар ногдох орлогын 1 хувь хүртэл хэмжээнээс хэтрэхгүй байна: 22.9.1.ой, амьтан, ус зэрэг байгалийн баялаг хамгаалах, нөөцийг нэмэгдүүлэх, зохистой ашиглах, нөхөн сэргээх, агаар, ус, хөрсний бохирдлыг бууруулах, цөлжилтийг сааруулах” бөгөөд 22.10-т “Энэ хуулийн 22.9.1-д заасан нөхөн сэргээх зардалд энэ хуулийн 13.4, 22.5.9-д зааснаас бусад нөхөн сэргээх зардал хамаарна.” гэж тус тус заажээ.

Энэхүү зохицуулалтыг тус хуулийн 22 дугаар зүйлийн 22.5.9-д заасан зохицуулалттай агуулгын хувьд давхардсан гэж үзэж болох юм. Нөгөөтээгүүр, ААНОАТТХ-ийн 22 дугаар зүйлийн 22.5.9-д заасан зохицуулалт практик хэрэгжилт хангалтгүй, цаашид байх зайлшгүй хэрэгцээ шаардлага тогтоогдохгүй байна.

Шалгуур үзүүлэлтийн томъёолол 4. ААНОАТТХ-ийн 26 дугаар зүйлд заасан албан татварыг тайлагнах зохицуулалтууд практикт хэрхэн хэрэгжиж байна вэ? Тус зохицуулалтыг

хэрэгжүүлэхэд хүндрэл, бэрхшээл тулгарч байгаа эсэх. /26 дугаар зүйлийн 26.1, 26.2 дахь хэсгийн хүрээнд/

Үнэлгээ: ААНОАТХ-ийн 26 дугаар зүйлд албан татварын тайлагнах хугацааг зохицуулсан бөгөөд тус зүйлийн 26.1-д “Өмнөх татварын жилийн албан татвар ногдуулах орлого нь 6 тэрбум төгрөг ба түүнээс дээш бол уг албан татвар төлөгч тухайн татварын жилийн улирлын татварын тайланг дараагийн улирлын эхний сарын 20-ны дотор, жилийн эцсийн татварын тайланг дараа оны 02 дугаар сарын 10-ны дотор харьяалах татварын албанд хүргүүлнэ.” гэж, 26.2-т “Татварын өмнөх жилийн албан татвар ногдуулах орлого нь 6 тэрбум төгрөг хүртэл энэ хуулийн 29.1-д заасны дагуу татварын албанд бүртгүүлээгүй албан татвар төлөгч тухайн татварын жилийн эхний хагас жилийн татварын тайланг 07 дугаар сарын 20-ны дотор, жилийн эцсийн татварын тайланг дараа оны 02 дугаар сарын 10-ны дотор гаргаж, харьяалах татварын албанд хүргүүлнэ.” гэж тус тус заасан.

Тус зохицуулалтуудын дагуу 2020-2023 онд ирүүлсэн тайланг судлан үзэхэд:

Хүснэгт 6.ААНОАТ-ын тайлангийн ирцийн мэдээ (2020-2023 он)

Он	Тайлагнавал зохих тоо	Тайлагнасан тоо	Үүнээс		Хэрэгжилтийн хувь
			Хугацаандаа тайлагнасан тоо	Хугацаа хоцроосон тоо	
2020	198,839	131,824	88,939	42,885	44.7
2021	209,937	145,218	128,538	16,680	61.2
2022	225,431	156,582	145,815	10,767	64.7
2023	215,388	159,669	152,172	7,497	70.7

2020 онд ААНОАТ тайлагнавал зохих 198,839 ААН-ээс 131,824 буюу 66.3 хувь нь, 2021 онд 209,937 ААН-ээс 145,218 буюу 69.2 хувь нь, 2022 онд 225,431 ААН-ээс 156,582 буюу 69.5 хувь нь, 2023 онд 215,388 ААН-ээс 159,669 буюу 74.1 хувь нь тус тус албан татвараа тайлагнасан байна.

Харин 2020 онд албан татвараа тайлагнасан ААН-ийн 88,939 буюу 67.5 хувь нь хугацаандаа, 42,885 буюу 32.5 хувь нь хугацаа хоцроосон бол 2021 онд 16,680 буюу 11.5 хувь нь, 2022 онд 10,767 буюу 6.9 хувь нь, 2023 онд 7497 буюу 4.7 хувь нь хугацаа хоцроосон байна.

Түүнчлэн, Татварын ерөнхий хуулийн 29 дүгээр зүйлийн 29.4-т "Татварын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагын дарга шаардлагатай тохиолдолд тайлан хүлээн авах хугацааг 7 хоног хүртэлх хугацаагаар сунгаж болох бөгөөд энэ тухайгаа олон нийтэд урьдчилан мэдэгдэнэ." гэж заасан. Тус заалтын хүрээнд тайлангийн хугацаа сунгасан шийдвэрүүдийг авч үзэхэд, 2020-2022 оны хооронд татварын тайлан ирүүлэх хуулийн хугацааг сунгаагүй, харин 2022-2024 онуудын хагас жилийн тайлан хүлээн авах хугацааг Үндэсний их баяр наадамтай давхцсаны улмаас 7 хүртэлх хоногоор сунгасан байна.

Татвар төлөгч ААН-үүдийн тайлангийн ирцийг сегментээр ангилж үзэхэд, 2020-2022 онуудад бичил сегментийн ААН-үүдийн тайлан тушаалт 66-69 хувьтай байсан бөгөөд 2023 оны жилийн эцсийн тайлан тушаах хугацааг Татварын ерөнхий хуульд заасны дагуу 7 хоногоор сунгахад тайлан ирүүлэлтийн нийт хувь өмнөх жилээс 4.6 хувиар өсөж 74.1 хувьтай болсон байна. Үүнийг сегментээр хувьчилбал, өмнөх оноос бичил сегмент 4.6 хувиар, дунд сегмент 2.1 хувиар, том сегмент 5.8 хувиар тус тус өссөн үзүүлэлттэй байна.

Татварын 2023 оны жилийн эцсийн тайланг сунгасантай холбоотой хугацаандаа тайлан ирүүлэлт бичил сегмент 5.8 хувь, дунд сегмент 4.6 хувь, жижиг сегмент 0.3 хувь, том сегмент 8.4 хувиар тус тус нэмэгдсэн үзүүлэлттэй байна.

Зөрчлийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.19.2.3-т заасан "татварын тайланг хуулиар тогтоосон хугацаанд татварын албанд тушаах" үүргээ биелүүлээгүй зөрчилд оногдуулсан шийтгэлийн судалгааг (2022-2024 он) авч үзэхэд:

Хүснэгт 7. Шийтгэлийн хуудасны судалгаа

2022 он		2023 он		2024 он	
Тоо	Хувь	Тоо	Хувь	Тоо	Хувь
483	28.8	572	25.2	1337	41.4

2024 онд нийт 1337 шийтгэлийн хуудас бүртгэгдсэн нь өмнөх онтой харьцуулахад 765 буюу 133.7 хувиар, 2022 онтой харьцуулахад 854 буюу 176.8 хувиар тус тус өссөн үзүүлэлттэй байна.

“Татварын шинэчлэл - 2025” хэлэлцүүлэг, олон нийтийн санал асуулгын үр дүнгээс үзэхэд тайлангийн хугацааны зохицуулалтыг өөрчлөх, зөрчилд хүлээлгэх торгуулийн хэмжээг бууруулах саналыг ирүүлсэн.

Дээрхээс дүгнэвэл, тус хуулийн 26 дугаар зүйлийн 26.1, 26.2 дахь хэсэгт заасан татварын тайлан гаргах хугацаатай холбоотой зохицуулалтыг практикт бүрэн хэрэгждэггүй, татварын тайланг хугацаандаа тайлагнаагүй тохиолдолд зөрчилд тооцож, шийтгэл оногдуулдаг зэргээс үүдэн олон нийт тус зохицуулалтад заасан хугацааг өөрчлөх саналыг нэлээдгүй гаргасан байна.

Шалгуур үзүүлэлтийн томъёолол 5. ААНОАТТХ-ийн 29 дүгээр зүйлийн 29.1 дэх хэсэгт заасан татварын хялбаршуулсан горимтой холбоотой зохицуулалт практикт хэрхэн хэрэгжиж байна вэ? Тус зохицуулалтыг хэрэгжүүлэхэд хүндрэл, бэрхшээл тулгарч байгаа эсэх.

Үнэлгээ: ААНОАТТХ-ийн 29 дүгээр зүйлийн 29.1-д “Өмнөх татварын жилийн тайлангаар баталгаажсан борлуулалтын нийт орлогын хэмжээ 50.0 сая төгрөгөөс бага бол тухайн албан татвар төлөгч тухайн татварын жилийн 3 дугаар улиралд багтаан хүсэлт гаргасныг харьяалах татварын алба бүртгэж авсан тохиолдолд дараагийн татварын жилээс эхлэн тухайн албан татвар төлөгчийн үйл ажиллагааны орлогын нийт дүнгээр албан татвар ногдуулах орлогыг тодорхойлж болно.” гэж заасан.

2019 оны шинэчлэн найруулсан ААНОАТТХ-ийн үзэл баримтлалд "одоо байгаа татварын ачааллыг бууруулах замаар татварын суурийг өргөжүүлэх зарчмыг баримтална. Мөн 2006 оны ААНОАТТХ-аар бүх аж ахуйн нэгж нэгэн ижил тайлангийн маягтаар, ижил хугацаанд тайлагнаж, төлдөг тул жижиг, дунд хэмжээний аж ахуйн нэгжүүдийн татвар төлөх, тайлагнахтай холбогдсон зардлууд хүндрэл учруулдаг. Жижиг, дунд аж ахуйн нэгжийн үйл ажиллагааг дэмжих, тэдний татвар төлөхтэй холбоотой зардлыг бууруулах, тайлагналын ажиллагааг хялбарчлах зорилгоор хялбаршуулсан татварын тайлагнал, төлөлтийн заалтуудыг хуулийн төсөлд тусгалаа. Үүний дагуу 50 сая төгрөг хүртэлх борлуулалтын орлоготой аж ахуйн нэгж өөрөө хүсвэл нийт орлогын дүнгээр 1 хувьтай тэнцэх татварыг төлж, жилд 1 удаа тайлагнана. Хуулийн төсөл батлагдсанаар Монгол Улсын бизнесийн орчин, бизнес эрхлэгчдийн татвар төлөхтэй холбоотой гарах зардал буурч, татварын тэгш шударга байдал дээшлэн, татварын бааз суурь өргөжих болно. Нөгөөтэйгүүр, татвараас зайлсхийх, зугтаах явдал багасаж, хуулийн дагуу шударгаар татвараа тайлагнах, төлөх явдал нэмэгдэх тул дунд хугацаанд төсвийн орлогыг нэмэгдүүлэх эерэг нөлөөтэй байх болно." гэжээ.

Тус хууль хэрэгжиж эхэлснээс хойш ААНОАТТХ-ийн 29 дүгээр зүйлийн 29.1 дэх хэсэгт заасан зохицуулалтын 2020-2023 онд давхардсан тоогоор нийт 18,110 татвар төлөгчийн албан татварыг 1 хувиар тооцон 1,336.5 сая төгрөгийг ногдуулж төсөвт төлсөн байна. Татварын жилд албан татварыг 1 хувиар төлж, тайлагнасан татвар төлөгчийн тоо, ногдлын дүнг харуулбал:

- 2021 онд 3,781 татвар төлөгч 328.7 сая төгрөгийг
- 2022 онд 7,085 татвар төлөгч 470.9 сая төгрөгийг
- 2023 онд 7,244 татвар төлөгч 536.9 сая төгрөгийг ногдуулж, тайлагнасан.

Дээрхээс дүгнэвэл, 2022 онд татвар төлөгчийн тоо өмнөх оноос 87.3 хувиар, ногдол 43.3 хувиар, 2023 онд өмнөх оноос татвар төлөгчийн тоо 2.2 хувиар, ногдол 14.0 хувиар тус тус өссөн үзүүлэлттэй байна.

“Татварын шинэчлэл - 2025” хэлэлцүүлэг, олон нийтийн санал асуулгын үр дүнгээс үзэхэд татварын хялбаршуулсан горимд хамрагдах нийт борлуулалтын орлогын хэмжээг нэмэгдүүлэх, хялбаршуулсан горимоор тайлан өгөх хүсэлтийг тайлант хугацааны эцэст татвар төлөгч өөрөө сонголт хийснээр тайлагнадаг илүү бодитой хялбаршуулсан нөхцөлийг бүрдүүлэх шаардлагатай гэсэн санал гарсан.

Дээрхээс дүгнэвэл, ААНОАТХ-ийн 29 дүгээр зүйлийн 29.1 дэх хэсэгт заасан хялбаршуулсан горимын зохицуулалт нь практикт тодорхой хэмжээнд хэрэгжиж татварын ачааллыг бууруулж байгаа бөгөөд олон нийтээс тус зохицуулалттай холбоотойгоор босгын хэмжээг нэмэгдүүлэх санал ирүүлсэн байна.

Шалгуур үзүүлэлтийн томъёолол 6. Хуулийн 30 дугаар зүйлийн 30.2, 30.8 дахь хэсэгт заасан эцсийн эзэмшигчийн хувьцаа, хувь оролцоог өөрчлөх замаар эрх борлуулсан, шилжүүлсний орлогод эрх борлуулсны орлогын албан татвар ногдуулах заалт практикт хэрхэн хэрэгжиж байна вэ?

Үнэлгээ:

- ААНОАТХ-ийн 30 дугаар зүйл

ААНОАТХ-ийн шинэчилсэн найруулгын төслийн үзэл баримтлалд "12.Эцсийн эзэмшигчийн хувьцаа, хувь оролцоог өөрчлөх замаар эрх борлуулсан, шилжүүлсний татварын харилцаа, ашигт малтмал, цацраг идэвхт ашигт малтмал, газрын тосны хайгуул, ашиглалтын тусгай зөвшөөрөл, газар ашиглах, эзэмших эрхийн эцсийн эзэмшигчийн хувьцаа, хувь оролцоог шууд бусаар шилжүүлэх, борлуулах замаар олсон эрх борлуулсны орлогод татвар ногдуулах одоогийн харилцааг хэрэгжүүлэх явцад зарим хүндрэлтэй асуудлууд үүсэж байна. Иймд, олон улсын туршлагад үндэслэн энэ харилцааг шинэчлэн боловсруулж, цогц байдлаар тусгайлсан зүйлээр зохицуулахаар тусгалаа. Ингэснээр хуулийн хэрэгжилт энгийн ойлгомжтой, нэг мөр болох ач холбогдолтой юм." гэсэн боловч өнөөгийн хуулийн зохицуулалт практик хэрэгжихэд татвар төлөгчдөд тодорхой асуудлууд үүсээд байна.

Энэ зохицуулалт нь хууль хэрэглээний зөрүүтэй асуудал үүсгэж практикт бодитой хэрэгжихгүй байна. Иймд, хуулийн 30 дугаар зүйлд нэмэлт, өөрчлөлт оруулж, хуулийн хэрэгжилтийг тодорхой, ойлгомжтой болгох шаардлагатай.

ДӨРӨВ. ДҮГНЭЛТ, САНАЛ

Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуулийн зарим зохицуулалтад Монгол Улсын Засгийн газрын 2016 оны 59 дүгээр хавсралтын 6 дугаар хавсралтаар баталсан “Хууль тогтоомжийн хэрэгжилтийн үр дагаварт үнэлгээ хийх аргачлал”-ыг үнэлгээ хийв.

Ийнхүү үнэлэхдээ тус хуулийн хэрэгжилтийг үнэлэхэд оновчтой, бодитой, хэмжиж болохуйц байдлыг баримталж, мөн үнэлгээний хүрээ, онцлогтой уялдуулан аргачлалд заасны дагуу “Зорилгод хүрсэн түвшин”, “Практикт нийцэж байгаа байдал” гэсэн 2 шалгуур үзүүлэлтийг сонгон үнэллээ.

“Зорилгод хүрсэн түвшин шалгуур” үзүүлэлтийн хүрээнд ААНОАТХ-ийн 15 дугаар зүйлийн 15.7-15.8 дахь хэсэг, 20 дугаар зүйлийн 20.1 дэх хэсэг, 20 дугаар зүйлийн 20.2.7 дахь заалт заалтуудыг сонгон судалсан болно.

Харин “Практикт нийцэж байгаа байдал” шалгуур үзүүлэлтийн хүрээнд ААНОАТХ-ийн 17 дугаар зүйлийн 17.11 дэх хэсэг, 22 дугаар зүйлийн 22.1 дэх хэсэг, 22 дугаар зүйлийн 22.5.3,

22.5.7-22.5.9 дэх заалт, 26 дугаар зүйлийн 26.1-26.2 дахь хэсэг, 29 дүгээр зүйлийн 29.1 дэх хэсэг, 30 дугаар зүйлийн зохицуулалтыг сонгон авч тус хуулийн хэрэгжилтийн үр дагаврыг үнэллээ. Тус судалгааны ажлыг гүйцэтгэж, дараах дүгнэлтэд хүрлээ.

ААНОАТХ-ийн 15 дугаар зүйлийн 15.7, 15.8 дахь хэсэгт ариун цэврийн байгууламж болон ойр орчмын гудамж талбайд эрх бүхий байгууллагаас тогтоосон стандартад нийцсэн хяналтын камер худалдан авч суурилуулахтай шууд холбогдон гарсан зардлыг 100 хувиар нэмэгдүүлэн албан татвар ногдох орлогоос хасах зохицуулалт нь 2025 оны 06 дугаар сарын 01-ний өдрөөс хэрэгжиж эхлэх тул хэрэгжилтийг үнэлэх боломжгүй байна.

Тус зохицуулалтууд нь ААНОАТХ-ийн 22.9 дэх хэсгийн 22.9.1-д заасан нийгмийн хариуцлагын хүрээнд хэрэгжүүлэх төсөл үйл ажиллагаа, санхүүгийн дэмжлэг, хандивын зардлын хөнгөлөлттэй давхардсан агуулгатай байгаа тул хуулийн давхардлыг арилгах нь зүйтэй байна.

- ААНОАТХ-ийн 17 дугаар зүйлийн 17.11-д "Албан татвар төлөгчийн тухайн улиралд шинээр эзэмшсэн хөрөнгийн элэгдэл, хорогдлын шимтгэлийг дараагийн сарын эхний өдрөөс эхлэн тооцно." гэж заасан. Шинэ хөрөнгийн элэгдэл, хорогдлыг тооцох хугацаа нь тухайн хөрөнгийн ашиглалтын эхнээс хуримтлагдах шимтгэлийг тооцоолох боломжийг олгодог бөгөөд энэ нь бизнесийн үйл ажиллагаанд чухал үүрэгтэй байна. Практикт тус зохицуулалтын элэгдэл байгуулж эхлэх хугацааг улирлын дараа сарын эхний өдрөөс эхлэх, эсхүл хөрөнгө эзэмшсэн сарын дараагийн сарийн эхний өдрөөс эхлэх эсэх нь тодорхойгүй байдлыг үүсгэж, олон нийт зөрүүтэй ойлгож хэрэгжүүлж болзошгүй байна.

Иймд, тус заалтын "тухайн улиралд" гэснийг хасаж хугацааны зохицуулалтыг илүү тодорхой болгон хууль даган мөрдөлтийг сайжруулах нь зүйтэй. Энэ нь тодорхой хугацаанд татвар төлөгчийн татварын ачаалал буурах боломжийг бий болгох бөгөөд зарим бизнесийн хувьд санхүүгийн нөхцөл байдлыг сайжруулж, хөрөнгө оруулалт хийх боломжийг олгох эерэг нөлөөлөл үзүүлнэ.

- ААНОАТХ-ийн 20 дугаар зүйлийн 20.1 дэх хэсгийн зохицуулалтаар албан татварын хувь хэмжээ нь 0-6 тэрбум төгрөгийн орлоготой аж ахуйн нэгжүүдэд 10 хувь, 6 тэрбум төгрөгөөс дээш орлоготой компаниудад нэмэгдүүлсэн 25 хувиар татвар ногдуулахаар тогтоосон.

Шаталсан татварын ачааллыг 2023 оны ААНОАТ-ын төлөвлөгөөний биелэлтээр үнэлэхэд, нийт ногдлын 70.4 хувь нь хугацаандаа төсөвт төлөгдсөн бөгөөд үлдэх 29.6 хувь нь хуулийн хугацаанд төлөөгүй байна. "Татварын хуулийн шинэчлэл-2025" хэлэлцүүлэг, санал асуулгын үр дүнгээс харахад, тус хуулийн 20.1-д заасан татварын хувь хэмжээг бууруулах эсвэл шаталсан хувийг бууруулах, мөн 6 тэрбум төгрөгийн албан татвар ногдуулах орлогын суурийг нэмэгдүүлэхтэй холбоотой саналууд дийлэнх хувиар гарсан байна.

Энэ нь практикт тус зохицуулалтыг хүлээн зөвшөөрөхгүй байгааг илтгэж байна. Түүнчлэн, татвар төлөгчид шаталсан хувиар албан татварыг төлөхөөс зайлсхийх зорилгоор үйл ажиллагааны чиглэлийг тусгаарлах, хуваах замаар компаниа жижиглэх хэлбэрт шилжиж, татварын ачааллаа бууруулах арга замыг эрэлхийлж болзошгүй гэдгийг харгалзан үзэж холбогдох нэмэлт, өөрчлөлтийг оруулах нь зүйтэй.

- ААНОАТХ-ийн 20 дугаар зүйлийн 20.2.7 дахь зохицуулалт нь ААН-ийн татвар төлөхтэй холбоотой зардлыг бууруулах, тайлагналыг илүү хялбарчлах зорилготой жижиг, дунд аж ахуйн нэгжүүдийн татвар төлөх зардлыг бууруулах ач холбогдолтой боловч хуулийн зорилгодоо хүрч хэрэгждэггүй, практикт тэдэнд бодитой дэмжлэг үзүүлэхгүй байгаа нь үнэлгээгээр тодорхойлогдож байна.

2023 онд нийт 39,738 ААН орлогын албан татварын тайлагнал ирүүлсэн бөгөөд ногдлын дүн 17.9 тэрбум төгрөг байна. Энэ нь өмнөх онтой харьцуулахад аж ахуйн нэгж 3,719 буюу 10.3 хувиар, ногдлын дүн 3.2 тэрбум төгрөг буюу 21.8 хувиар тус тус өссөн үзүүлэлттэй

байна. ААНОАТ-ын 2023 оны тайланг 154,782 татвар төлөгч тушааж, тайлангийн ирц 83.8 хувь байх бөгөөд 83.8 хувь нь ААНОАТХ-ийн 20.2.7 дахь заалтад хамаарч тайлагнасан байна.

“Татварын хуулийн шинэчлэл-2025” хэлэлцүүлэг, санал асуулгаар жижиг, дунд бизнес эрхлэгч ААН-үүдийн эдийн засагт эзлэх хувь оролцоог дээшлүүлэх, татварын бодлогоор дэмжиж татвар ногдох орлогын босгыг нэмэгдүүлэх замаар 1 хувиар албан татвар төлөгчдийн хамрагдалтыг нэмэгдүүлэх саналууд гарсан.

Хэрэв ААНОАТХ-ийн 22 дугаар зүйлийн 22.1 дэх хэсэгт заасан албан татвар ногдох орлогын 1.5 тэрбум төгрөгийн босгыг ЖДҮҮДТХ-ийн 4.1.1-д заасан жилийн 2.5 тэрбум төгрөг хүртэл борлуулалтын орлоготой уялдуулсан тохиолдолд энэхүү 20.2.7 дахь заалт цаашид байх эсэхийг тодорхойлох шаардлагатай.

- ААНОАТХ-ийн 22 дугаар зүйлийн 22.1-д заасан албан татварын хөнгөлөлт нь татвар төлөгчийн татварын дарамтыг бууруулж, жижиг, дунд бизнесүүдэд санхүүгийн ачааллаа багасгах боломжийг олгох зорилготой бөгөөд энэ нь хуулийн хэрэгжилтэд эерэг нөлөө үзүүлжээ. 2023 онд албан татварын хөнгөлөлтөд хамрагдсан ААН-үүдийн тоо болон хөнгөлөлтийн дүн өссөн нь энэхүү зохицуулалтын үр дүнг харуулж байна. Гэвч, хөнгөлөлтөд хамрагдах нөхцөлтэй холбоотойгоор компанийн үйл ажиллагааг тусгаарлах, жижиглэн олон компани байгуулах, орлогыг нуух зэрэг эрсдэлүүд үүсэх боломжтой байна.

Үүнтэй холбогдуулан, олон нийтийн хэлэлцүүлэгт оролцсон хүмүүс албан татвар ногдох орлогын босгыг нэмэгдүүлэх, хамрагдалтын түвшинг сайжруулах шаардлагыг тавьжээ. Мөн ААНОАТХ-ийн 22 дугаар зүйлийн 22.1-д заасан зохицуулалтыг Жижиг, дунд үйлдвэрлэл, үйлчилгээг дэмжих тухай хуулийн 4.1.1-д заасан "жижиг, дунд үйлдвэр, үйлчилгээ эрхлэгч" гэх тодорхойлолттой уялдуулан, хууль хоорондын харилцан уялдааг хангах нь зүйтэй гэж үзэж байна. Энэ нь хуулийн үйлчлэлийг илүү оновчтой, үр дүнтэй болгох, жижиг, дунд бизнес эрхлэгчдийг дэмжих зорилгод нийцэх боломжийг бий болгох эерэг нөлөөлөл үзүүлнэ.

- ААНОАТХ-ийн 22 дугаар зүйлийн 22.5.3 дахь заалт нь байгаль орчинд ээлтэй техник, тоног төхөөрөмжийг борлуулсны орлогод албан татварын хөнгөлөлт үзүүлэх зорилготой бөгөөд ногоон эдийн засгийг дэмжих, байгаль орчны бохирдлыг бууруулах, цэвэр технологи, инновацийг нэвтрүүлэх зорилго агуулж байна. Тус зохицуулалт нь экологид ээлтэй үйл ажиллагаа явуулах бизнесүүдийг урамшуулж, уур амьсгалын өөрчлөлттэй тэмцэхэд туслах зорилготой боловч практикт хөнгөлөлт эдэлсэн ААН-ийн тоо бага, хөнгөлөлтийн хэмжээ нь төдийлөн өндөр биш байна. 2023 онд нийт хөнгөлөлт эдэлсэн татвар төлөгчийн 0.06 хувийг эзэлж, үүний үр дүнд зохицуулалтын практик хэрэгжилт хангалтгүй байх тул хөнгөлөлтийн үр ашгийг нэмэгдүүлэхээр хууль эрх зүйн зохицуулалтыг сайжруулах шаардлагатай байна.

- ААНОАТХ-ийн 22 дугаар зүйлийн 22.5.7, 22.5.8 дахь заалтууд нь чөлөөт бүсүүдэд хөрөнгө оруулалт хийсэн аж ахуйн нэгжүүдэд татварын хөнгөлөлт үзүүлэх зорилготой бөгөөд эдгээр зохицуулалтуудын агуулга нь чөлөөт бүсийн хөгжлийг дэмжих, экспортын үйлдвэрлэлийг өсгөх, худалдаа, аялал жуулчлал болон хөрөнгө оруулалтыг татах, бүс нутгийн хөгжлийг хурдасгах зэрэг эдийн засгийн өсөлтийг нэмэгдүүлэхэд чиглэсэн юм.

Гэвч, 2020-2023 оны хугацаанд эдгээр хөнгөлөлтөд хамрагдсан аж ахуйн нэгж байхгүй байна. Тус хөнгөлөлтийн заалтууд нь 2006 оны ААНОАТХ-д 2012 онд шинээр оруулсан зохицуулалт бөгөөд өмнөх хуулийн үйлчлэлийн хугацаанд хэрэгжилтэд амжилт олохгүй, практик дээр төдийлөн ашиглагдаагүй байна. Энэ нь хуулийн тодорхой зохицуулалт практикт хэрэгжихгүй байгааг илэрхийлж, хөнгөлөлтүүдийн үр ашиггүй байдал, хуулийн зорилгодоо хүрэхгүй байгааг харуулж байна. Иймд, цаашид хөнгөлөлтийн зохицуулалтыг шинэчлэх, хэрэгжилтийг сайжруулах арга хэмжээ авах шаардлагатай байна.

- ААНОАТХ-ийн 22 дугаар зүйлийн 22.5.9-д заасан "усны нөөцийг нэмэгдүүлэх, усны найдвартай хангамжийг бүрдүүлэх зорилгоор байгалийн усны чанарыг сайжруулах, гол, горхийг нөхөн сэргээх арга хэмжээг санхүүжүүлсэн иргэн, аж ахуйн нэгж, байгууллагын

орлогод ногдох албан татварыг хөнгөлөх" зохицуулалтыг 2020-2022 онд практикт хэрэгжүүлээгүй бөгөөд зөвхөн 2023 онд нэг аж ахуйн нэгж хөнгөлөлт эдэлсэн байна. Энэ нь хуулийн зохицуулалт практик дээр төдийлөн хэрэгжээгүй байгааг харуулж байна.

Мөн, ААНОАТтХ-д 2024 оны нэмэлт, өөрчлөлтөөр тус хуульд 22.9 дэх хэсэг шинээр нэмэгдсэн бөгөөд байгалийн баялаг хамгаалах, нөхөн сэргээх үйл ажиллагааг дэмжих зорилгоор олгосон санхүүгийн дэмжлэг, хандивын зардлыг ногдуулсан албан татвараас хасаж хөнгөлөхөөр заасантай хуулийн 22.5.9 дэх заалтын агуулга давхардсан байна. Иймд, хуулийн давхардсан агуулга бүхий зохицуулалтыг нэг болгох шаардлагатай байна.

- ААНОАТтХ-ийн 26 дугаар зүйлд албан татварын тайлангийн хугацааг зохицуулсан бөгөөд 2020-2023 онд нийт 215,388 ААН-ийн тайлангийн ирцийг судалж үзэхэд, нийтдээ 74.1% нь хугацаандаа тайлангаа ирүүлсэн байна. Тайлан хоцрох явдал харьцангуй буурч, 2020 онд 67.5%, 2023 онд 4.7% болж буурсан ч зөрчил гарсан тохиолдлуудын тоо нэмэгдэж, шийтгэлийн хуудасны тоо 2024 онд 1,337-д хүрсэн нь өмнөх жилүүдээс ихээр өссөн үзүүлэлттэй байна.

Татварын ерөнхий хуульд заасан "тайлан хүлээн авах хугацааг сунгах" боломжийг 2022-2024 онд ашигласан боловч, энэхүү зохицуулалт нь төдийлөн хангалттай үр дүнд хүрэхгүй байсныг харуулж байна. Олон нийтээс, тайлан гаргах хугацааг өөрчлөх болон зөрчилд оногдуулсан торгуулийн хэмжээг бууруулах санал гаргасан нь тухайн зохицуулалт дахь хүндрэлийг илэрхийлж байна.

Тус хуулийн 26 дугаар зүйлд заасан зохицуулалт нь татварын тайлангийн хугацаанд гүйцэтгэлийг сайжруулах, нягтлан бодох бүртгэлийн хариуцлагыг нэмэгдүүлэх зорилготой ч, практик дээр хэрэгжилт хангалтгүй, тайлангийн хугацааг сунгах шаардлага байгааг харуулж байх тул хуулийн 26.1, 26.2 дахь хэсгийн татварын тайлан тушаах хугацааг өөрчлөх, мөн тайлангийн хугацааны өөрчлөлттэй холбогдуулан албан татвар төсөвт төлөх хуулийн хугацааг адилтган өөрчлөх нь зүйтэй байна.

- ААНОАТтХ-ийн 29 дүгээр зүйлийн 29.1-д заасан хялбаршуулсан татварын зохицуулалт нь жижиг, дунд аж ахуйн нэгжүүдийн татварын ачааллыг бууруулах, тайлагнах ажиллагааг хялбарчлах зорилготой бөгөөд 2020-2023 онд 18,110 татвар төлөгч хөнгөлөлт эдэлж, 1,336.5 сая төгрөгийг төсөвт төлсөн байна. Энэ нь татвар төлөгчийн тоо болон ногдол дүнгийн өсөлтөөс харагдаж байгаа ч, 2022-2023 онуудад өсөлт харьцангуй бага буюу 2.2% ба 14.0%-ийн нэмэгдэлтэй байжээ.

Гэвч олон нийтийн санал асуулгаас харахад, хялбаршуулсан горимын зохицуулалт нь бодит амьдралд хэрэгжүүлэхэд хүндрэлтэй, мөн тус зохицуулалттай холбоотойгоор борлуулалтын орлогын босгын хэмжээг нэмэгдүүлэх хүсэлт ирсээр байна. Үүний зэрэгцээ, татвар төлөгчид тайлан өгөх хялбаршуулсан нөхцөлийг илүү тодорхой, уян хатан байдлаар хэрэгжүүлэх шаардлага байгааг харуулж байна. Энэ нь тус хуулийн практик хэрэгжилтэд олон нийтээс тавигдаж буй шаардлагыг илэрхийлж, хялбаршуулсан горимыг шинэчлэх, тохиромжтой босго тодорхойлох хэрэгтэйг харуулж байна.

- ААНОАТтХ-ийн 30 дугаар зүйлийн эцсийн эзэмшигчийн хувьцаа, хувь оролцоо, саналын эрхийг өөрчлөх замаар төрийн байгууллагаас олгосон эрхийг бүрэн буюу хэсэгчлэн борлуулах, шилжүүлэхтэй холбогдох зохицуулалтыг олон нийтийн санал асуулга, хэлэлцүүлгийн үр дүнгээс үзэхэд хөрөнгө оруулалтын хүсэл эрмэлзэл, татвар төлөгчдийн хөрөнгө оруулалтын шийдвэрт сөргөөр нөлөөлж, хуулийн зохицуулалт амьдралд хэрэгжихэд бэрхшээл үүсгэдгийг харуулж байна.

--oo00oo--

ТАВ. АШИГЛАСАН ЭХ СУРВАЛЖ

Хууль тогтоомж, эрх зүйн акт

- Монгол Улсын Үндсэн хууль, Төрийн мэдээлэл эмхэтгэл (1992), №1
- Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хууль, Төрийн мэдээлэл эмхэтгэл, (2006), №38
- Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хууль, Төрийн мэдээлэл эмхэтгэл (2019), №23;
- Зөрчлийн тухай хууль, Төрийн мэдээлэл эмхэтгэл (2017), №24
- Татварын ерөнхий хууль, Төрийн мэдээлэл эмхэтгэл (2019), №22
- Төсвийн тухай хууль, Төрийн мэдээлэл эмхэтгэл (2012), №03
- Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тухай хууль, Төрийн мэдээлэл эмхэтгэл (2018), №30
- Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого “Алсын хараа 2050”
- Монгол Улсын Их Хурлын 2024 оны 21 дүгээр тогтоолоор батлагдсан “Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөр”
- Монгол Улсын Засгийн газрын 2024 оны 11 дүгээр сарын 20-ний өдрийн дугаар 181 тогтоолын хавсралтаар баталсан “Монгол Улсын хууль тогтоомжийг 2028 он хүртэл боловсронгуй болгох үндсэн чиглэл”

Бусад эх сурвалж

- “Татварын шинэчлэл-2025” олон нийтийн санал, асуулга, хэлэлцүүлгийн нэгтгэл мэдээ
- Аж ахуйн нэгжийн албан татвар ногдох орлогоос хасагдсан зардлын мэдээ (2020-2023 он)
- Аж ахуйн нэгжийн орлогын албан татвар төлөгчийн бүртгэлийн мэдээ (2020-2024 он)
- Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тайлангийн ирцийн мэдээ (2020-2023 он)
- Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуулийн үзэл баримтлал, танилцуулга, 2019 он;
- Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын хөнгөлөлт, чөлөөлөлтийн мэдээ (2020-2023 он)
- Аж ахуйн нэгжийн орлогын гүйцэтгэлийн мэдээ (2020-2024 он)
- Захиргааны хэргийн шүүхээр шийдвэрлэгдсэн хэрэг маргааны судалгаа (2020-2024 он)
- Зөрчлийн тухай хуулийн дагуу шийтгэл оногдуулсан зөрчлийн судалгаа (2020-2024 он)
- Татварын албаны дэргэдэх Татварын маргаан таслах зөвлөлөөр шийдвэрлэсэн гомдлын судалгаа (2020-2024 он)
- Татварын бүртгэл, мэдээллийн нэгдсэн сангийн мэдээлэл (2020-2024 он)
- Төрийн байгууллагаас олгосон тусгай зөвшөөрлийг борлуулсан, шилжүүлсний орлогод төлсөн татварын мэдээ (2020-2023 он)
- Татварын хяналт шалгалтын мэдээ (2020-2024 он)

**“АЖ АХУЙН НЭГЖИЙН ОРЛОГЫН АЛБАН ТАТВАРЫН ТУХАЙ
ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ” ХУУЛИЙН
ТӨСӨЛД ХИЙСЭН ҮР НӨЛӨӨ ҮНЭЛГЭЭНИЙ ТАЙЛАН**

**АЖ АХУЙН НЭГЖИЙН ОРЛОГЫН АЛБАН ТАТВАРЫН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ,
ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ ХУУЛИЙН ТӨСӨЛД ХИЙСЭН ҮР НӨЛӨӨ
ҮНЭЛГЭЭНИЙ ТАЙЛАН**

НЭГ. ЕРӨНХИЙ ЗҮЙЛ

Энэхүү үнэлгээг Сангийн яамнаас боловсруулсан Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн зүйл, хэсэг, заалтад Хууль тогтоомжийн тухай хуулийн¹ 17 дугаар зүйлд заасны дагуу дүн шинжилгээ хийх, үр нөлөөг тооцож, давхардал, хийдэл, зөрчлийг илрүүлэн, хуулийн зүйл, заалтыг ойлгомжтой, хэрэгжих боломжтой байдлаар боловсруулахад зөвлөмж өгөхөд оршино.

Үнэлгээ хийхээр сонгож авсан хуулийн төсөл нь хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл хэлбэрээр боловсруулагдсан байна.

Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн /цаашид “хуулийн төсөл” гэх/ үр нөлөөг үнэлэх ажиллагааг Засгийн газрын 2016 оны 59 дүгээр тогтоолын 3 дугаар хавсралтаар батлагдсан “Хуулийн төслийн үр нөлөө тооцох аргачлал”²-д /цаашид “Аргачлал” гэх/ заасны дагуу дараах үе шатаар хийлээ. Үүнд:

1. Шалгуур үзүүлэлтийг сонгох;
2. Хуулийн төслөөс үр нөлөө тооцох хэсгээ тогтоох;
3. Урьдчилан сонгосон шалгуур үзүүлэлтэд тохирох шалгах хэрэгслийн дагуу үр нөлөөг тооцох;
4. Үр дүнг үнэлэх, зөвлөмж өгөх.

**ХОЁР. ХУУЛИЙН ТӨСЛИЙН ҮР НӨЛӨӨГ ҮНЭЛЭХ ШАЛГУУР
ҮЗҮҮЛЭЛТИЙГ СОНГОСОН БАЙДАЛ, ҮНДЭСЛЭЛ**

Тус үнэлгээний ажлыг хийж гүйцэтгэхдээ хуулийн төслийн зорилго, хамрах хүрээ, зохицуулах асуудалтай уялдуулан Аргачлалын 2.9-д заасныг үндэслэн 6 шалгуур үзүүлэлтээс дараах 3 шалгуур үзүүлэлтийг сонголоо. Үүнд:

1. Зорилгод хүрэх байдал
2. Практикт хэрэгжих боломж
3. Ойлгомжтой байдал зэрэг болно.

¹<https://legalinfo.mn/mn/detail?lawId=11119>

² Засгийн газрын 2016 оны 59 дүгээр тогтоолоор батлагдсан.

Хуулийн төслийн үр нөлөөг үнэлэх шалгуур үзүүлэлтийг сонгосон үндэслэл:

1.Зорилгод хүрэх байдал:

Энэхүү үнэлгээний үндсэн зорилго нь тухайн хуулийн төслийн зохицуулалт анх дэвшүүлсэн зорилго буюу тулгамдсан бэрхшээлийг шийдвэрлэж чадах эсэхийг тогтоох билээ. Иймд хуулийн төслийн зохицуулалт нь хуулийн төслийн үзэл баримтлал буюу хуулийн төслийг боловсруулах болсон үндэслэл, шаардлагад нийцсэн эсэх, мөн түүнийг тодорхой илэрхийлж чадахуйц зохицуулалтын хувилбарыг агуулсан эсэхийг тогтоох зорилгоор тус шалгуур үзүүлэлтийг сонгосон болно.

2.Практикт хэрэгжих боломж:

Энэхүү хуулийн төсөл нь одоогийн хүчин төгөлдөр мөрдөгдөж буй Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуулийн тодорхой хэрэгцээ, шаардлагын үндсэн дээр нэмэлт, өөрчлөлт оруулах хуулийн төслийн зүйл, заалтууд нь дагаж мөрдөх болон хэрэгжүүлэхэд боломжтойгоор боловсруулагдаж чадсан эсэх, дагаж мөрдөх боломжтой эсэх, тухайн зохицуулалтыг хэрэгжүүлэх субъект, байгууллага нь хэн байх, тэдгээр байгууллагад тухайн зохицуулалтыг хэрэгжүүлэх боломж, бололцоо байгаа эсэхийг үнэлнэ.

3.Ойлгомжтой байдал:

Хуулийг хэрэглэх, хэрэгжүүлэх субъектийн хувьд ойлгомжтой байх нь хэрэгжилтийн үр дүнд шууд нөлөөлдөг. Хууль тогтоомжийн тухай хуульд зааснаар хуулийн төсөл нь бүтэц, хэлбэрийн хувьд логик дараалалтай, хэл зүй, найруулгын хувьд тодорхой, ойлгоход хялбараар томъёологдсон байх шаардлага тавигддаг.

Энэхүү хуулийн төсөл нь Хууль тогтоомжийн тухай хууль, Хууль тогтоомжийн төсөл боловсруулах аргачлалд заасан шаардлагыг хангасан эсэхийг хянах тогтоох зорилгоор энэхүү шалгуур үзүүлэлтийг сонгосон болно.

ГУРАВ. ХУУЛИЙН ТӨСЛӨӨС ҮР НӨЛӨӨГ ҮНЭЛЭХ ХЭСГИЙГ ТОГТООСОН БАЙДАЛ

Сонгосон шалгуур үзүүлэлтийн дагуу үр нөлөөг үнэлэхэд хамруулах хэсэг, түүнийг шалгах хэрэгслийг дараах байдлаар тогтоолоо.

д/д	Шалгуур үзүүлэлт	Үр нөлөөг үнэлэх хэсэг	Шалгах хэрэгсэл
1	Зорилгод хүрэх байдал	Хуулийн төслийн холбогдох зохицуулалт	Хуулийн төслийн үзэл баримтлалд дэвшүүлсэн зорилтыг хангах эсэхэд дүн шинжилгээ хийх.
2	Практикт хэрэгжих боломж	Төслийн 3 дугаар зүйлд заасан зохицуулалт	Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуулийг

		хэрэгжих боломжтой эсэхийг үнэлэх	хэрэглэх этгээдүүдтэй нээлттэй хэлэлцүүлэг зохион байгуулах, хуулийн төсөлд ирүүлсэн саналуудад дүн шинжилгээ хийх.
3	Ойлгомжтой байдал	Хуулийн төсөлд зохицуулалтыг бүхэлд нь хамруулах	Хууль тогтоомжийн тухай хуулийн 23, 28, 29, 30 дугаар зүйл, Хууль тогтоомжийн төсөл боловсруулах аргачлалд заасан шаардлагыг хангасан эсэхийг шалгах.

ДӨРӨВ.ХУУЛИЙН ТӨСЛИЙН ҮР НӨЛӨӨГ ТООЦСОН БАЙДАЛ

1.Зорилгод хүрэх байдлыг хангасан эсэх:

“Зорилгод хүрэх байдал” гэсэн шалгуур үзүүлэлтийн хүрээнд хуулийн төслийн үзэл баримтлалд тусгасан хуулийн төсөл боловсруулах болсон үндэслэл, хэрэгцээ шаардлагад хуулийн төслийн зорилго, зорилт, зохицуулалтууд нь нийцэж байгаа эсэхэд дүн шинжилгээ хийх үүднээс хуулийн төслийн үзэл баримтлалтай танилцаж, үзэл баримтлал болон хуулийн төслийн зорилго, түүнийг хангахад чиглэсэн зохицуулалтуудыг харьцуулах байдлаар дүн шинжилгээ хийнэ.

Хуулийн төслийн үзэл баримтлал, хуулийн төслийн бүтэц, зохицуулах харилцаа, хамрах хүрээ, агуулгад дүн шинжилгээ хийж үзвэл:

1. Жижиг, дунд аж ахуйн нэгжүүдийг дэмжиж, аж ахуйн нэгжүүдийн татварын ачааллыг бууруулах;
2. Бизнесүүд үйл ажиллагаагаа өргөжүүлэх, идэвхжүүлэх боломжийг дэмжих;
3. Аж ахуйн нэгжүүдэд тулгарч буй нийтлэг асуудлуудыг шийдвэрлэн, татварын орчныг энгийн болгох.

Дээр дурдсан зорилтуудыг хангах чиглэлээр тодорхой зохицуулалтыг хуулийн төсөлд тусгасан байдлыг шалгаж үзвэл:

Зорилт-1.Жижиг, дунд аж ахуйн нэгжүүдийг дэмжиж, аж ахуйн нэгжүүдийн татварын ачааллыг бууруулах:

Жижиг, дунд аж ахуйн нэгжүүдийн хувьд татварын ачааллыг бууруулах зорилгоор 1.5 тэрбум төгрөг хүртэлх борлуулалтын орлоготой аж ахуйн нэгжүүд 90 хувийн татварын хөнгөлөлт эдлэх зохицуулалтын босгыг 2.5 тэрбум төгрөг болгон нэмэгдүүлсэн. Ингэснээр татварын хөнгөлөлт эдлэх хүрээ өргөжиж, илүү олон аж ахуйн нэгж энэхүү дэмжлэгт хамрагдах боломжтой болно. Улмаар жижиг, дунд бизнес эрхлэгчдэд тулгарах санхүүгийн дарамт буурч, хөрөнгө оруулалтаа

нэмэгдүүлэх, технологийн шинэчлэл хийх, ажлын байр шинээр бий болгох зэрэг өсөлт, өргөжилтийн үйл ажиллагаагаа идэвхжүүлэх суурь нөхцөл бүрдэнэ.

Зорилт-2.Бизнесүүд үйл ажиллагаагаа өргөжүүлэх, идэвхжүүлэх боломжийг дэмжих:

Хуулийн төслөөр албан татвар ногдуулах орлогын босгыг нэмэгдүүлэн, 6-10 тэрбум хүртэлх ашигтай аж ахуйн нэгж 15 хувиар, 10 тэрбумаас дээш ашигтай аж ахуйн нэгж 25 хувиар татвар төлөх зохицуулалтыг тусгасан. Ингэснээр аж ахуйн нэгжүүдийн үйл ажиллагаагаа өргөжүүлэх, шинэ төсөл хэрэгжүүлэх боломжийг бодитойгоор дэмжиж, бизнесийн идэвхийг тасралтгүй хадгалах, илүү өргөн хүрээнд үйл ажиллагаа явуулах урамшуулал болж, эдийн засгийн тогтвортой өсөлтийг хангах чухал алхам болно. Тодруулбал, татварын хувь хэмжээний шатлалт зохицуулалт нь аж ахуйн нэгжүүдийн ашиг өсөхийн хэрээр татварын ачаалал бага багаар нэмэгдэх ба энэ нь бизнесүүдийг орлого, ашгаа нэмэгдүүлэхэд сөрөг дарамт үүсгэхгүйгээр, харин өсөлтийн хөшүүрэг болгох давуу талтай. Үүний үр дүнд, аж ахуйн нэгжүүд илүү их хөрөнгө оруулалт хийх, шинэлэг бүтээгдэхүүн, үйлчилгээ нэвтрүүлэх, зах зээлээ тэлэх, дотоодын болон гадаадын зах зээлд өрсөлдөх чадвараа нэмэгдүүлэх нөхцөл бүрдэх юм.

Зорилт-3.Аж ахуйн нэгжүүдэд тулгарч буй нийтлэг асуудлуудыг шийдвэрлэн, татварын орчныг энгийн, уян хатан болгох:

Аж ахуйн нэгжүүдэд тулгарч буй нийтлэг асуудлуудыг шийдвэрлэн, татварын орчныг энгийн болгох зорилгоор татварын хялбаршуулсан горимын босгыг 400 сая төгрөг болгож нэмэгдүүлнэ. Ингэснээр хөнгөн, шуурхай, ойлгомжтой татварын зохицуулалтад хамрагдах аж ахуйн нэгжийн хүрээ тэлж, бичил, жижиг бизнесүүдийн захиргаа, тайлагналын зардал буурах, албан татвар тогтмол төлөгч болох сонирхол нэмэгдэх, албан бус эдийн засгаас албан ёсны эдийн засаг руу шилжих үйл явцыг түргэтгэх эерэг нөлөө үзүүлнэ. Мөн татварын тайлан, бүртгэлийн ачаалал багассанаар бизнес эрхлэгчид үндсэн үйл ажиллагаандаа төвлөрөх, орлогоо тогтвортой өсгөх боломж нэмэгдэж, эдийн засгийн суурь өргөжин тэлэх нөхцөл бүрдэнэ.

2.Практикт хэрэгжих боломжтой эсэх:

Төслийн 3 дугаар зүйлд заасан зохицуулалтуудыг “Практикт хэрэгжих боломж” шалгуур үзүүлэлтээр шалган бодит байдалд хэрэгжих боломжтой эсэхийг тодруулахыг зорилоо.

Энэхүү шалгуур үзүүлэлтийн хүрээнд 2025 оны 01 дүгээр сарын 27-ны өдрөөс 02 дугаар сарын 12-ны өдрийг хүртэл Сангийн яам, татвар, гаалийн байгууллага, Монголын үндэсний худалдаа, аж үйлдвэрийн танхим болон Улсын Их Хурлын Тамгын газар хамтран улс орон даяар нийт 150 удаагийн уулзалт, хэлэлцүүлгийг зохион байгуулж, давхардсан тоогоор 13,000 гаруй татвар төлөгчийг хамруулан 176 мянга гаруй санал, хүсэлт хүлээн авсан. Эдгээр хэлэлцүүлгийн үр

дүнд татвар ногдуулах орлогын босго, шатлалыг нэмэх, бизнес эрхлэгчдэд тулгарч буй хүндрэл, асуудлыг шийдвэрлэх зохицуулалтуудыг тусгах зэрэг саналуудыг нэгтгэн судалж, хуулийн нэмэлт өөрчлөлийн төслийг эцэслэн боловсруулснаар практикт хэрэгжих боломжтой гэж үзэж байна.

3. Ойлгомжтой байдлыг хангасан эсэх:

Энэ шалгуур үзүүлэлтийн хүрээнд Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуулийн нэмэлт өөрчлөлтийн төслийг боловсруулахдаа Хууль тогтоомжийн тухай хуулийн 26, 28, 29, 30 дугаар зүйл, Хууль тогтоомжийн төсөл боловсруулах аргачлалд заасан шаардлагыг хангасан эсэхийг хянах байдлаар үнэлгээг гүйцэтгэлээ. Мөн хуулийн нэмэлт өөрчлөлтийн төсөлд холбогдох байгууллага, татвар төлөгчдөөс ирүүлсэн саналыг тусгасан эсэхийг нягтлан, дүн шинжилгээ хийсэн болно.

Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуулийн нэмэлт өөрчлөлтийн төслийг хэрэгжүүлэхэд ойлгомжтой байдлаар томъёологдсон эсэхийг шалгах үүднээс хуулийн нэмэлт өөрчлөлтийн төслийн үзэл баримтлалд Олон улсын валютын сан, Эдийн засгийн хамтын ажиллагаа, хөгжлийн байгууллага зэрэг олон улсын байгууллагаас ирүүлсэн зөвлөмжийг авсан.

Үзэл баримтлалд тусгасан үндсэн чиглэлийг баримталж, дараах холбогдох зохицуулалтуудыг хуулийн нэмэлт өөрчлөлтийн төсөлд тусгалаа. Үүнд:

1. Жижиг, дунд аж ахуйн нэгжүүдийн татварын ачааллыг бууруулж, татварын орчныг сайжруулна.

Дээр дурдсан асуудлуудыг тусгасан зохицуулалтыг хуулийн төслийн 3 дугаар зүйл, 4 дүгээр зүйл болон 5 дугаар зүйлд тус тус тусгалаа.

2. Бизнесүүд тогтвортой үйл ажиллагаа явуулах, хуримтлал үүсгэх, хүний нөөцийн хөгжилд дэмжлэг үзүүлэх, бизнесийн өргөжих боломжийг дэмжинэ.

Дээр дурдсан асуудлуудыг тусгасан зохицуулалтыг хуулийн төслийн 1 дүгээр зүйл, 2 дугаар зүйл, 3 дугаар зүйл, 4 дүгээр зүйл болон 5 дугаар зүйл, 6 дугаар зүйлд тус тус тусгалаа.

3. Хэлэлцүүлгийн явцад олон нийтээс ирүүлсэн саналуудыг судлан үзэж, зарим арга хэмжээнүүдийг хуулийн төсөлд нэмж тусгав.

Хууль тогтоомжийн тухай хуульд заасны дагуу татварын хууль тогтоомжийн төслийг үзэл баримтлал, дагалдах судалгааны хамт Сангийн яамны албан ёсны цахим хуудсанд 60 хоногийн хугацаанд байршуулж, олон нийтээс санал авсан. Эдгээр санал болон уулзалт, хэлэлцүүлгийн явцад татвар төлөгчдөөс ирүүлсэн саналыг нэгтгэн авч үзвэл Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай

хуультай холбоотой нийт 28,386 саналыг ирүүлсэн бөгөөд саналуудыг нэг тус бүрчлэн судлан үзсэн.

Хуулийн төсөл боловсруулах явцад татвар төлөгчдөөс хялбаршуулсан горимын зохицуулалтыг хэвээр үлдээж, тус горимд хамрагдах босго дүнг нэмэгдүүлэх саналыг ирүүлсэн. Эдгээр саналыг судлан үзэж, хуулийн төсөлд холбогдох зохицуулалтыг тусгасан.

Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуулийн нэмэлт өөрчлөлтийн төсөл нь Хууль тогтоомжийн тухай хуулийн 28 дугаар зүйлд заасан хуулийн бүтэц, хэлбэрт нийцсэн байна.

Хуулийн нэмэлт, өөрчлөлтийн төсөлд татвар төлөгчдийн саналд үндэслэн олон нийтээс санал авахаар байршуулсан хуулийн нэмэлт өөрчлөлтийн төсөлд тусгагдсан бүс, орон нутагт татварын ялгаатай бодлого хэрэгжүүлэх зохицуулалтыг хуулийн төслөөс хассан болно.

Хуулийн төсөл батлагдсанаар Монгол Улсын бизнесийн орчны олон улсын тавцанд өрсөлдөх чадвар сайжирч, бизнес эрхлэгчдийн татварын ачаалал буурна. Үүний үр дүнд эдийн засгийн өсөлтийг дэмжих, нийгмийн тогтвортой байдал бэхжүүлэх суурь нөхцөл бүрдэх чухал ач холбогдолтой юм.

Хууль тогтоомжийн тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1-д дурдагдсан нийтлэг шаардлагуудаас харилцан уялдаатай холбогдох 29.1.1, 29.1.5, 29.1.7-д заасан нийтлэг шаардлагууд болон Хууль тогтоомжийн төслийн үр нөлөөг үнэлэх аргачлалын 4.10-т заасан шалгах хэрэгслийн дагуу үнэллээ:

- Хууль тогтоомжийн тухай хуулийн 29 дүгээр зүйлд заасан шаардлагыг хангасан эсэх:

д/д	Шалгах асуулт	Шаардлагыг хангасан эсэх
1	29.1.1.Монгол Улсын Үндсэн хууль, Монгол Улсын олон улсын гэрээнд нийцсэн, бусад хууль, үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлалтай уялдсан байх:	Үндсэн хуульд заасан зарчмыг хангахад чиглэсэн бөгөөд ямар нэгэн байдлаар зөрчилдөөгүй байна.
2	29.1.5.зүйл, хэсэг, заалт нь хоорондоо зөрчилгүй байх.	Төслийн зүйл, хэсэг, заалт хоорондоо зөрчилдөөгүй байна.
3	29.1.7.бусад хуулийн заалтыг давхардуулан заахгүйгээр шаардлагатай бол түүнийг эш татах, энэ тохиолдолд эшлэлийг тодорхой хийж, хуулийн нэр болон хэвлэн нийтэлсэн албан ёсны эх сурвалжийг бүрэн гүйцэд заасан байх,	Энэхүү хуулийн төслийн зүйл, заалт бусад хуулиудтай давхардаагүй.
4	29.1.10.шаардлагатай тохиолдолд бусад хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах болон хүчингүй болсонд	Тус хуулийн төслийг дагаж одоогийн мөрдөгдөж буй

	тооцох тухай дагалдах хуулийн төслийг боловсруулсан байх.	Мэргэжлийн болон техникийн боловсрол, сургалтын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг боловсруулсан байна.
--	---	--

- Хууль тогтоомжийн төслийн үр нөлөөг үнэлэх аргачлалын 4.10-т заасан уялдаа холбоог шалгах хэрэгсэлд дурдагдсан шалгуурыг хангасан эсэх:

д/д	Асуулт	Хариулт	Дүн шинжилгээ
1	Хуулийн төслийн зохицуулалт тухайн хуулийн зорилттой нийцэж байгаа эсэх:	тийм	Хуулийн төслийн зохицуулалт нь үзэл баримтлалд тусгагдсан зорилтыг бүрэн хангаж байна.
2	Хуулийн төслийн “Хууль тогтоомж” гэсэн хэсэгт заасан хуулиудын нэр тухайн харилцаанд хамаарах хууль мөн эсэх.	тийм	Энэхүү шаардлагыг хангасан байна.
3	Хуулийн төсөлд тодорхойлсон нэр томьёо тухайн хуулийн төслийн болон бусад хуулийн нэр томьёотой нийцэж байгаа эсэх	Тийм	Зөрүүтэй нэр томьёо илрээгүй болно.
4	Хуулийн төслийн зүйл, заалт тухайн хуулийн төсөл болон бусад хуулийн заалттай нийцэж байгаа эсэх.	тийм	Зарчмын зөрүүтэй ямар нэгэн асуудал дүн шинжилгээний хүрээнд илрээгүй болно.
5	Хуулийн төслийн зүйл, заалт тухайн хуулийн төслийн болон бусад хуулийн заалттай давхардсан эсэх	үгүй	Хяналтаар ямар нэгэн зөрчилтэй зохицуулалт илрээгүй.
6	Хуулийн төслийг хэрэгжүүлэх этгээдийг тодорхой тусгасан эсэх	Тийм	Хуулийн төслийг хэрэгжүүлэгч субъектүүдийн эрх үүргийг ялган тодорхойлсон байна.
7	Хуулийн төсөлд шаардлагатай зохицуулалтыг орхигдуулсан эсэх	үгүй	Хуулийн төсөлд байх бүхий л зохицуулалтыг тусгасан гэж ойлгож байна.
8	Хуулийн төсөлд төрийн байгууллагын гүйцэтгэх чиг үүргийг давхардуулан тусгасан эсэх.	Үгүй	Хяналтаар ямар нэгэн зөрчилтэй зохицуулалт илрээгүй.
9	Төрийн байгууллагын чиг үүргийг төрийн бус байгууллага, мэргэжлийн холбоодоор гүйцэтгүүлэх боломжтой эсэх	Тийм	Төрийн байгууллагын зарим чиг үүргийг “мэргэжлийн холбоод, төрийн бус байгууллага”-аар гүйцэтгүүлэхээр зохицуулах боломжтой.

10	Татварын хуулиас бусад хуулийн төсөлд албан татвар, төлбөр, хураамж тогтоосон эсэх.	Үгүй	Тогтоогоогүй.
11	Тухайн хуулийн төсөлд тусгасан тусгай зөвшөөрөлтэй холбоотой зохицуулалтыг Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуульд тусгасан эсэх	Үгүй	Тусгаагүй.
12	Монгол Улсын Үндсэн хууль болон Монгол Улсын олон улсын гэрээнд заасан хүний эрхийг хязгаарласан зохицуулалт тусгасан эсэх,	Үгүй	Хяналтаар ямар нэгэн зөрчилтэй зохицуулалт илрээгүй.
13	Хуулийн төслийн зүйл, заалт жендерийн эрх тэгш байдлыг хангасан эсэх	-	Хуулийн төсөлд тусгайлан зохицуулалт тусгагдаагүй бөгөөд энэ асуудлыг Жендерийн эрх тэгш байдлыг хангах тухай хуулийн хүрээнд зохицуулах боломжтой.
14	Хуулийн төсөлд шударга бус өрсөлдөөнийг бий болгоход чиглэсэн заалт тусгагдсан эсэх		Хуулийн төсөлд тусгайлан зохицуулалт тусгагдаагүй бөгөөд энэ асуудлыг Өрсөлдөөний тухай хуулийн хүрээнд зохицуулах боломжтой.
15	Хуулийн төсөлд авлига, хүнд суртлыг бий болгоход чиглэсэн заалт тусгагдсан эсэх	үгүй	Хяналтаар энэ төрлийн зөрчил илрээгүй.
16	Хуулийн төсөлд тусгасан хориглосон хэм хэмжээг зөрчсөн этгээдэд хүлээлгэх хариуцлагын талаар тодорхой тусгасан эсэх		Тухайн хуулийг зөрчсөн этгээдэд хүлээлгэх хариуцлагыг Зөрчлийн тухай хуулиар зохицуулагдсан болно.

Энэхүү шалгуур үзүүлэлтийн дагуу дүн шинжилгээ хийж үзэхэд хуулийн төслийн зүйл заалт өөр хоорондоо болон Үндсэн хууль, бусад хүчин төгөлдөр үйлчилж байгаа хууль тогтоомжтой зөрчилдөөгүй, үүрэг хүлээсэн байгууллага, албан тушаалтнуудын чиг үүрэгт давхардал үүсгээгүй байна.

ТАВ. ҮР ДҮНГ ҮНЭЛЖ, ЗӨВЛӨМЖ ӨГСӨН БАЙДАЛ

Үнэлэлт, дүгнэлт

Хуулийн төслийн бүтэц зохицуулах харилцаа, хамрах хүрээ, агуулгыг дүн шинжилгээг Хууль тогтоомжийн тухай хуулийн 17 дугаар зүйлд заасны дагуу хийв. Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл нь бизнесийн таатай орчныг бүрдүүлэх, бизнесийн үйл

ажиллагаагаа өргөжүүлэх, идэвхжүүлэх үйл ажиллагааг дэмжих шаардлага тулгарч буйг харгалзан олон улсын тавцанд өрсөлдөх чадвар сайжрах, жижиг, дунд бизнес эрхлэгчдийн татварын ачааллыг бууруулах, эдийн засгийн өсөлтийг нэмэгдүүлэх чиглэлд тодорхой зохицуулалт тусган боловсруулжээ.

Зөвлөмж

Монгол Улсын хувьд жижиг, дунд аж ахуйн нэгжүүдийн төлбөрийн чадвар буурах, мөнгөн хөрөнгийн дутагдалд орж байгаа нь бизнесийн тогтвортой байдлаа хадгалах боломжийг хязгаарлах үндсэн шалтгаануудын нэг болж байна. Тодруулбал, Монгол Улсын хэмжээнд 2023 оны байдлаар нийт аж ахуйн нэгжүүдийн 57 орчим хувь нь мөнгөн хөрөнгийн дутагдалтай байгаа нь 2019 оныхтой харьцуулахад 27 хувиар өссөн үзүүлэлттэй байна. Мөн аж ахуйн нэгжүүдийн 34 хувь буюу 32 мянга гаруй компани тухайн онд алдагдалтай ажилласан байна. Иймд дээрх үүсээд буй нөхцөл, хүндрэлүүдийг шийдвэрлэх, бизнесийн орчны тогтвортой байдлыг хангахын тулд татварын бодлогын зохих арга хэмжээнүүдийг авч хэрэгжүүлэх шаардлага бий болж байна.

**АЖ АХУЙ НЭГЖИЙН ОРЛОГЫН АЛБАН
ТАТВАРЫН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ,
ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ ХУУЛИЙН
ТӨСЛИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХТЭЙ ХОЛБОГДОН
ГАРАХ ЗАРДЛЫН ТООЦОО**

Улаанбаатар хот
2025 он

АГУУЛГА

Нэг. Хуулийн этгээдийн зардлыг тооцох.....	Error! Bookmark not defined.
1.1. Хуулийн этгээдийн гүйцэтгэх үүргийг тогтоох.....	3
1.2. Зардлыг тооцох.....	3
1.3. Тоон үзүүлэлтийг тооцох.....	5
1.4. Нийт зардлын дүнг тооцох	5
1.5. Хялбарчлах боломж	6
1.6. Нэмэлт зардлыг тооцох.....	6
Хоёр. Иргэний зардлыг тооцох	7
Гурав. Төрийн байгууллагын зардлыг тооцох	7
3.1. Байгууллагын гүйцэтгэх үүрэг буюу ажил, үйлчилгээг тодорхойлох.....	7
3.2. Ажил, үйлчилгээг гүйцэтгэх хүний нөөцийг тодорхойлох.....	8
3.3. Гарах зардлыг урьдчилан тооцох.....	8Error! Bookmark not defined.
3.4. Зардлыг нэгтгэн тооцох.....	9
3.5. Хувилбарыг нягталж, үр дүнг танилцуулах.....	Error! Bookmark not defined.

АЖ АХУЙ НЭГЖИЙН ОРЛОГЫН АЛБАН ТАТВАРЫН ТУХАЙ ХУУЛИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХТЭЙ ХОЛБОГДОН ГАРАХ ЗАРДЛЫН ТООЦОО

Засгийн газрын 2016 оны 59 дүгээр тогтоолын 4 дүгээр хавсралтаар баталсан “Хууль тогтоомжийг хэрэгжүүлэхтэй холбогдон гарах зардлын тооцоог хийх аргачлал”-ын дагуу Аж ахуй нэгжийн орлогын албан татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг боловсруулж буйтай холбоотойгоор уг хуулийг хэрэгжүүлэхтэй холбоотой зардлын тооцоог боловсрууллаа.

Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн зорилт нь аж ахуйн нэгжийн орлогын албан татвар ногдуулах, уг албан татварыг төсөвт төлөх, тайлагнахтай холбогдсон харилцааг зохицуулах бөгөөд уг хуулийн харилцаанд оролцогч аж ахуйн нэгж болон татварын албатай холбоотой зардлыг тооцсон болно.

НЭГ. ХУУЛИЙН ЭТГЭЭДИЙН ЗАРДЛЫГ ТООЦОХ

1.Хуулийн этгээдийн зардлыг аргачлалд зааснаар дараах байдлаар тооцов.
Үүнд:

1.1. Хуулийн этгээдийн гүйцэтгэх үүргийг тогтоох:

Уг хуулийн төсөлд зааснаар хуулийн этгээд нь орлого, зардлаа тооцож албан татварын тайланг татварын өмнөх жилийн албан татвар ногдуулах орлогын хэмжээнээс хамаарч жилд 1-ээс 4 удаа гаргаж, тайлангаар ногдуулсан татварыг төсөвт төлөхөөр тусгасан.

Гүйцэтгэх үүрэг

- Санхүүгийн анхан шатны баримтуудыг бүрдүүлэх;
- Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тайлан, тодруулга, мэдээ болон хуульд заасан холбогдох бусад суутган татвартай холбоотой тайлан гаргах;
- Тайлангаар ногдуулсан аж ахуй нэгжийн орлогын албан татварыг төсөвт төлөх.

1.2. Зардлыг тооцох:

Зардлыг тооцохдоо аж ахуйн нэгжийн орлогын албан татварын 2024 оны тайлангийн үзүүлэлтэд үндэслэн борлуулалтын орлогын хэмжээгээр нь долоо ангилан тухайн ангилалд хамаарах аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуулийг хэрэгжүүлэх үүрэг бүхий албан хаагчийн тоог 1-5, үндсэн цалинг 1,000,000₮-3,500,000₮ байхаар сонгон авч тооцоонд ашиглав. Уг долоон ангиллын аж ахуйн нэгжүүдийн жигнэсэн дундаж үндсэн цалингийн хэмжээг тооцоход нэг аж ахуйн нэгжийн тайлан гаргах албан хаагчийн сарын үндсэн цалин 1,001,470 төгрөг байхаар байна.

Ажлын хөлс=Үндсэн цалин × Ажиллах хугацаа

/мянган төгрөг/

№	Үзүүлэлт	6.0 тэрбум.₮ дээш	2.5 -6.0 тэрбум	1.5-2.5 тэрбум	0.3-1.5 тэрбум	50-300 сая	50 сая хүртэл	бусад
1	Үндсэн цалин /сар/	3,500.0	3,000.0	2,700.0	2,500.0	2,100.0	1,500.0	1,000.0
2	Ажиллах хугацаа /цаг/	24.4	24.4	11.8	10.3	8.2	5.8	1.2
3	Ажлын хөлс	508.3	435.7	189.6	153.3	102.5	51.8	7.1

Үйл ажиллагааг хэрэгжүүлэх хугацаа:

Аж ахуйн нэгжүүдийг борлуулалтын орлогоос нь хамааруулан 7 ангилан тухайн ангилалд багтах аж ахуйн нэгжүүдийн үйл ажиллагааг хэрэгжүүлэх хугацааг аргачлалын хүснэгт 1-д тодорхойлсон загварын дагуу доорх байдлаар тодорхойлов.

/ААН-үүдийн үйл ажиллагааг хэрэгжүүлэх хугацаа/

№	Ерөнхий үйл ажиллагаа	6.0 тэрбум.₮ дээш	2.5 -6.0 тэрбум.₮	1.5-2.5 тэрбум.₮	0.3-1.5 тэрбум.₮	50-300 сая.₮	50 сая.₮ хүртэл	бусад
1	Үүрэгтэй танилцах, судлах	120	120	15	15	15	15	15
2	Мэдээлэл цуглуулах	120	120	120	30	30	15	3
3	Маягт бөглөх, гарчиглах, тэмдэглэх	3	3	7	7	7	7	7
4	Тооцоо хийх	120	120	120	120	20	20	3
5	Мэдээлэл, өгөгдөхүүнийг нягтлах	45	45	45	45	45	45	5
6	Алдааг засах	2	2	10	10	10	10	2
7	Тоо баримтыг боловсруулах	120	120	120	120	120	15	3
8	Мэдээлэл шилжүүлэх болон нийтлүүлэх	10	10	10	10	10	10	10
9	Дотоод хуралдаан (зөвлөгөөн)	480	480	30	30	30	5	
10	Бусадтай хамтран хийх хуралдаан (зөвлөгөөн)	60	60	60	60	10	10	
11	Мөнгө шилжүүлэх үүрэг хэрэгжүүлэх	8	8	8	8	30	30	
12	Олшруулах, архивлах, тараах	15	15	15	15	15	15	2
13	Төрийн захиргааны байгууллагаас шалгах	240	240	30	30	30	30	2
14	Төрийн захиргааны байгууллагын шалгалтын дүнгээс үүдэлтэй засвар, өөрчлөлт	90	90	90	90	90	90	3
15	Холбогдох байгууллагатай харилцахад хүндрэл үүссэнээс үүдэн мэдээлэл нэмж цуглуулах	15	15	15	15	15	15	3
16	Сургалт, давтан сургалтын арга хэмжээнүүд	15	15	15	15	15	15	15
Нийт дүн /цагаар/		24.4	24.4	11.8	10.3	8.2	5.8	1.2

Үйл ажиллагааг хэрэгжүүлэх хугацаа нь аж ахуйн нэгжүүдийн хэмжээнээс хамааран харилцан адилгүй 1.2-24.4 цаг байхаар байна. Нийт аж ахуйн нэгжүүдийн жигнэсэн дунджаар нэг аж ахуйн нэгж үйл ажиллагааг хэрэгжүүлэхэд 265 минут буюу 4.42 цагийг зарцуулахаар байна.

Зардал (ҮА тус бүрийн)=Хугацаа × Ажлын хөлс

/мянган төгрөг/

№	Ерөнхий үйл ажиллагаа	6.0 тэрбум.₮ дээш	2.5 -6.0 тэрбум.₮	1.5-2.5 тэрбум.₮	0.3-1.5 тэрбум.₮	50-300 сая.₮	50 сая.₮ хүртэл	бусад
1	Ажлын хөлс /сар/	3,500.0	3,000.0	2,700.0	2,500.0	2,100.0	1,500.0	1,000.0
2	Үйл ажиллагааг хэрэгжүүлэх хугацаа /цаг/	24.4	24.4	11.8	10.3	8.2	5.8	1.2
3	Зардал /сар/	508.3	435.7	189.6	153.3	102.5	51.8	7.1

Аж ахуйн нэгжийн борлуулалтын орлогын хэмжээнээс нь хамааруулан тухай аж ахуйн нэгжүүдийн зардлын хэмжээг тооцоход 7.1-508.3 мянган төгрөг байх бөгөөд жигнэсэн дунджаар нэг аж ахуй нэгжийн зардал 12,923.8 төгрөг байхаар байна.

1.3. Тоон үзүүлэлтийг тооцох:

Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тайлан ирүүлбэл зохих 215,522 хуулийн этгээд байх бөгөөд 2024 онд нийт хуулийн этгээдийн 82.0 хувь буюу 176,637 хуулийн этгээд тайлан ирүүлсэн.

Нийт тайлан ирүүлбэл зохих аж ахуйн нэгжүүдийг жилийн татвар ногдуулах орлогоор нь авч үзвэл 6.0 тэрбум төгрөгөөс дээш орлоготой 317 аж ахуй нэгж, 50 сая төгрөгөөс 6 тэрбум төгрөг хүртэл орлоготой 54,062 аж ахуйн нэгж, 50 сая төгрөг хүртэл орлоготой 47,688 аж ахуйн нэгж, бусад 74,570 аж ахуйн нэгж байна.

Тоон үзүүлэлт=Тохиолдлын тоо × Давтамжийн тоо

Ангилал	Тоон үзүүлэлт	Тохиолдлын тоо	Давтамжийн тоо
2.5 тэрбумаас дээш	1,268	317	4
	13,148	6,574	2
1.5-2.5 тэрбум.₮	6,562	3,281	2
0.3-1.5 тэрбум.₮	35,954	17,977	2
50-300 сая.₮	52,460	26,230	2
50 сая.₮ хүртэл	95,376	47,688	2
Бусад	74,570	74,570	1
Нийт дүн	279,338	176,637	

1.4. Нийт зардлын дүнг тооцох:

Нийт зардал = Зардал × Тоон үзүүлэлт

3,613,544,240.0₮=12,933.8₮ × 279,338

Одоогийн Аж ахуй нэгжийн орлогын албан татварын тухай хуулиар бүх аж ахуй нэгжүүд сегментийн ангиллаас хамааран нэг тайлангийн маягтаар жилд 1-4 удаа тайлагнадаг бөгөөд Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тайлан гаргах татвар төлөхтэй холбоотой нийт зардлын хэмжээ Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тайлан ирүүлсэн 176,637 аж ахуйн нэгжийн хувьд 2,284.6 сая төгрөг, нийт

тайлан ирүүлбэл зохих 215,522 аж ахуйн нэгжийн хувьд 3,613.5 сая төгрөг байхаар байна.

Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөлд тайлагналын тоог хэвээр үлдээсэн, хялбаршуулсан тайлан ирүүлэх татвар төлөгчийн тоог нэмэгдүүлсэнтэй холбоотойгоор 300-400 сая төгрөгийн борлуулалтын орлоготой 2,338 татвар төлөгч хялбаршуулсан горимд шилжих, тайлан ирүүлэх давтамж буурснаар Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тайлан гаргах татвар төлөхтэй холбоотой зардал 30.2 сая төгрөгөөр буурахаар байна.

1.5. Хялбарчлах боломж:

Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын хуульд нэмэлт, өөрчлөлт оруулахтай холбоотойгоор татвар төлөгч хуулийн этгээдийг үүрэгжүүлсэн татвар төлөгчийн бүртгэл хийлгэх, татварын хяналт шалгалтад хамруулахтай холбоотой хувь хүний зүгээс гарах зардлыг бууруулах боломжийг дараах шалгууруудаар тодорхойлжээ. Үүнд:

а) Хамрагдах хуулийн этгээдийн тоог багасгах боломж байгаа эсэх:

Татварын ерөнхий хууль болон Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуульд зааснаар тухайн татварын төрлөөр бүртгүүлэх шаардлагатай хуулийн этгээдүүдийг Улсын бүртгэлд бүртгүүлсэн тухай бүр татварын алба нь бүртгэх байгууллагын мэдээлэлд үндэслэн цахимаар шууд бүртгэж Аж ахуй нэгжийн орлогын албан татварын тухай хуульд заасан үүргүүдийг хүлээлгэж байгаа нь шинээр бүртгүүлсэн хуулийн этгээдийн тоогоор хууль тогтоомжийг биелүүлж ажиллах, төсвийн орлогыг нэмэгдүүлэх боломжтой.

б) Мэдээллийн агуулга, давтамжийг багасгах боломж байгаа эсэх:

Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хууль нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөлд хялбаршуулсан тайлан ирүүлэх татвар төлөгчийн тоог нэмэгдүүлсэнтэй холбоотойгоор 300-400 сая төгрөгийн борлуулалтын орлоготой 2,338 татвар төлөгч хялбаршуулсан горимд шилжсэнээр тайлан ирүүлэх давтамж буурч Аж ахуй нэгжийн орлогын албан татварын тайлан гаргах татвар төлөхтэй холбоотой зардал 30.2 сая төгрөгөөр буурахаар байна.

в) Шинээр үүсэх үүргийг урьд байсан үүрэгтэй нэгтгэж болох эсэх;

Хуулийн төсөлд татвар төлөгч хуулийн этгээдэд шинээр үүрэг хүлээлгээгүй бөгөөд татварын хялбаршуулсан горимтой холбоотойгоор холбогдох хуулийн этгээдийн үүрэг буурна.

г) Мэдээллийг цахимаар хүргүүлэх боломжтой эсэх;

Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тайланг цахимаар болон цаасан хэлбэрээр тайлагнах боломжтой бөгөөд 2024 оны байдлаар нийт тайлан тушаасан хуулийн этгээд 100 хувь нь цахимаар тайлан тушаасан байна.

1.6. Нэмэлт зардлыг тооцох.

Хуулийн төсөлд хуулийн этгээдэд нэмж үүрэг хүлээлгээгүй бөгөөд аливаа нэмэлт зардал гарахгүй болно.

Аж ахуйн нэгжийн зүгээс хуулийг хэрэгжүүлэхтэй холбоотойгоор холбогдох албан хаагчид гаргах материаллаг зардлын хэмжээг аж ахуйн нэгжүүдийн татвар ногдуулах орлогын хэмжээнээс нь хамааруулж долоо ангилан тодорхойлсон.

№	Үзүүлэлт	6.0 тэрбум.₮ дээш	2.5 -6.0 тэрбум.₮	1.5-2.5 тэрбум.₮	0.3-1.5 тэрбум.₮	50-300 сая.₮	50 сая.₮ хүртэл	бусад
1	Материаллаг зардал /ажлын байрны төлбөр, эд хөрөнгийн элэгдэл, бичиг хэрэг, тоног төхөөрөмж, цахилгаан, дулаан, ус гэх мэт/	14.1 сая.₮	11.3 сая.₮	7.1 сая.₮	5.7 сая.₮	2.3 сая.₮	1.1 сая.₮	0.3 сая.₮
2	Үйл ажиллагааг хэрэгжүүлэх хугацаа /цаг/	24.4	24.4	11.8	10.3	8.2	5.8	1.2
3	Зардал /жил/	2.05 сая.₮	1.64 сая.₮	0.5 сая.₮	0.35 сая.₮	0.11 сая.₮	0.04 сая.₮	0.0021 сая.₮
4	Хуулийн этгээдийн тоо	317	6,574	3,281	17,977	26,230	47,688	74,570
5	Ангилал бүрийн нийт зардал	649.17 сая ₮	10,789.19 сая ₮	1,636.20 сая ₮	6,282.32 сая ₮	2,944.63 сая ₮	1,811.01 сая ₮	159.79 сая ₮
Нийт материаллаг зардал		24,272.31 сая төгрөг						

ХОЁР. ИРГЭНИЙ ЗАРДЛЫГ ТООЦОХ

Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн зорилт нь аж ахуйн нэгжийн орлогын албан татвар ногдуулах, уг албан татварыг төсөвт төлөх, тайлагнахтай холбогдсон харилцааг зохицуулах бөгөөд уг хуулиар иргэнийг үүрэгжүүлсэн аливаа зохицуулалт байхгүй бөгөөд тус хуулийн нэмэлт өөрчлөлтийн төсөлтэй холбоотойгоор иргэнээс зардал гарахгүй болно.

ГУРАВ.ТӨРИЙН БАЙГУУЛЛАГЫН ЗАРДЛЫГ ТООЦОХ

Төрийн байгууллагын зардал буюу улсын төсөвт үүсэх ачааллыг дараах байдлаар тооцов. Үүнд:

3.1.Байгууллагын гүйцэтгэх үүрэг буюу ажил, үйлчилгээг тодорхойлох:

- Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тайлан холбогдох бусад суутган тайлан, мэдээ, тодруулгыг татвар төлөгчөөс хүлээн авч хянаж, шаардлагатай тохиолдолд холбогдох өөрчлөлтийг татвар төлөгчөөр залруулга хийлгүүлэн тайлан,мэдээг хүлээн авах;
- Аж ахуйн нэгжийн орлогын албан татварыг хураах.

3.2. Ажил, үйлчилгээг гүйцэтгэх хүний нөөцийг тодорхойлох;

Хуулийг хэрэгжүүлэх хүний нөөцийн хэрэгцээг албан хаагчдын ажлын байрны тодорхойлолтод заасан чиг үүрэг, тайлан хүлээн авах, татвар хураах үүргийг гүйцэтгэх чиг үүрэг бүхий албан хаагчдын тоо зэрэг хүний нөөцийн 2024 оны мэдээлэлд үндэслэн тооцоход 893 хүн/жил буюу нийт албан хаагчдын 48.7 хувь хуулийг хэрэгжүүлэхэд нийт ажлын цагаа зарцуулсан байх бөгөөд хүний нөөцийн хэрэгцээ нэмэх шаардлагагүй байна.

Хүний нөөцийн хэрэгцээ = Тоо (баримжаагаар)

Хүний нөөцийн хэрэгцээ = 893

Хуулийн төсөлд Аж ахуй нэгжийн орлогын албан татварын тайлагналын тоог жилд 1-4 удаа байсныг хялбаршуулсан горимд шилжих татвар төлөгчийн тоог нэмэгдүүлснээр татварын албаны үйл ажиллагааг хялбарчлаж байна. Мөн татварын өр хураах үйл ажиллагаа гүйцэтгэлийн бие даасан эрх мэдлийг хэрэгжүүлэх хуулийн зохицуулалтад татвар төлөгчийн үйл ажиллагааг хэвийн явуулах, татвар төлөгчийг дэмжсэн нэмэлт, өөрчлөлтийн саналыг Татварын ерөнхий хуульд оруулахаар хуулийн төслийг боловсруулсан нь татварын албаны үйл ажиллагааны зардлыг нэмэгдүүлэхээр байна.

Хуулийн төсөлд тусгасан татварын албаны үйл ажиллагааг хөнгөвчилсөн болон шинээр хэрэгжүүлэх эрхтэй холбоотойгоор хуулийг хэрэгжүүлэх албан хаагчдын ажил үүргийн хуваарьт дотоод зохицуулалт хийж, хүний нөөцийн хэмжээг нэмэгдүүлэхгүйгээр одоогийн түвшинд буюу тухайн хуулийг хэрэгжүүлэхтэй холбоотойгоор ажиллаж буй 893 албан хаагчтайгаар ажиллах боломжтой. Энэ нь татварын албаны нийт ажиллагсдын 48.7%-ийг эзэлж байна.

3.3. Гарах зардлыг урьдчилан тооцох;

Татварын албаны зүгээс дотоод зохион байгуулалт хийж хүний нөөцийн болон бусад материаллаг зардлыг нэмэгдүүлэхгүйгээр одоогийн түвшинд барьж ажиллах боломжтой.

-Хүний нөөцийн цалингийн зардал:

Албан хаагчийн үндсэн цалингийн хэмжээг дунджаар дараах байдлаар тооцсон.

Үндсэн цалин төрийн захиргааны албан тушаалын цалингийн сүлжээний ТЗ-7 зэрэглэлийн шатлалаар 1,539,000₮;

Төрийн алба хаасан хугацааны нэмэгдлийг, төрийн албанд 11-15 жил ажилласан гэж үзэж 10%-ийн нэмэгдэл олгохоор;

Зэрэг дэвийн хувьд гутгаар зэргийн дэс түшмэл гэж үзэж 17%-ийн нэмэгдэл олгохоор.

Цалингийн зардал = (үндсэн цалинг + нэмэгдлүүд)

$1,954,530.7₮/\text{сар} = 1,539,000₮ + 1,539,000₮ * 10\% + 1,539,000₮ * 17\%$

$1,954,530.7₮/\text{сар} \times 12 \text{ сар} = 23,454.360.0₮/\text{жил}$

Ажил олгогчоос төлөх эрүүл мэндийн даатгал, нийгмийн даатгалын шимтгэл $2,931,795₮ = 23,454.360.0₮ \times 12.5\%$

Нийт цалинтай холбоотой зардал $26,386,155₮ = 23,454.360.0₮ + 2,931,795₮$

Хуулийн төслийг хэрэгжүүлэхтэй холбоотойгоор төрийн байгууллагын зүгээс цалин, эрүүл мэндийн даатгал, нийгмийн даатгалын шимтгэлтэй холбоотойгоор Татварын удирдлагын нэгдсэн системд бүртгэлтэй 54 татварын төрлөөс Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын хуульд хамаарах 4 татварын төрлийн

хэрэгжилтийг хангуулахаар тооцвол, дунджаар нэг албан хаагчийн цалинтай холбоотойгоор 1.96 сая төгрөгийн зардал гаргахаар байна.

Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын хуулийн хэрэгжилтийг хангуулах нэг албан хаагчид ногдох цалингийн зардлыг тооцож үзвэл:

$$1,954,530.00\text{₮}=26,386,155\text{₮} / 54 * 4$$

-Материаллаг зардал:

Татварын алба 2024 онд 1,834 албан хаагчтайгаар үйл ажиллагаа явуулсан бөгөөд шинээр 3 татварын албаны байрыг шинээр ашиглалтад оруулсан, тоног төхөөрөмж, компьютер, тоног төхөөрөмжийн худалдан авалтын шинэчлэл хийснээр ажлын байртай холбоотой нийт 67,708.9 сая төгрөгийн зардал гарсан байна.

Нэг албан хаагчид ногдох материаллаг зардлыг тооцож үзвэл:

$$67,708.9 \text{ сая } \text{₮} / 1834 = 36,918,702.3\text{₮}$$

Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын хуулийн хэрэгжилтийг хангуулах нэг албан хаагчид ногдох материаллаг зардлыг тооцож үзвэл:

$$2,734,718.69\text{₮}=36,918,702.3\text{₮}/54 * 4$$

-Бусад зардал

Татварын албаны жилийн төсөвт зардлаас цалин хөдөлбөрийн хөлстэй холбоотой зардлыг цалингийн зардал хэсэгт, үлдэх зардлыг материаллаг зардал тооцоход хамруулан тооцсон тул хуулийг хэрэгжүүлэхтэй холбоотой төсөвт зардлаас илүү гарах бусад зардал гарахгүй болно.

3.4. Зардлыг нэгтгэн тооцох;

Нийт зардал = (хүний нөөцийн зардал + материаллаг зардал + бусад зардал) × хүний нөөцийн хэрэгцээ

$$4,187,499,078.52\text{₮} = (1,954,530.00\text{₮}+2,734,718.69\text{₮}+0) \times 893$$

Хуулийг хэрэгжүүлэхэд төрийн байгууллага буюу татварын албаны зүгээс 893 хүний нөөцөд тулгуурлан нийт 4,187.5 сая төгрөгийн зардал гаргахаар байна.

3.5. Хувилбарыг нягталж, үр дүнг танилцуулах.

Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөлд тусгасан зохицуулалттай холбоотойгоор хуулийн этгээдийн орлогын хэмжээнээс хамааруулан хялбаршуулсан тайлангийн маягтаар тайлагнах, тайлагналын тоог бууруулсан зэрэг зохицуулалтыг шинээр тусгасан нь уг хуулийн харилцаанд оролцогч хуулийн этгээдийн хувьд татварын тайлагналтай холбоотой зардал буурна. Мөн 25 хувиар татвар ногдуулах орлогын босго 10 тэрбум төгрөг болж нэмэгдсэнтэй холбоотойгоор хуулийн этгээдүүдийн татварын ачааллын хэмжээ 110.2 тэрбум төгрөгөөр буурахаар байна.

--oo00oo--